



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.05.01 № 35-1/71
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай**

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000244001837



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.05.01 № хэрг/884
танай _____-ны № _____-т


**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай**

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 157 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлд:


“2.ХЭЛЭЛЦСЭН нь: Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд, Засгийн газрын гишүүдийн саналыг тусгасны үндсэн дээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.




ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН САЙД, НИЙСЛЭЛ
УЛААНБААТАР ХОТЫН АВТО
ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА


Б.ДЭЛГЭРСАЙХАН


БАТЛАВ.
САНГИЙН САЙД


Б.ЖАВХЛАН

БАТЛАВ.
БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД


Ц.ДАВААСҮРЭН

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, Э
ДОНООД ХЭРГИЙН САЙД


Б.ЗЭНХБАЯР

ШИНЭ ЗУУНМОД ХОТЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т “Нийслэл хот нь дагуул хоттой байна” гэж, 34 дүгээр зүйлийн 34.1-д “Нийслэл хотын дагуул хот нь нийслэл хоттой эдэлбэр газар, хүн ам, эдийн засаг, дэд бүтэц, тээвэр, логистикийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, газар зүйн байрлал болон нийслэл хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэхэд стратегийн ач холбогдолтой, хот бүрдүүлэгч дэд бүтэц бүхий төвлөрсөн суурин газар мөн.” гэж, 34.2-т “Дагуул хотыг нийслэлийн болон бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид, эсхүл хэд хэдэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид дамнан байгуулж болно.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 9.5-д “Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ.” гээд 9.5.2-т ““Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, инженерийн шугам сүлжээ, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.” гэж, 9.5.3-т “Хөшигийн хөндийд байрлах олон улсын нисэх онгоцны буудлыг даган байгуулагдах “Шинэ Зуунмод” шинэ хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ.” гэж, 9.5.6-д “Зарим их, дээд сургуулийг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж, дагуул хотуудад хотхон байгуулан шилжүүлэх замаар хотын төвлөрлийг сааруулна.” гэж, 9.3.4-д “Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу нийслэл болон дагуул, хаяа хот, тосгоны инженерийн дэд бүтцийг үе шаттай барьж байгуулан өргөтгөж шинэчилнэ.” гэж тус тус заасан.

хаяа хот, тосгоны инженерийн дэд бүтцийг үе шаттай барьж байгуулан өргөтгөж шинэчилнэ.” гэж тус тус заасан.

Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д хотыг шинээр байгуулах шийдвэр гаргах, нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэхээр, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 35.1-д дагуул хотыг стратегийн ач холбогдол бүхий нөхцөлийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал байгуулахаар тус тус заасан.

1.2.Практик шаардлага

Улаанбаатар хотыг хөгжүүлэх урт хугацааны анхдугаар хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 1954 онд батлагдаж, 1961, 1976, 1986 онуудад тодотгол, шинэчлэл хийгдэж байсан ба манай улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орсноос хойш Улаанбаатар хотыг 2000-2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байсан ба Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичгийг баталж, Улаанбаатар хот нийт 15 дагуул хот, тосгонтой байхаар төлөвлөсөн боловч дагуул хотыг хэрхэн байгуулах, бүтэц зохион байгуулалт нь ямар байх талаар ерөнхий зохицуулалттай, тухайн хотын онцлогт тохирсон нарийвчилсан зохицуулалтгүйгээс тодорхой үр дүнд хүрээгүй боловч дагуул хот байгуулах хэрэгцээ, шаардлага байгааг дараах тоо баримтаас харж болно.

Өөрөөр хэлбэл, Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь манай улсын нийт газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг хэдий ч хүн ам, их, дээд сургууль, коллеж, бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ зэрэг үзүүлэлтээр тогтмол Улсын хэмжээнд тэргүүлж жил бүр энэ үзүүлэлтийн тоо хэмжээ өссөөр байна. Эдгээр үзүүлэлтийг 2024 оны 2 дугаар сарын байдлаар авч үзвэл:

- Нийслэлд байнга оршин суугчдын тоо 1,730,263 буюу манай улсын нийт хүн амын 49 хувь;

- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо 172,159 буюу манай улсад бүртгэлтэй нийт аж ахуйн нэгжийн 74.7 хувь;

- 2023 оны дүнгээр нийслэлийн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 43.3 их наяд төгрөг буюу улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 63 хувийг тус тус бүрдүүлж байна.

Ийнхүү нийслэл Улаанбаатар хотын хүн амын тоо эрчимтэй өсөж, үйл ажиллагаа идэвхжихийн хирээр төлөвлөлтгүй суурьших, байгаль орчин доройтох, хог хаягдал, орчны бохирдол нэмэгдэх, гэмт хэрэг, зөрчил ихсэх, замын хөдөлгөөний түгжрэл үүсэх зэрэг олон асуудлын улмаас нийслэл хотын эдийн засаг, нийгмийн харилцаанд хүндрэл учирч, иргэдийн ая тухтай, эрүүл, аюулгүй амьдрах эрх зөрчигдөхөд хүрч байна.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04”-ийн 2.14-т заасан хүн амын тооцоот нягтрал 1 га газарт 450 байх хязгаарыг давсан Нийслэлийн 6 дүүргийн 111 байршил,

1044 га газарт инженерийн болон нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн зам, талбай барихаас бусад зориулалтаар, шинээр газар эзэмших, ашиглах эрх, барилга байгууламж барих зөвшөөрөл олгохгүй байх зэрэг шийдвэрийг гаргасан боловч иргэдийн эрүүл, аюулгүй, тав тухтай орчныг бүрдүүлэх, шинжлэх ухааны хөгжил, цаг үеийн өөрчлөлт, ирээдүйн хотжилтын чиг хандлагад нийцүүлэн тулгамдсан асуудлаа өөрийн онцлогт тохируулан шийдвэрлэх шаардлага тавигдаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 55 дугаар тогтоолоор Нийслэл Улаанбаатар хотын хүн амын хэт төвлөрөл, хүрээлэн байгаа орчинд үзүүлж буй агаар, ус, хөрсний бохирдол, сөрөг нөлөөг бууруулах, олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн эдийн засгийн тодорхой салбаруудыг тогтвортой хөгжлийн зорилтод нийцүүлэн хөгжүүлэх, хүн амыг эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлалыг дэмжих зорилгоор Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт орон нутгийн зэрэглэлтэй "Шинэ Зуунмод" хотыг шинээр байгуулсан боловч өнөөг хүртэл тус хотын засаг захиргаа, удирдлагын тогтолцоо тодорхойгүй, хотын бүтээн байгуулалтын ажил зогсонги байдалтай байна.

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны 9.5.2, 9.5.3-т Хөшигийн хөндийд байрлах олон улсын нисэх онгоцны буудлыг даган байгуулагдах "Шинэ Зуунмод" шинэ дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, инженерийн шугам сүлжээ, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд тус үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах хүрээнд Шинэ Зуунмод хотыг нийслэлийн дагуул хотын статустайгаар эрх зүйн байдлыг хуулиар тусгайлан тодорхойлох шаардлагатай байна.

Ингэхдээ Төв аймагтай бүх талаар хөгжлийн интеграцид орж хотын эдийн засгийн үр ашгийг хамт хүртэх нөхцөл боломжийг бүрдүүлж бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах нь чухал юм. Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон зайн оновчтой төлөвлөлт бүхий дагуул хот байгуулах, түүний эрх зүйн байдлыг тогтоох, хотын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасныг үндэслэн Улаанбаатар хотын төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр дагуул хот байгуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзэж анхдагч хуулийн төсөл боловсруулна.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн зорилго нь бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон зайн оновчтой төлөвлөлт бүхий дагуул хот байгуулах зорилтын хүрээнд Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлыг тогтоож, хотын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тогтвортой хөгжлийг дэмжих бодлогыг тодорхойлоход оршино. Хуулийн төсөлд дараах асуудлыг тусгана:

Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл буюу хуулийн зорилго, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хотын эрх

зүйн үндэс, байршил, эдэлбэр газар, хотыг хөгжүүлэх үйл ажиллагааны зарчим зэрэг асуудлыг тусгана.

Хоёрдугаар бүлэгт хот байгуулалтын үйл ажиллагаа буюу Шинэ Зуунмод хотын төлөвлөлт, бүсчлэл, газрын менежменттэй холбоотой зохицуулалтыг тусгана.

Шинэ Зуунмод хот нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй байх ба нийслэл хотын болон Төв аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан байна.

Шинэ Зуунмод хотын газар зохион байгуулалт нь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон хотыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд үндэслэнэ.

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу нийгмийн болон инженерийн суурь дэд бүтцээс бусад зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглах эрх олгох асуудлыг зөвхөн төсөл сонгон шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ.

Гуравдугаар бүлэгт Шинэ Зуунмод хотын зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог тодорхойлж, хотын чиг үүргийг тогтоож, тус хотын Зөвлөл, Захирагч, Ерөнхий архитектор, хотын хөгжлийн корпораци, тэдгээрийн ажлын албаны үйл ажиллагаа, бүрэн эрхийн талаар тусгана.

Шинэ Зуунмод хотын удирдлагын тогтолцоо нь хотын Зөвлөл, хотын Захирагч, хотын ерөнхий архитектороос бүрдэх ба сонгуулийн болон сонгон шалгаруулалтын журмаар байгуулагддаг, томилогддог байх зарим баримтална.

Шинэ Зуунмод хотын нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого тодорхойлох, хотын чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх үүргийг Шинэ Зуунмод хотын Зөвлөл хэрэгжүүлэх ба хотын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлж зохион байгуулах үүргийг хотын Захирагч, хот байгуулалт, газар зохион байгуулалт, төлөвлөлт, хөгжүүлэлтийн чиг үүргийг хотын ерөнхий архитектор хэрэгжүүлнэ.

Дөрөвдүгээр бүлэгт Шинэ Зуунмод хотын эдийн засгийн үндсийг тодорхойлж, хотын эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хотын эдийн засагт төр, нийслэл, Төв аймгаас үзүүлэх дэмжлэг, туслалцаа, хотын төсөв, өмч, дэд бүтцийг хөгжүүлэх сантай холбоотой үүсэх харилцаа, зохицуулалтыг тусгана.

Шинэ Зуунмод хотын эдийн засгийн үндэс нь улс, нийслэл, орон нутаг, хотын өөрийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө, түүнчлэн хотын өмч, татварын болон татварын бус орлого, хотын сангийн хөрөнгө, гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүсийн хандив, тусламж, бусад орлогоос бүрдэнэ.

Шинэ Зуунмод хот төсөвтэй байх бөгөөд нийслэлийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна. Хотын төсвийн орлогын тодорхой хувийг Төв аймгийн төсөвт хуваарилна.

Тавдугаар бүлэгт Шинэ Зуунмод хотын бизнесийн орчин, хөрөнгө оруулалт, түүний баталгаа, хотын бүтээн байгуулалтад үзүүлэх дэмжлэгийн талаар тусгана.

Шинэ Зуунмод хотод хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ нь Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан шалгуур хангасан тохиолдолд хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамаарч тогтворжуулалтын гэрчилгээг олгоно.

Шинэ Зуунмод хот дахь төрийн үйлчилгээ нь худалдаа, , хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх бүртгэл, зөвшөөрлийн цахим нэг цонхны үйлчилгээнд суурилна.

Зургаадугаар бүлэгт Шинэ Зуунмод хотын удирдлагаас бусад этгээдтэй харилцах болон хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох талаар тусгана.

Шинэ Зуунмод хотын удирдлага нь Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй нийслэлийн Засаг даргаар дамжуулж харилцах ба хотыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж болох бөгөөд энэ харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл батлагдсанаар дараах нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар гарна. Үүнд:

- нийслэл хотын төвлөрлийг задалж, нийслэл хотын түгжрэл, агаар, хөрсний бохирдол, орон сууцны хангамж, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэхэд эерэг нөлөө үзүүлнэ;

- Төв аймагтай эдийн засгийн интеграцид орж, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангана;

- орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой дагуул хотыг хөгжүүлж, бүтээн байгууллалтын үйл ажиллагааны журам, зохицуулалт тодорхой болно;

- дагуул хотын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтад дэмжлэг үзүүлнэ;

- нийгмийн болон инженерийн дэд бүтцийн төвлөрсөн хангамж бий болж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг кластераар хөгжүүлж улс, нийслэл, төв аймаг цаашлаад бүс нутгийн нийгэм, эдийн засгийг дэмжих, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ;

- шинээр ажлын байр бий болж, дотоодын нийт бүтээгдэхүүн, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ;

- орон сууцжуулах төсөл хэрэгжүүлж орон сууцны хангамж нэмэгдэж, нийслэлээс иргэд шилжин суурьших, төрийн байгууллага, их дээд сургууль, коллеж, шинжлэх ухааны байгууллагуудыг нүүлгэх нөхцөлийг бүрдүүлнэ;

- тээвэр ложистикийн нэгдсэн төвийг байгуулж, хөгжүүлснээр орон нутгийн болон бүс нутаг цаашлаад олон улсын логистикийг сайжруулна;

- иргэдийн аятай таатай амьдрах орчин бий болж, амьдралын чанар сайжирна;

- Шинэ Зуунмод хот дүрэмтэй болж хууль тогтоомжоор зохицуулагдаагүй хотын амьдрал, үйл ажиллагаатай холбоотой асуудлаа оршин суугчид, иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэх боломжтой болно.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай зэрэг холбогдох шаардлагатай бусад дагалдах хуулийн төслүүд болон “Хот байгуулах тухай”, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.

---o0o---

ШИНЭ ЗУУНМОД ХОТЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх” гэж, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлж, хүний аюулгүй байдлыг хангах” төрийн үүргийг тодорхойлсон.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 9-д “Улаанбаатар хотыг Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлэх” зорилгыг дэвшүүлж, түүнийг хэрэгжүүлэх зорилт, үе шат, хүрэх үр дүнг дараахи байдлаар тодорхойлсон. Үүнд:

Зорилт 9.3.Орон зайн оновчтой төлөвлөлт, суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж байгаа дагуул хотуудтай, олон улсад өрсөлдөгч метрополитан хот болж хөгжинө:

- 9.3.6.Зарим их, дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар нь дагуул хотуудад кампус байгуулж шилжүүлэх замаар хотын төвлөрлийг сааруулна;

- 9.3.46.Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу нийслэл болон дагуул, хаяа хот, тосгоны инженерийн дэд бүтцийг үе шаттай барьж байгуулан өргөтгөж шинэчилнэ.

Зорилт 9.5.Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд Азийн тээвэр, логикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ:

- 9.5.1.Дагуул, хаяа хот, тосгоныг тус бүрд нь худалдаа, үйлчилгээ, боловсрол, соёл, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлалын чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулна;

- 9.5.2.“Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, инженерийн шугам сүлжээ, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ;

- 9.5.3.Хөшигийн хөндийд байрлах олон улсын нисэх онгоцны буудлыг даган байгуулагдах “Шинэ Зуунмод” шинэ хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ;

- 9.5.5.Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг нэгдсэн бодлого төлөвлөлттэйгөөр дагуул хотуудад шилжүүлэн үйл ажиллагааг нь дэмжин ажиллана;

- 9.5.10.Улаанбаатар хотын бүсийн хэмжээнд өндөр технологийн үйлдвэрүүдийг нутагшуулж, дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжтой эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулна.

Мөн түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 9.5.4-т "дагуул хотуудад дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 6.1-д "Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ", 6.2.1-д "Төвлөрлийг сааруулах бодлогыг Улаанбаатар хотын удирдлагатай хамтарч үндэсний хэмжээнд цогц байдлаар хэрэгжүүлнэ" гэж тус тус заасан.

Дээр дурьдсан хууль тогтоомжид нийцүүлэн Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 130 дугаар тушаалаар батлагдсан БНБД 30-01-02-21 баримт бичгийн 4.12.5-д Нийслэл хот болон бүсийн тулгуур төв хот тухайн хотын хүн амын амралт, сувилал, хүнсний болон бусад хангамж, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах тодорхой үүрэг бүхий дагуул, хаяа хот, тосгонтой байхаар тусгагдсан.

Улаанбаатар хотыг хөгжүүлэх урт хугацааны анхдугаар хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 1954 онд батлагдаж, 1961, 1976, 1986 онуудад тодотгол, шинэчлэл хийгдэж байсан ба манай улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орсноос хойш Улаанбаатар хотыг 2000-2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байсан ба Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага"-ын баримт бичгийг баталж, Улаанбаатар хот нийт 15 дагуул хот, тосгонтой байхаар төлөвлөсөн боловч дагуул хотыг хэрхэн байгуулах, бүтэц зохион байгуулалт нь ямар байх талаар ерөнхий зохицуулалттай, тухайн хотын онцлогт тохирсон нарийвчилсан зохицуулалтгүйгээс тодорхой үр дүнд хүрээгүй боловч дагуул хот, тосгон байгуулах хэрэгцээ шаардлага байгааг дараах тоо баримт харуулж байна.

Тухайлбал, Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь манай улсын нийт газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг хэдий ч хүн ам, их дээд сургууль, коллеж, бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ зэрэг үзүүлэлтээр тогтмол Улсын хэмжээнд тэргүүлж жил бүр энэ үзүүлэлтийн тоо хэмжээ өссөөр байна. Эдгээр үзүүлэлтийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар авч үзвэл:

- Нийслэлд байнга оршин суугчдын тоо 1,596,335 буюу манай улсын нийт хүн амын 47.4% хувьтай;

- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо 175,200 буюу манай улсад бүртгэлтэй нийт аж ахуйн нэгжийн 74.7 хувьтай;

- нийслэлийн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 33.8 их наяд төгрөг буюу үндэсний дотоодын нийт бүтээгдэхүүний 69.2 хувьтай тус тус тэнцэж байна.

Ийнхүү нийслэл Улаанбаатар хотын хүн амын тоо эрчимтэй өсөж, үйл ажиллагаа идэвхжихийн хирээр төлөвлөлтгүй суурьших, байгаль орчин доройтох, хог хаягдал, дуу чимээ нэмэгдэх, гэмт хэрэг, зөрчил ихсэх, замын хөдөлгөөний түгжрэл үүсэх зэрэг олон сөрөг асуудлын улмаас нийслэл хотын эдийн засаг,

нийгмийн харилцаанд хүндрэл учирч, иргэдийн ая тухтай амьдрах эрх зөрчигдөж байгаа тул дээрх асуудлуудыг шийдвэрлэх, тухайлбал, Улаанбаатар хотын төвлөрлийг задалж, дэд бүтцийг тэлэх, дагуул хотуудыг байгуулах, түүний дотроос эн тэргүүнд “Шинэ Зуунмод хот”-ыг байгуулах шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасныг үндэслэн нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр нийслэлийн дагуул хот болох Шинэ Зуунмод хотыг байгуулахтай холбоотой нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан, шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзэж анхдагч хуулийн төсөл боловсрууллаа.

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах нийгэм болон хууль зүйн баталгааг бүрдүүлэх, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон зайн оновчтой төлөвлөлт бүхий дагуул хот байгуулах зорилтын хүрээнд Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлыг тогтоож, хотын бүтээн байгуулалт, тогтвортой хөгжлийг дэмжих бодлогыг тодорхойлох зорилго бүхий Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь 6 бүлэг, 29 зүйлтэй.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгасан:

Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл буюу хуулийн зорилго, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хотын эрх зүйн үндэс, байршил, эдэлбэр газар, хотыг хөгжүүлэх үйл ажиллагааны зарчим зэрэг асуудлыг тусгасан.

Тухайлбал, Шинэ Зуунмод хотыг байгуулах, төлөвлөх, бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд Хот байгуулалтын тухай хуульд зааснаас гадна нийслэл болон орон нутаг, бүс нутгийг тэнцвэртэй хөгжүүлэх, гадаргын ус, саарал усыг дахин ашиглах, хог хаягдлыг дахин боловсруулах технологид тулгуурлах; хотын бүтээн байгуулалтыг улс, нийслэл, орон нутаг, бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжил, аж үйлдвэрийн бүтцийн зохицуулалттай уялдуулах; эдийн засгийн хувьд бие даасан байх; орчин үеийн эко, ухаалаг хотыг хот байгуулалтын баримт бичигт нийцүүлэн хөгжүүлэх зэрэг зарчим баримтална.

Шинэ Зуунмод хот нь хуулиар тусгайлан тогтоосон чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалт, эдийн засагтай, нийслэл хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэхэд стратегийн ач холбогдол бүхий Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын дагуул хот байна.

Шинэ Зуунмод хот нь нийтийн эрх зүйн этгээд байх бөгөөд эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцох ба эрх зүйн харилцаанд хотыг Хотын захирагч төлөөлнө.

Шинэ Зуунмод хот нь дүрэмтэй байх бөгөөд хотын Зөвлөлийн үйл ажиллагаа, хуралдааны дэг; хотын Захирагч, түүний ажлын албаны чиг үүрэг, үйл ажиллагаа; хотын Ерөнхий архитектор, түүний ажлын албаны чиг үүрэг, үйл ажиллагаа; хотын

бэлгэдэл тэмдэг; хотын оршин суугчийн оролцоо, иргэний танхим; ашиг сонирхлын зөрчил, ёс зүйн хороо гэх мэт асуудлыг хотын дүрмээрээ зохицуулахаар тусгасан.

Шинэ Зуунмод хот нь Хөшигийн хөндий дэх олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт байрлах ба хотын эдэлбэр газрын хэмжээг Монгол Улсын Их Хурал тогтоохоор хуульчлав.

Хоёрдугаар бүлэгт хот байгуулалтын үйл ажиллагаа буюу Шинэ Зуунмод хотын төлөвлөлт, бүсчлэл, газрын менежменттэй холбоотой зохицуулалтыг тусгав.

Тухайлбал, Шинэ Зуунмод хот нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй байх ба нийслэл хотын болон Төв аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан байна.

Хот байгуулалтын баримт бичгийг боловсруулах үйл ажиллагаанд Захиргааны ерөнхий хуулийн Долоодугаар бүлэгт заасан журмыг баримталж, олон нийтийн оролцоог хангах ба Шинэ Зуунмод хотын оршин суугч оршин суугаа газраасаа 300-500 метрт нийгмийн болон инженерийн дэд бүтцийг нэн тэргүүнд барьж байгуулах зарчим баримтлах ба Шинэ Зуунмод хотын газар зохион байгуулалт нь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон хотыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд үндэслэх хуулийн шаардлагыг тодорхойлсон.

Гуравдугаар бүлэгт Шинэ Зуунмод хотын чиг үүрэг, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог тодорхойлж, хотын чиг үүргийг тогтоож, тус хотын Зөвлөл, Захирагч, Ерөнхий архитектор, Хөгжлийн корпораци, тэдгээрийн ажлын албаны үйл ажиллагаа, бүрэн эрхтэй холбоотой харилцааг дараахи байдлаар зохицуулсан:

- Шинэ Зуунмод хот нь хотынхоо эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх, өөрийн эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг хууль тогтоомж, хотын дүрмийн хүрээнд хотын оршин суугч, хөрөнгө оруулагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн чиг үүрэгтэй байх ба нийслэлийн дагуул хот болохын хувьд Засгийн газар, нийслэл, бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаас холбогдох хуулийн дагуу шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ;

- Шинэ Зуун мод хот нь зохион байгуулалтын хувьд хороололд хуваагдана.

- Шинэ Зуунмод хотын удирдлагын тогтолцоо нь хотын Зөвлөл, хотын Захирагч, хотын ерөнхий архитектороос бүрдэх ба сонгуулийн журмаар байгуулагддаг байх зарим баримтална;

- Шинэ Зуунмод хотын нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого тодорхойлох, хотын чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх үүргийг Шинэ Зуунмод хотын Зөвлөл хэрэгжүүлэх ба хотын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлж зохион байгуулах үүргийг хотын Захирагч, хот байгуулалт, газар зохион байгуулалт, төлөвлөлт, хөгжүүлэлтийн чиг үүргийг хотын ерөнхий архитектор хэрэгжүүлнэ;

- Шинэ Зуунмод хотын газар хөгжүүлэлт, менежмент, хэрэгжих бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, хөрөнгө оруулах, төслийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг нийслэл, Төв аймгийн өмчийн оролцоотой Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпораци хэрэгжүүлэх ба түүнийг

байгуулах асуудлыг нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

Дөрөвдүгээр бүлэгт Шинэ Зуунмод хотын эдийн засгийн үндсийг тодорхойлж, хотын эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хотын эдийн засагт төрөөс болон нийслэл, төв аймгаас үзүүлэх дэмжлэг, туслалцаа, хотын төсөв, татвар, өмч, дэд бүтцийг хөгжүүлэх сантай холбоотой үүсэх харилцаа, зохицуулалтыг тусгасан.

Тухайлбал, Шинэ Зуунмод хотын эдийн засгийн үндэс нь улс, нийслэл, орон нутаг, хотын өөрийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө, түүнчлэн хотын өмч, татварын болон татварын бус орлого, хотын сангийн хөрөнгө, гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүсийн хандив, тусламж, бусад орлогоос бүрдэнэ.

Шинэ Зуунмод хотын эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх, бие даан хөгжих, баталгаагаар хангахад төр, нийслэл, орон нутаг энэ хуульд заасны дагуу тодорхой дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээнэ. Жишээлбэл:

- Төрөөс хотын бүтээн байгуулалтад татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх, улсын төсөвт инженерийн болон нийгмийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт, төрийн байгууллагуудыг үе шаттай нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг баталж, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусгах, Засгийн газрын болон төрийн захиргааны төв байгууллагын зарим чиг үүргийг Шинэ Зуунмодын хотын удирдлагад шилжүүлж болох;

- Нийслэл хот нь Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтад зориулж холбогдох хууль, журмын дагуу үнэт цаас гаргаж болох;

- Нийслэл болон Төв аймаг хотын эрчим хүч, дулаан, ус хангамж, ариутгах татуурга, харилцаа холбоо, инженерийн бэлтгэл арга хэмжээ, хог хаягдалтай холбоотой зөвшөөрөл, үйлчилгээг саадгүй үзүүлэх, орон нутгийн татвар, төлбөр, хураамжаас хөнгөлөх, чөлөөлөх; өөрийн мэдлийн өмчийг дагуул хотод хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах асуудлыг шийдвэрлэх; төрийн үйлчилгээг шуурхай, нэг цонхоор үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх; хяналт, шалгалтыг давхардуулахгүй байх гэх мэт.

Мөн энэ бүлэгт Шинэ Зуунмод хот төсөвтэй байх, тухайн хот дахь татварын орлогын 80 хувийг Шинэ Зуунмод хотод, 20 хувийг Төв аймгийн төсөвт хуваарилах зарчим баримтлах, хотын бүтээн байгуулалтад зориулсан “Дэд бүтцийн сан”-тай байх, тус санд хотын төсвийн татварын орлогын 10 хувь, бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө оруулалтын ашгийн 2 хувь, Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпорацийн ногдол ашгийн 20 хувь, Чөлөөт бүсийн аж ахуйн үйл ажиллагааны орлогын 10 хувийг төвлөрүүлж нийгмийн болон инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд зарцуулах зохицуулалтууд тусгагдсан.

Тавдугаар бүлэгт Шинэ Зуунмод хотын бизнесийн орчин, хөрөнгө оруулалтын талаар буюу хотын бүтээн байгуулалтад үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэгийн талаар тусгасан.

Шинэ Зуунмод хотод хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ нь Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан зарим шалгуур хангасан тохиолдолд тогтворжуулалтын гэрчилгээг олгохоор тусгаж тавигдах шаардлагыг энэ хуулиар тодорхойлж, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг

хамт боловсруулсан. Мөн хотын бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд гаалийн, татварын болон татварын бус тусгай зохицуулалт үйлчлэх эрх зүйн үндсийг тавьж холбогдох хуулиар нарийвчлан зохицуулсан.

Шинэ Зуунмод хот дахь төрийн үйлчилгээ нь худалдаа, татвар, бизнес, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх бүртгэл, зөвшөөрлийн цахим нэг цонхны үйлчилгээнд суурилах зарчмыг хуульчилсан.

Зургаадугаар бүлэгт Шинэ Зуунмод хотын удирдлагаас бусад этгээдтэй харилцах болон хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох талаар тусгалаа.

Тухайлбал, Шинэ Зуунмод хотын удирдлага нь Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй нийслэлийн Засаг даргаар дамжуулж харилцах ба хотыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж болох бөгөөд энэ харилцааг холбогдох хуулиар зохицуулахаар хуульчилсан.

Хууль батлагдсанаар хүлээгдэж буй үр дүн:

- Нийслэл хотын төвлөрлийг задалж, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангана;
- орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой хотыг хөгжүүлж, бүтээн байгууллалтын үйл ажиллагааны журам, зохицуулалт тодорхой болно;
- дагуул хотын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх боломж бүрдэнэ;
- нийслэл хотын түгжрэл, агаар, хөрсний бохирдол, орон сууцны хангамж, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэхэд эерэг нөлөө үзүүлнэ;
- нийгмийн болон инженерийн дэд бүтцийн төвлөрсөн хангамж бий болж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг кластераар хөгжүүлж улс, нийслэл, төв аймаг цаашлаад бүс нутгийн нийгэм, эдийн засгийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ;
- шинээр ажлын байр бий болж, дотоодын нийт бүтээгдэхүүн болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ;
- орон сууцжуулах төсөл хэрэгжүүлж орон сууцны хангамж нэмэгдэж, нийслэлээс иргэд шилжин суурьших, төрийн байгууллага, их дээд сургууль, коллеж, шинжлэх ухааны байгууллагуудыг нүүлгэх нөхцөлийг бүрдүүлнэ;
- тээвэр ложистикийн нэгдсэн төвийг байгуулж, хөгжүүлснээр орон нутгийн болон бүсийн цаашлаад олон улсын ложистикийг сайжруулна;
- иргэдийн аятай таатай амьдрах орчин бий болж, амьдралын чанар сайжирна;
- Шинэ Зуунмод хот дүрэмтэй болж хууль тогтоомжоор зохицуулагдаагүй хотын амьдрал, үйл ажиллагаатай холбоотой асуудлаа оршин суугчид, иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэнэ;

- бусад улсуудын хотуудын жишгээр Шинэ Зуунмод хотын оршин суугчид хотын удирдлагаа сонгодог болно гэх мэт.

Хуулийн төсөлтэй холбогдуулан дараах хууль тогтоомжийн төслийг боловсруулсан. Тухайлбал:

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл:

Шинэ Зуунмод хотын байнгын оршин суугчийн тоо 15,000 давснаар Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Шинэ Зуунмод хотын Зөвлөл, Захирагчийн сонгуулийг зохион байгуулах, сонгуулийг зохион байгуулах хүртэлх хугацаанд хотын Зөвлөлийн чиг үүргийг Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпораци гүйцэтгэх ба хотын Захирагчийг нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлөх шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгав.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл:

Нийслэлийн дагуул хотын бүтээн байгуулалтын төсөл нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 16.1.1-д зааснаас бусад шалгуурыг хангасан тохиолдолд Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу тогтворжуулалтын гэрчилгээг олгож болох, Нийслэлийн дагуул хотын бүтээн байгуулалтын төсөлд 300 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчтай түүний гаргасан хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулах орчныг тогтвортой байлгах зорилгоор хөрөнгө оруулалтын гэрээг Засгийн газрын эрх олгосноор дагуул хотын Захирагч байгуулж болох зохицуулалтыг тус тус хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлтээр оруулахаар хуулийн төсөлд тусгав.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл:

Шинэ Зуун мод хотын Зөвлөлийн 3 гишүүн нь Шинэ Зуунмод хот дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас сонгосон хөрөнгө оруулагчдын төлөөлөл байх тул хуулийн төсөлд Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимыг Шинэ Зуунмод хотод байгуулж болох тухай зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл:

Шинэ Зуунмод хотын төсөл, арга хэмжээний бүтээн байгуулалтад зориулж үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, импортоор оруулах барилгын материал, тоног төхөөрөмжийн нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн Засгийн газар гаргаж болох зохицуулалтыг уг хуулийн төсөлд тусгав.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл:

Шинэ Зуун мод хотын бүтээн байгуулалтад ажиллах хүчнийг нэмэгдүүлэх зорилгоор Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлийн

32.4 дэх хэсэгт шинэ хотын бүтээн байгуулалтад гадаад ажилтан ажиллуулах тохиолдолд Засгийн газар ажлын байрны төлбөрөөс хөнгөлж, чөлөөлөх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл:

Шинэ Зуунмод хот нь тус хотод мөрдөх хууль, дүрэм, журамтай байх тул Нийслэл Улаанбаатар хотод мөрдөх хууль, дүрэм, журам зөрчихөд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон Зөрчлийн тухай хуулийн 6.30 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг Шинэ Зуунмод хотод нэгэн адил хэрэглэдэг байхаар хуулийн төслийг боловсруулсан болно.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл:

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль баталсантай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангах талаар чиглэл өгч, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулсан:

1.Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн иргэдийн хотын нийтийн аж ахуйн үйлчилгээ, төрийн үйлчилгээ авах эрхийг хангах арга хэмжээ авах;

2.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулиар төрөөс үзүүлэх дэмжлэгтэй холбогдсон харилцааг зохицуулсан тул хотын бүтээн байгуулалтын хугацаанд буюу 2040 он хүртэл жил бүр улсын төсөвт инженерийн болон нийгмийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт, төрийн байгууллагуудыг үе шаттай нүүлгэх шилжүүлэх зардлын төсвийг тусгаж батлуулах;

3.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 14.1 дэх хэсгийн хэрэгжилтийг хангаж хотын Захирагчийн сонгуулийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох ажлыг зохион байгуулах зэрэг асуудлыг тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавихыг холбогдох байнгын хороодод даалгасан зохицуулалтыг тусгалаа.

“Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл:

Хот байгуулалтын тухай хуулийн 5.1.2, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 35.1-д хот байгуулах шийдвэрийг Монгол Улсын Их Хурал гаргана, мөн Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 5.2-т Шинэ Зуунмод хотын эдэлбэр газрын хэмжээг Монгол Улсын Их Хурал тогтооно гэж тус тус заасан тул “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан ба дараахи асуудлуудыг тусгасан:

1.Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын хүн амын хэт төвлөрөл, хүрээлэн байгаа орчинд үзүүлж буй сөрөг нөлөөг бууруулах, олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн эдийн засгийн тодорхой салбаруудыг тогтвортой хөгжлийн зорилтод нийцүүлэн хөгжүүлэх, хүн амыг эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлалыг дэмжих зорилгоор Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт нийслэлийн дагуул хот "Шинэ Зуунмод" хотыг байгуулах;

2.Шинэ Зуунмод хотын эдэлбэр газрын хэмжээг 32,501.3 га-гаар тогтоож, эдэлбэр газрын хил заагийг батлах;

3.Улсын Их Хурлын 2020 оны "Хот байгуулах тухай" 55 дугаар тогтоолд өөрчлөлт оруулж тус тогтоолын "Шинэ Зуунмод" хоттой холбоотой зохицуулалтыг хасаж өөрчлөлт оруулах;

4."Шинэ Зуунмод" хотын бүтээн байгуулалтын үйл ажиллагааг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Төв аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулан Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид, шинэ хотын бүтээн байгуулалтад дэмжлэг үзүүлэх, хяналт тавихыг Монгол Улсын Засгийн газарт даалгах.

---oOo---

ШИНЭ ЗУУНМОД ХОТЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх” гэж, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлж, хүний аюулгүй байдлыг хангах” төрийн үүргийг тодорхойлсон.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод дэвшүүлсэн Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлэх зорилтын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 9.5.1-д дагуул, хаяа хот, тосгоныг тус бүрд нь худалдаа, үйлчилгээ, боловсрол, соёл, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлалын чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулна, 9.5.2-т “Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, инженерийн шугам сүлжээ, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ, 9.5.3-т Хөшигийн хөндийд байрлах олон улсын нисэх онгоцны буудлыг даган байгуулагдах “Шинэ Зуунмод” шинэ хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ, 9.5.5-д Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг нэгдсэн бодлого төлөвлөлттэйгөөр дагуул хотуудад шилжүүлэн үйл ажиллагааг нь дэмжин ажиллана, 9.5.6.Зарим их, дээд сургуулийг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж, дагуул хотуудад хотхон байгуулан шилжүүлэх замаар хотын төвлөрлийг сааруулна гэж тус тус заасан.

Улаанбаатар хотыг хөгжүүлэх урт хугацааны анхдугаар хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 1954 онд батлагдаж, 1961, 1976, 1986 онуудад тодотгол, шинэчлэл хийгдэж байсан ба манай улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орсноос хойш Улаанбаатар хотыг 2000-2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байсан ба Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичгийг баталж, Улаанбаатар хот нийт 15 дагуул хот, тосгонтой байхаар төлөвлөсөн боловч дагуул хотыг хэрхэн байгуулах, бүтэц зохион байгуулалт нь ямар байх талаар ерөнхий зохицуулалттай, тухайн хотын онцлогт тохирсон нарийвчилсан зохицуулалтгүйгээс тодорхой үр дүнд хүрээгүй боловч дагуул хот, тосгон байгуулах хэрэгцээ шаардлага байгааг дараах тоо баримт харуулж байна.

Тухайлбал, Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь манай улсын нийт газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг хэдий ч хүн ам, их дээд сургууль, коллеж, бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ зэрэг үзүүлэлтээр тогтмол Улсын хэмжээнд тэргүүлж жил бүр энэ үзүүлэлтийн тоо хэмжээ өссөөр байна. Эдгээр үзүүлэлтийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар авч үзвэл:

- Нийслэлд байнга оршин суугчдын тоо 1,596,335 буюу манай улсын нийт хүн амын 47,4% хувьтай;

- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо 175,200 буюу манай улсад бүртгэлтэй нийт аж ахуйн нэгжийн 74.7 хувьтай;
- нийслэлийн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 33.8 их наяд төгрөг буюу үндэсний дотоодын нийт бүтээгдэхүүний 69.2 хувьтай тус тус тэнцэж байна.

Ийнхүү нийслэл Улаанбаатар хотын хүн амын тоо эрчимтэй өсөж, үйл ажиллагаа идэвхжихийн хирээр төлөвлөлтгүй суурьших, байгаль орчин доройтох, хог хаягдал, дуу чимээ нэмэгдэх, гэмт хэрэг, зөрчил ихсэх, замын хөдөлгөөний түгжрэл үүсэх зэрэг олон сөрөг асуудлын улмаас нийслэл хотын эдийн засаг, нийгмийн харилцаанд хүндрэл учирч, иргэдийн ая тухтай амьдрах эрх зөрчигдөж байгаа тул дээрх асуудлуудыг шийдвэрлэх, тухайлбал, Улаанбаатар хотын төвлөрлийг задалж, дэд бүтцийг тэлэх, дагуул хотуудыг байгуулах, түүний дотроос эн тэргүүнд “Шинэ Зуунмод хот”-ыг байгуулах шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах нийгэм болон хууль зүйн баталгааг бүрдүүлэх, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон зайн оновчтой төлөвлөлт бүхий дагуул хот байгуулах зорилтын хүрээнд Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлыг тогтоож, хотын бүтээн байгуулалт, тогтвортой хөгжлийг дэмжих бодлогыг тодорхойлох зорилго бүхий Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг 6 бүлэг, 29 зүйлтэйгээр боловсрууллаа.

Хуулийн төсөлд дараахь асуудлыг тусгасан:

- Шинэ Зуунмод хотыг олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт байгуулах бөгөөд хотын эдэлбэр газрын хэмжээг Улсын Их Хурал тогтооно;

- Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь нийслэл болон Төв аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан байх ба эдэлбэр газар нь амралт, аялал жуулчлалын, олон нийт худалдаа, үйлчилгээний, засаг захиргааны, оюутны хотхон, судалгаа, шинжилгээний, тээвэр, логистик, олон улсын нисэх онгоцны буудал, агаарын каргоны зэрэг 9 бүстэй байх, бүсчлэлийн хуваарийг зөвхөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлно. Тухайлбал, амралт, аялал жуулчлалын бүсэд ОУ-ын хурал, зөвлөгөөн, арга хэмжээний цогцолбор, морин тойруулга, бооцоот тоглоом, музейн цогцолборыг байгуулах ба хотын төв, засаг захиргааны бүсэд төрийн зарим байгууллагыг нүүлгэн шилжүүлнэ;

- Шинэ Зуунмод хот нь иргэдэд зориулсан ирээдүйн хотын олон улсын концепцийн дагуу төлөвлөгдөж байгуулагдах ба үүнийг зөрчсөн тохиолдолд холбогдох этгээдэд хариуцлага хүлээлгэнэ. Тодруулбал, оршин суугчид оршин суугаа газраасаа 300-500 метр зайд сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийтийн тээврийн үйлчилгээний буудал, цэцэрлэгт хүрээлэн, худалдаа, үйлчилгээний газарт хүрэх төлөвлөлтийг хэрэгжүүлнэ;

- газар ашиглуулах асуудлыг зөвхөн төсөл сонгон шалгаруулах зарчмаар шийдвэрлэх ба төсөл болон сонгон шалгаруулалтад оролцох этгээдэд тавигдах шаардлага, төсөл шалгаруулах журмыг Засгийн газар батална;

- хотын удирдлага нь Хотын зөвлөл, Захирагч, Ерөнхий архитектороос бүрдэх ба зохион байгуулалтын хувьд хороололд хуваагдана;

- хотыг төлөвлөлтийн дагуу байгуулах чиг үүргийг хотын ерөнхий архитектор хүлээнэ. Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпораци нь хотын бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, удирдлага, арга зүйгээр хангах, төслийн хэрэгжилтэд хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй байна;

- хотын эдийн засаг нь бие даасан байх ба аялал жуулчлал; тээвэр ложистик, үйлдвэрлэл; бүтээлч үйлдвэрлэл /кино контент, биет бус өвийн академи/; шинжлэх ухаан, инновацийн зэрэг тэргүүлэх чиглэлд үндэслэнэ;

- Шинэ Зуунмод хотын эдийн засгийн чадавхийг бэхжүүлэхэд төр, нийслэл, Төв аймаг хуульд заасан тодорхой дэмжлэг үзүүлнэ. Тухайлбал, төрөөс татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх, улсын төсөвт дэд бүцийн хөрөнгө оруулалтыг тусгах, төрийн байгууллагыг нүүлгэн шилжүүлэх гэх мэт. Нийслэл, Төв аймгийн хувьд орон нутгийн төлбөр, хураамжаас хөнгөлөх, өөрийн өмчийг хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах, төрийн үйлчилгээг шуурхай, нэг цонхоор хүргэх, хяналт шалгалтыг давхардуулахгүй байх, дагуул хотын бүтээн байгуулалтад зориулж үнэт цаас гаргах зэрэг дэмжлэг үзүүлнэ;

- Шинэ Зуунмод хот төсөвтэй байх ба тухайн хот дахь татварын орлогын 80 хувийг Шинэ Зуунмод хотод, 20 хувийг Төв аймгийн төсөвт хуваарилах зарчим баримтална.

- хотын бүтээн байгуулалтад зориулсан “Дэд бүтцийн сан”-тай байх ба тус санд хотын төсвийн татварын орлогын 10 хувь, бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө оруулалтын ашгийн 2 хувь, Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпорацийн ногдол ашгийн 20 хувь, Чөлөөт бүсийн аж ахуйн үйл ажиллагааны орлогын 10 хувийг төвлөрүүлж нийгмийн болон инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд зарцуулна гэх мэт.

Хууль батлагдсанаар хүлээгдэж буй үр дүн:

- Нийслэл хотын төвлөрлийг задалж, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангана;
- орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой хотыг хөгжүүлж, бүтээн байгуулалтын үйл ажиллагааны журам, зохицуулалт тодорхой болно;

- дагуул хотын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх боломж бүрдэнэ;

- нийслэл хотын түгжрэл, агаар, хөрсний бохирдол, орон сууцны хангамж, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэхэд эерэг нөлөө үзүүлнэ;

- нийгмийн болон инженерийн дэд бүтцийн төвлөрсөн хангамж бий болж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг кластераар хөгжүүлж улс, нийслэл, төв аймаг цаашлаад бүс нутгийн нийгэм, эдийн засгийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ;

- шинээр ажлын байр бий болж, дотоодын нийт бүтээгдэхүүн болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ;

- орон сууцжуулах төсөл хэрэгжүүлж орон сууцны хангамж нэмэгдэж, нийслэлээс иргэд шилжин суурьших, төрийн байгууллага, их дээд сургууль, коллеж, шинжлэх ухааны байгууллагуудыг нүүлгэх нөхцөлийг бүрдүүлнэ;

- тээвэр ложистикийн нэгдсэн төвийг байгуулж, хөгжүүлснээр орон нутгийн болон бүсийн цаашлаад олон улсын логистикийг сайжруулна;

- иргэдийн аятай таатай амьдрах орчин бий болж, амьдралын чанар сайжирна;

- Шинэ Зуунмод хот дүрэмтэй болж хууль тогтоомжоор зохицуулагдаагүй хотын амьдрал, үйл ажиллагаатай холбоотой асуудлаа оршин суугчид, иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэнэ;

- бусад улсуудын хотуудын жишгээр Шинэ Зуунмод хотын оршин суугчид хотын удирдлагаа сонгодог болно гэх мэт.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай зэрэг холбогдох шаардлагатай бусад дагалдах хуулийн төслүүд болон Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулсан.

---о0о---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны...дугаар
сарын...-ны өдөр

Улаанбаатар
хот

ШИНЭ ЗУУНМОД ХОТЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон зайн оновчтой төлөвлөлт бүхий дагуул хот байгуулах зорилтын хүрээнд Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлыг тогтоож, хотын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тогтвортой хөгжлийг дэмжих бодлогыг тодорхойлоход оршино.

2 дугаар зүйл.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын хууль тогтоомж

2.1.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль², Хот байгуулалтын тухай хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Газрын тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдалтай холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

3.2.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол бусад хуульд заасан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын хэрэгжүүлэх чиг үүргийг Шинэ Зуунмод хотын удирдлага нэгэн адил хэрэгжүүлнэ.

4 дүгээр зүйл.Шинэ Зуунмод хотын эрх зүйн үндэс

4.1.Шинэ Зуунмод хот нь хуулиар тусгайлан тогтоосон чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалт, эдийн засагтай, нийслэл хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэхэд стратегийн ач холбогдол бүхий Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын дагуул хот байна.

¹Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

²Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2021 оны 35 дугаарт нийтлэгдсэн.

4.2.Шинэ Зуунмод хот /цаашид “хот” гэх/ нь нийтийн эрх зүйн этгээд байх бөгөөд эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно.

4.3.Эрх зүйн харилцаанд хотыг Хотын захирагч төлөөлнө.

4.4.Шинэ Зуунмод хот нь Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 8.1-д заасан дүрэмтэй байх бөгөөд дараах асуудлыг тусгана:

4.4.1.хотын Зөвлөлийн үйл ажиллагаа, хуралдааны дэг;

4.4.2.хотын Захирагч, түүний ажлын албаны чиг үүрэг, үйл ажиллагаа;

4.4.3.хотын Ерөнхий архитектор, түүний ажлын албаны чиг үүрэг, үйл ажиллагаа;

4.4.4.хотын бэлгэдэл тэмдэг;

4.4.5.хотын оршин суугчийн оролцоо, иргэний танхим;

4.4.5.ашиг сонирхлын зөрчил, ёс зүйн хороо.

4.5.Энэ хуулийн 4.4-т заасан дүрэмд зарчмын шинжтэй өөрчлөлт орсон, эсхүл шинэчлэн баталсан тохиолдолд тухайн шийдвэрт өөрөөр заагаагүй бол Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу бүртгүүлснээс хойш 3 сарын дараа дагаж мөрдөнө.

5 дугаар зүйл.Шинэ Зуунмод хотын байршил, эдэлбэр газрын хэмжээ

5.1.Шинэ Зуунмод хот нь Хөшигийн хөндий дэх олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт байрлана.

5.2.Шинэ Зуунмод хотын эдэлбэр газрын хэмжээг Монгол Улсын Их Хурал тогтооно.

6 дугаар зүйл.Шинэ Зуунмод хотыг хөгжүүлэх үйл ажиллагааны зарчим

6.1.Шинэ Зуунмод хотыг байгуулах, төлөвлөх, бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд Хот байгуулалтын тухай хуульд заасан болон дараах зарчмыг баримтална:

6.1.1.нийслэл болон орон нутаг, бүс нутгийг тэнцвэртэй хөгжүүлэх;

6.1.2.соёл, аялал жуулчлал, эрүүл мэндийн үйлчилгээ, олон улсын харилцаа, үйлдвэрлэл, инновацийн төв байх;

6.1.3.гадаргын ус, саарал усыг дахин ашиглах, хог хаягдлыг дахин боловсруулах технологид тулгуурлах;

6.1.4.Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтыг улс, нийслэл, орон нутаг, бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжил, аж үйлдвэрийн бүтцийн зохицуулалттай уялдуулах;

6.1.5.нэгдсэн төлөвлөлтийн тогтолцоотой байх;

6.1.6.эдийн засгийн хувьд бие даасан байх;

6.1.7.орчин үеийн эко, ухаалаг хот болгон хөгжүүлэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХОТ БАЙГУУЛАЛТ

7 дугаар зүйл.Шинэ Зуунмод хотын төлөвлөлт

7.1.Шинэ Зуунмод хот нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй байх ба нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй нийцсэн байна.

7.2.Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газар, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хотын Ерөнхий архитекторын саналыг үндэслэн хотын Зөвлөл тус тус батална.

7.3.Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хотыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийцүүлэн барилгажилтын төслийг Шинэ Зуунмод хотын Ерөнхий архитектор баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

7.4.Энэ хуулийн 7.1, 7.2, 7.3-т заасан төлөвлөгөөний төсөл нь Хот байгуулалтын тухай хуульд заасан шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байх ба тэдгээрийг боловсруулах үйл ажиллагаанд Захиргааны ерөнхий хуулийн Долоодугаар бүлэгт заасан журмыг баримталж, олон нийтийн оролцоог хангана:

7.4.1.оршин суугчийн оршин суугаа газраас 300-500 метрт сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийтийн тээврийн үйлчилгээний буудал, цэцэрлэгт хүрээлэн, соёлын төв, худалдаа, үйлчилгээний газарт хүрэх боломжтой байх;

7.4.2.Шинэ Зуунмод хотын тээврийн хэрэгсэл нь хос болон цахилгаан тэжээлтэй байх;

7.4.3.Инженерийн бэлтгэл арга хэмжээ, ус хангамж, ариутгах татуурга, цахилгаан хангамж, хийн хангамж, зам, харилцаа холбоо, сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг дэд бүтэц, нийтийн үйлчилгээний барилга байгууламж барих ажлыг нэн тэргүүнд зохион байгуулж, сэргээгдэх эрчим хүчний олон төрлийг ашиглах дэд бүтцийг хөгжүүлэх;

7.4.4.инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний төлөвлөлт, бүтээн байгуулалтад шинэлэг инноваци бүхий технологийг нэвтрүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

8 дугаар зүйл.Шинэ Зуунмод хотын бүсчлэл

8.1.Хотын нутаг дэвсгэр нь дараах бүсчлэлтэй байна:

8.1.1.эдийн засгийн чөлөөт бүс;

8.1.2.амралт, аялал жуулчлалын бүс;

8.1.3.олон нийт, худалдаа, үйлчилгээний бүс;

8.1.4.засаг захиргааны бүс;

8.1.5.оюутны хотхон, сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолборын бүс;

8.1.6.зах, худалдаа, бөөний төвийн бүс;

- 8.1.7.тээвэр, логистик, үйлдвэрлэлийн бүс;
- 8.1.8.олон улсын нисэх онгоцны буудал, агаарын каргоны бүс;
- 8.1.9.аж ахуй, нөөц бүс.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан бүсчлэлийн хуваарийг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлно.

8.3.Шинэ Зуунмод хотын бүсчлэлийн дүрмийг хотын Зөвлөл батална.

9 дүгээр зүйл.Шинэ Зуунмод хотын газрын менежмент

9.1.Шинэ Зуунмод хотын газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөө нь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хотыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, барилгажилтын төсөлд үндэслэх бөгөөд хотын Ерөнхий архитекторын саналыг үндэслэн хотын Зөвлөл батална.

9.2.Энэ хуулийн 7, 8 дугаар зүйлд заасны дагуу хотын эдэлбэр газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах газрын байршил, зориулалт, хэмжээг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгана.

9.3.Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу нийгмийн болон инженерийн дэд бүтцээс бусад зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглах эрх олгох асуудлыг зөвхөн төсөл сонгон шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ.

9.4.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглах эрх олгох төсөл нь хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хотыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний үе шатны төслийн жагсаалтад хамаарч байна.

9.5.Энэ хуулийн 9.3-т заасан төсөл болон сонгон шалгаруулалтад оролцох этгээдэд тавигдах шаардлага, төсөл шалгаруулах журмыг Засгийн газар батална.

9.6.Энэ хуулийн 9.5-д заасан журмын дагуу төслийг Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпораци сонгон шалгаруулж, шалгарсан этгээдтэй газар ашиглуулах гэрээг хотын Захирагч байгуулна.

9.7.Энэ хуулийн 9.5-д заасан газар ашиглуулах гэрээнд Газрын тухай хуульд зааснаас гадна дараах нөхцөлийг тусгана:

9.7.1.газрыг гэрээнд заасан төсөл хэрэгжүүлэхээс өөр зориулалтаар ашигласан, эсхүл ашиглахаар бүтээн байгуулалтын ажил хийгдэж байгаа бол гэрээг нэг талын санаачилгаар цуцлах;

9.7.2.төслийг гэрээ байгуулснаас хойш 12 сарын хугацаанд хэрэгжүүлж эхлээгүй бол газар ашиглах эрх дуусгавар болох.

9.8.Шинэ Зуунмод хотын эдэлбэр газарт улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт зориулж газар ашиглуулах асуудлыг энэ хуулийн 9.5-д заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

9.9.Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хотыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Засгийн газрын шийдвэрээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлж болно. Энэ тохиолдолд Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах хуулийн 10, 11, 12 дугаар зүйлийг баримтална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ.ХОТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

10 дугаар зүйл.Шинэ Зуунмод хотын чиг үүрэг

10.1.Шинэ Зуунмод хот нь тус хотын эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх, өөрийн эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг хууль тогтоомж, хотын дүрмийн хүрээнд хотын оршин суугч, хөрөнгө оруулагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн чиг үүрэгтэй байна.

10.2.Шинэ Зуунмод хот нь нийслэлийн дагуул хот болохын хувьд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 36.1-д заасан болон Засгийн газар, нийслэл, бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаас холбогдох хуулийн дагуу шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

10.3.Засгийн газар, нийслэл, бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж энэ хуулийн 10.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төрийн болон орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах эрхийг хууль тогтоомжид нийцүүлэн Шинэ Зуунмод хотод шилжүүлж болно.

10.4.Шинэ Зуунмод хот хуульд заасан чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах эрхтэй.

11 дүгээр зүйл.Шинэ Зуунмод хотын зохион байгуулалт

11.1.Дагуул хот нь зохион байгуулалтын хувьд хороонд хуваагдана. Хороо нь энэ хуулийн 8.1-д заасан бүсчлэлийн дагуу зохион байгуулагдана.

12 дугаар зүйл.Шинэ Зуунмод хотын удирдлага, түүний тогтолцоо

12.1.Шинэ Зуунмод хотын удирдлага дараах тогтолцоотой байна.

- 12.1.1.хотын Зөвлөл;
- 12.1.2.хотын Захирагч;
- 12.1.3.хотын Ерөнхий архитектор.

12.2.Шинэ Зуунмод хотын нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого тодорхойлох, хотын чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх үүргийг Шинэ Зуунмод хотын Зөвлөл хэрэгжүүлнэ.

12.3.Шинэ Зуунмод хотын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлж зохион байгуулах үүргийг Шинэ Зуунмод хотын Захирагч гүйцэтгэнэ.

12.4.Шинэ Зуунмод хотын Ерөнхий архитектор нь Хот байгуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан болон энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

12.5. Шинэ Зуунмод хот нь хөгжлийн корпорацитай байна.

12.6.Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпораци нь энэ хуулийн 16.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

12.7.Хотын удирдлага энэ хуульд заасан зарим чиг үүргээ холбогдох хуульд заасны дагуу гэрээний үндсэн дээр бусдаар гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн, эсхүл хэсэгчлэн санхүүжүүлж болно.

13 дугаар зүйл.Шинэ Зуунмод хотын Зөвлөл, түүний бүрэн эрх

13.1.Шинэ Зуунмод хотын Зөвлөл нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

13.2.Шинэ Зуунмод хотын Зөвлөлийн 3 гишүүн нь Шинэ Зуунмод хот дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас сонгосон хөрөнгө оруулагчдын төлөөлөл байх ба тэдгээр нь дараах шаардлагыг хангасан байна:

13.2.1.Монгол Улсын иргэн байх;

13.2.2.Шинэ Зуунмод хотод 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө оруулалт хийсэн;

13.2.3.татварын өргүй байх;

13.2.4.ял, шийтгэлгүй байх.

13.3.Энэ хуулийн 13.2-т зааснаас бусад 6 гишүүнийг Шинэ Зуунмод хотын оршин суугчдаас сонгон шалгаруулж, 4 жилийн хугацаагаар хотын Захирагч томилно.

13.4.Шинэ Зуунмод хотын Зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

13.4.1.Шинэ Зуунмод хотын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэл, Шинэ Зуунмод хотын төсөв, хөтөлбөрийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

13.4.2.Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

13.4.3.энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан хотын чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;

13.4.4.Шинэ Зуунмод хотын Захирагчийн тайланг сонсох, хэлэлцэх, дүгнэх;

13.4.4.хуульд өөрөөр заагаагүй бол Шинэ Зуунмод хотын чиг үүрэг хэрэгжүүлэх талаар журам, дүрэм, заавар батлах;

13.4.5.хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд татвар, төлбөр, хураамж, урамшууллын хэмжээг тогтоох;

13.4.6.Шинэ Зуунмод хотын өмчийн зүйлсийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх;

13.4.7.хотын өмчийн болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах;

13.4.8.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

13.5.Шинэ Зуунмод хотын Зөвлөл хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлэхээр баталсан захиргааны хэм хэмжээ агуулсан журам, дүрэм, зааврыг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

13.6.Шинэ Зуунмод хотын Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Зөвлөл нь хуралдааны дэг, тэмдэглэл хөтлөх журмыг тогтооно.

14 дүгээр зүйл.Шинэ Зуунмод хотын Захирагч, түүний бүрэн эрх

14.1.Хотын Захирагчийг хотын оршин суугчдаас шууд, чөлөөтэй сонгуулийн үндсэн дээр сонгоно. Хотын Захирагчийн сонгуулийг хуулиар зохицуулна.

14.2.Шинэ Зуунмод хотын Захирагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.2.1.хотын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэл, хөтөлбөрийг боловсруулан Хотын Зөвлөлөөр батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

14.2.2.хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

14.2.3.хотын төсвийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах;

14.2.4.хотын өмчийг хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулж, тэдгээрийг шинээр бий болгох, түрээслэх асуудлыг шийдвэрлэх;

14.2.5.хотын өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааг чиглүүлж, удирдлагыг нь томилж, чөлөөлөх;

14.2.6.хуулиар хүлээлгэсэн хотын чиг үүргийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн тайланг хотын Зөвлөлд тайлагнах, нийтэд мэдээлэх;

14.2.7.бүс нутаг, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хот хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, дэмжлэг үзүүлэх, бусад улсын хоттой холбоо тогтоох, хамтран ажиллах;

14.2.8.хотод байгуулагдсан чөлөөт бүсийн Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх;

14.2.9.хуульд заасан бусад.

14.3.Хотын Захирагч нь бүрэн эрхийнхээ хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргана.

14.4.Хотын Захирагч нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудастай байна.

14.5.Хотын Захирагч нь ажлын алба болон харьяа газартай байна.

14.6.Хотын Захирагчийн ажлын алба (цаашид “Захирагчийн ажлын алба” гэх)-ны бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газар, дүрмийг хотын Захирагч батална.

15 дугаар зүйл.Шинэ Зуунмод хотын Ерөнхий архитектор

15.1.Хотын ерөнхий архитекторын чиг үүргийг Хот байгуулалтын тухай хуулийн 9.3-т заасан этгээд хэрэгжүүлнэ.

15.2.Хотын ерөнхий архитекторыг 4 жилийн хугацаагаар нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр хотын Захирагч томилно.

15.3.Хотын ерөнхий архитектор нь ажлын албатай байна.

15.4.Хотын ерөнхий архитектор нь Хот байгуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.4.1.хот байгуулалт, газар зохион байгуулалтын баримт бичгийг боловсруулах, эрх бүхий этгээдээр батлуулах;

15.4.2.хот байгуулалт, газар зохион байгуулалтын баримт бичгийн хэрэгжилтэнд хяналт тавих;

15.4.3.инженерийн дэд бүтцийн төлөвлөлт, хөгжүүлэлт;

15.4.4.Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпорацийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөмж, дүгнэлт хүргүүлэх;

15.4.5.тухайн жилийн хот байгуулалт, газар зохион байгуулалтын баримт бичгийн хэрэгжилтийг дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор хотын Захирагчид тайлагнах.

16 дугаар зүйл.Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпораци

16.1.Шинэ Зуунмод хотын газар хөгжүүлэлт, менежмент, хэрэгжих бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, хөрөнгө оруулах, төслийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг нийслэл, Төв аймгийн өмчийн оролцоотой Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпораци /цаашид “корпораци” гэх/ хэрэгжүүлнэ.

16.2.Корпораци байгуулах асуудлыг нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

16.3.Корпорацийн төлөөлөн удирдах зөвлөл нь есөн гишүүнтэй байх ба сонгон шалгаруулалтын үндсэн дээр нийслэлийн Засаг дарга томилно.

16.4.Энэ хуулийн 16.3-т заасан төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний таваас доошгүй нь нийслэл хотын, хоёроос доошгүй нь Төв аймгийн, хоёроос доошгүй нь мэргэжлийн, хараат бус, хувийн хэвшлийн төлөөлөл байна.

16.5.Корпорацийн дүрэм, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах журмыг Засгийн газар батална.

16.6.Корпорацийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна:

16.6.1.Эрүүгийн хуульд заасан эдийн засгийн, авлигын, өмчийн эсрэг гэмт хэрэгт шүүхийн шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдож байгаагүй;

16.6.2.гурваас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан, хот байгуулалт, хууль, санхүү, хөрөнгө оруулалт, нягтлан бодох бүртгэл, бизнесийн удирдлага, эдийн засаг, инженерийн мэргэжлээр дээд боловсролтой;

16.6.3.нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, корпорацийн зорилго, ашиг сонирхолд нийцүүлэн ажиллах чадвартай;

16.6.4.сүүлийн найман жил улс төрийн намын удирдах албан тушаал хашиж байгаагүй;

16.6.5.эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан аж ахуйн нэгж байгууллага нь дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон;

16.6.6.Компанийн тухай хуулийн 75.8-д заасан шаардлагыг хангасан байх;

16.6.7.ашиг сонирхлын зөрчилгүй байх;

16.6.8.татварын өргүй байх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ШИНЭ ЗУУНМОД ХОТЫН ЭДИЙН ЗАСАГ

17 дугаар зүйл.Шинэ Зуунмод хотын эдийн засгийн үндэс, тэргүүлэх чиглэл

17.1.Шинэ Зуунмод хотын эдийн засгийн үндэс нь улс, нийслэл, орон нутаг, хотын өөрийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө, түүнчлэн хотын өмч, татварын болон татварын бус орлого, хотын сангийн хөрөнгө, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний хандив, тусламж, бусад орлогоос бүрдэнэ.

17.2.Шинэ Зуунмод хотын эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх, баталгаагаар хангах нь төр, нийслэл, орон нутгийн үүрэг бөгөөд энэ харилцааг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

17.3.Шинэ Зуунмод хот нь эдийн засгийн дараах тэргүүлэх чиглэлтэй байна:

17.3.1.аялал жуулчлал;

17.3.2.тээвэр ложистик;

17.3.3.соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын биет бус өвийн академи;

17.3.4.шинжлэх ухаан, технологи, инноваци;

17.3.5.олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, худалдаа.

18 дугаар зүйл.Төрийн дэмжлэг

18.1.Төрөөс хотын бүтээн байгуулалтад татварын болон татварын бус дэмжлэг үзүүлнэ.

18.2.Улсын Их Хурал хотын бүтээн байгуулалтын хугацаанд буюу 2040 он хүртэл жил бүр улсын төсөвт инженерийн болон нийгмийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт, төрийн байгууллагуудыг үе шаттай нүүлгэн шилжүүлэх зардлын төсвийг тусгаж батална.

18.3.Засгийн газар төрийн байгууллагуудыг үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ.

18.4.Шинэ Зуунмод хот хувийн хэвшилтэй хамтрах, төр, хувийн түншлэлийг хэрэгжүүлэх нөхцөлийг хуулиар тогтоож болно.

18.5.Төрийн зарим чиг үүргийг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу Шинэ Зуунмодын хотын удирдлагад шилжүүлж болно.

18.6.Хотын бүтээн байгуулалтын төсөлд хөнгөлөлттэй зээл олгох бодлогыг дэмжиж хэрэгжүүлнэ.

19 дүгээр зүйл.Нийслэл хот, орон нутгийн дэмжлэг

19.1.Нийслэл хот нь Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтад зориулж холбогдох хууль, журмын дагуу үнэт цаас гаргаж болно.

19.2.Нийслэл, Төв аймаг нь хотын эрчим хүч, дулаан, ус хангамж, ариутгах татуурга, харилцаа холбоо, инженерийн бэлтгэл арга хэмжээ, хог хаягдалтай холбоотой зөвшөөрөл, үйлчилгээг саадгүй үзүүлнэ.

19.3.Нийслэл хот болон Төв аймаг нь хотод дараах дэмжлэгийг үзүүлнэ:

19.3.1.орон нутгийн татвар, төлбөр, хураамжийн хэмжээг өөрөөр тогтоох;

19.3.2.өөрийн мэдлийн өмчийг дагуул хотод хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах асуудлыг шийдвэрлэх;

19.3.3.төрийн үйлчилгээг шуурхай, нэг цонхоор үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

19.3.4.салбарын хяналт, шалгалтыг давхардуулахгүй байх.

20 дугаар зүйл.Хотын төсөв, татвар

20.1.Шинэ Зуунмод хот төсөвтэй байх бөгөөд нийслэлийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.

20.2.Хотын төсвийн орлогын эх үүсвэр нь татварын болон татварын бус орлого, улс, нийслэлийн төсвөөс олгох орлогын шилжүүлэг, санхүүгийн дэмжлэг болон хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

20.3.Нийслэлийн төсвийн орлогын дагуул хотоос эх үүсвэртэй татварын орлогын 80 хувийг Шинэ Зуунмод хотын төсөвт, 20 хувийг Төв аймгийн төсөвт хуваарилна.

20.4.Шинэ Зуунмод хотын төсвийг хотын чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулна.

20.5.Шинэ Зуунмод хотын төсвийн харилцааг энэ хуульд заасан зарчмыг баримтлан Төсвийн тухай хуулиар зохицуулна.

20.6.Шинэ Зуунмод хот татвартай байна. Хотын татварыг Хотын албан татварын тухай хуулиар зохицуулна.

21 дүгээр зүйл.Шинэ Зуунмод хотын өмч

21.1.Шинэ Зуунмод хот нь хотын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор хууль тогтоомжид заасны дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах өмчтэй байна.

21.2.Хуульд өөрөөр заагаагүй бол хөрөнгө оруулалтаар хийсэн инженерийн болон нийгмийн дэд бүтцийг хотын өмчлөлд бүртгэнэ.

21.3.Хотын өмчийн менежментийг Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпораци хэрэгжүүлнэ.

21.4.Шинэ Зуунмод хотын өмчийн харилцааг хуулиар зохицуулна.

22 дугаар зүйл.Шинэ Зуунмод хотын дэд бүтцийн сан

22.1.Шинэ Зуунмод хот нь доор дурдсан үйл ажиллагаанд зарцуулах сантай байна:

22.1.1.инженерийн болон нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх;

22.1.2.нийтийн эдэлбэрийн газрын ашиглалт, хамгаалалт, цэцэрлэгт хүрээлэн, тохижилт, ногоон байгууламж бий болгох.

22.2.Дэд бүтцийн сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

22.2.1.хотын төсвийн орлогын 10 хувь;

22.2.2.Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпорацийн ногдол ашгийн 20 хувь;

22.2.3.Чөлөөт бүсийн аж ахуйн үйл ажиллагааны орлогын 10 хувь;

22.2.4.хуулиар хориглоогүй бусад.

22.3.Энэ зүйлийн 22.1-д заасан санг байгуулах, түүнийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журмыг Хотын зөвлөл тогтоож, түүний хэрэгжилтэд хяналт тавина.

22.4.Энэ зүйлийн 22.3-т заасны дагуу тогтоосон журмыг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу бүртгүүлнэ.

22.5.Шинэ Зуунмод хотын дэд бүтцийн сангаас зээл олгох, өр, авлага үүсгэх, сангийн хөрөнгийг зориулалтын бус үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно.

ТАВДУГААР БҮЛЭГ ХОТЫН БИЗНЕСИЙН ОРЧИН, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

23 дугаар зүйл.Шинэ Зуунмод хотод хөрөнгө оруулах, түүний баталгаа

23.1.Хотод хэрэгжүүлэх төсөл нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 16.1.1-д зааснаас бусад шалгуур хангасан тохиолдолд доор дурдсан салбарт дараах хугацаагаар тогтворжуулалтын гэрчилгээг олгоно:

Хөрөнгө оруулалтын хэмжээ /тэрбум төгрөгөөр/	Тогтворжуулах гэрчилгээ олгох хугацаа /жилээр/	Хөрөнгө оруулалтаа хийж дуусах хугацаа /жилээр/
10-30 хүртэл	5	2
30-50 хүртэл	6	3
50-100 хүртэл	7	4
100-200 хүртэл	8	5
200-300 хүртэл	10	6

23.2.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 20.8-д заасны дагуу хотын бүтээн байгуулалтын хөгжлийн төсөлд 300 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө оруулалт хийх санал гаргасан хөрөнгө оруулагчтай Засгийн газар эрх олгосноор хотын Захирагч гэрээ байгуулна.

23.3.Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд гаалийн, татварын болон татварын бус, худалдан авах ажиллагааны тусгай зохицуулалт үйлчлэх ба хуулиар зохицуулна.

23.4.Шинэ Зуунмод хот дахь төрийн үйлчилгээ нь худалдаа, татвар, бизнес, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх бүртгэл, зөвшөөрлийн цахим нэг цонхны үйлчилгээнд суурилна.

23.5.Шинэ Зуунмод хотод үйл ажиллагаа явуулж байгаа хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээртэй хамтран ажиллах зорилгоор Хөрөнгө оруулагчдын зөвлөлийг хотын Захирагчийн дэргэд байгуулах ба зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хотын Зөвлөл батална.

23.6.Энэ хуулийн 23.5-д заасан Хөрөнгө оруулагчдын зөвлөлийн ажиллах журмыг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

23.7.Хотыг хөгжүүлэх төсөл, арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж болох бөгөөд энэ харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

24 дүгээр зүйл.Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтын гаалийн тусгай зохицуулалт

24.1.Хотын бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд шаардлагатай бараа, материал, тоног төхөөрөмжийг хилийн чанадаас Монгол Улсын хилээр оруулахад Гаалийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хялбарчилсан бүрдүүлэлт хийнэ.

24.2.Хотын бүтээн байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нэвтрүүлсэн барааны бүртгэлийг цахим хэлбэрээр хөтөлнө.

25 дугаар зүйл.Шинэ Зуунмод хотод үзүүлэх татварын дэмжлэг

25.1.Шинэ Зуунмод хотын төсөл, арга хэмжээний бүтээн байгуулалтад зориулж барилгын материал, тоног төхөөрөмж импортолсон иргэн, хуулийн этгээдэд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд заасны дагуу татварын дэмжлэг үзүүлнэ.

26 дугаар зүйл.Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд үзүүлэх татварын бус дэмжлэг

26.1.Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтад чиглэсэн тогтвортой үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс нь дараах татварын бус дэмжлэгийг үзүүлж болно:

26.1.1.цахилгаан, дулаан, түрээсийн төлбөр зэрэг урсгал зардалд дэмжлэг үзүүлэх;

26.1.2.бизнес эрхлэхэд шаардагдах баримт бичиг, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбаршуулах;

26.1.3.бүтээн байгуулалтын ажилд зориулан хөнгөлөлттэй зээлийг тэргүүн ээлжинд олгох;

26.1.4.Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай гадаадаас авах ажиллах хүчний ажлын байрны төлбөрийг чөлөөлөх.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ БУСАД

27 дугаар зүйл.Шинэ Зуунмод хотын удирдлагаас бусад этгээдтэй харилцах

27.1.Шинэ Зуунмод хотын удирдлага нь Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй нийслэлийн Засаг даргаар дамжуулж харилцана.

27.2.Хотод үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь өмчийн хэлбэрээс үл хамааран хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хотын стандартыг мөрдөх, хотын удирдлагаас хуульд нийцүүлэн гаргасан шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

28 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

28.1.Энэ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

28.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

28.3.Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол төсөл хэрэгжүүлэгч нь хотын удирдлагатай байгуулсан гэрээний харилцаанаас үүсэх маргааныг талууд харилцан тохиролцсоны дагуу шүүх, эсхүл арбитраар шийдвэрлүүлнэ.

28.4.Хотын эдэлбэр газар, инженерийн дэд бүтэц, бүтээн байгуулалтад хохирол учруулсан гэм буруутай этгээд нь Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээсэн эсэхээс үл хамааран уг хохирлыг өөрийн хүч хөрөнгөөр арилгах арга хэмжээ авах бөгөөд хэрэв мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн бол үүнтэй холбогдон гарсан зардлыг бүрэн хариуцна. Гэм буруутай этгээд нь төсөл хэрэгжүүлэгч бол төсөл хэрэгжүүлэх эрхийг цуцалж, учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

29 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

29.1.Энэ хуулийг 2024 оны .. дүгээр сарын ..-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны...дугаар
сарын...-ны өдөр

Улаанбаатар
хот

ШИНЭ ЗУУНМОД ХОТЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл.Шинэ Зуунмод хотын байнгын оршин суугчийн тоо 15,000 хүрснээр Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Шинэ Зуунмод хотын Зөвлөл, Захирагчийн сонгуулийг зохион байгуулна.

2 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хугацаанд хотын Зөвлөлийн чиг үүргийг Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпораци гүйцэтгэнэ.

3 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хугацаанд хотын Захирагчийг нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсэг:

“16.6.Нийслэлийн дагуул хотын бүтээн байгуулалтын төсөл нь Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 23.1-д заасан шалгуурыг хангасан тохиолдолд тогтворжуулалтын гэрчилгээг олгоно.”

2/20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэг:

“20.8.Нийслэлийн дагуул хотын бүтээн байгуулалтын төсөлд 300 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчтай түүний гаргасан хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулах орчныг тогтвортой байлгах зорилгоор хөрөнгө оруулалтын гэрээг Засгийн газрын эрх олгосноор дагуул хотын Захирагч байгуулж болно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дах хэсэг, 7 дугаар зүйлийн 7.2 дах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/"5.2.Аймаг, нийслэл, хот, эсхүл аймаг, хот дундын танхим байж болно."

2/"7.2.Аймаг, нийслэл, хот, аймаг, хот дундын танхим нь бие даан үйл ажиллагаа явуулна."

2 дугаар зүйл.Энэ хуулийг Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Чөлөөт бүсийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

"8.2.Хуульд өөрөөр заагаагүй бол чөлөөт бүсийн захирагчийг чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө."

2 дугаар зүйл.Энэ хуулийг Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/38 дугаар зүйлийн 38.1.23 дахь заалт:

"38.1.22.Засгийн газраас энэ хуулийн 40.8-д заасны дагуу тогтоосон төслийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах барилгын материал, тоног төхөөрөмж."

2/40 дүгээр зүйлийн 40.8 дахь хэсэг:

"40.8.Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд туссан техник, эдийн засгийн үндэслэл бүхий барилгажилтын төслийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах барилгын материал, тоног төхөөрөмжийн нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн Засгийн газар гаргаж болно."

2 дугаар зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.7 дахь хэсгийн "Энэ хуулийн 38.1.20, 38.1.22, 40.2, 40.4, 40.6-д заасныг хэрэгжүүлэх" гэснийг "Гаалийн болон бусад татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлөх, үүнтэй холбоотой татвараас чөлөөлөх" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийн "үйлдвэрлэлийн" гэснийг "үйлдвэрлэл, шинэ хотын" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 6.30 дугаар зүйлийн нэрийн “Улаанбаатар хотод” гэснийг “Улаанбаатар хот, дагуул хотод” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “Нийслэл хотын” гэснийг “Нийслэл хот, дагуул хотын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ЧИГЛЭЛ ӨГӨХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн иргэдийн хотын нийтийн аж ахуйн үйлчилгээ, төрийн үйлчилгээ авах эрхийг хангах арга хэмжээ авах;

2/Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулиар төрөөс үзүүлэх дэмжлэгтэй холбогдсон харилцааг зохицуулсан тул хотын бүтээн байгуулалтын хугацаанд буюу 2040 он хүртэл жил бүр улсын төсөвт инженерийн болон нийгмийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт, төрийн байгууллагуудыг үе шаттай нүүлгэн шилжүүлэх зардлын төсвийг тусгаж батлуулах;

3/Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 14.1 дэх хэсэгт заасан хотын Захирагчийн сонгуулийн талаарх хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/, Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн/-нд тус тус даалгасугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

ХОТ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын хүн амын хэт төвлөрөл, хүрээлэн байгаа орчинд үзүүлж буй сөрөг нөлөөг бууруулах, олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн эдийн засгийн тодорхой салбаруудыг тогтвортой хөгжлийн зорилтод нийцүүлэн хөгжүүлэх, хүн амыг эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлалыг дэмжих зорилгоор Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт нийслэлийн дагуул хот "Шинэ Зуунмод" хотыг байгуулсугай.

2.Шинэ Зуунмод хотын эдэлбэр газрын хэмжээг 32,501.3 га-гаар тогтоож, эдэлбэр газрын хил заагийг хавсралт ёсоор баталсугай.

3.“Шинэ Зуунмод” хотын бүтээн байгуулалтын үйл ажиллагааг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Төв аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулан Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Х.Нямбаатар/-т тус тус даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Хот байгуулах тухай” 55 дугаар тогтоолын 1 дэх заалтын ““Шинэ Зуунмод” болон “Майдар” хотыг” гэснийг “Майдар хотыг” гэж, мөн заалтын “олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн эдийн засгийн тодорхой салбаруудыг тогтвортой хөгжлийн зорилтод нийцүүлэн хөгжүүлэх” гэснийг “эдийн засгийн тодорхой салбаруудыг тогтвортой хөгжлийн зорилтод нийцүүлэн хөгжүүлэх” гэж, мөн тогтоолын 2, 3 дахь заалтын ““Шинэ Зуунмод” болон “Майдар” хотуудыг” гэснийг ““Майдар” хотыг” гэж тус тус өөрчилсүгэй.

5.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/, Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн/, Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-нд даалгасугай.

Гарын үсэг

ШИНЭ ЗУУНМОД ХОТЫН ЭДЭЛБЭР ГАЗРЫН ХИЛИЙН ЗААГИЙН ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙН СОЛБИЦОЛ,
ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ

Сумын нэр	Талбайн хэмжээ /га/	Хотын нэр	Талбайн хэмжээ /га/	Цэгийн дугаар	Х	Y
Төв аймаг, Алтанбулаг сум, Сэргэлэн сум	566649.0, 379646.9	Шинэ Зуунмод хот	31501.3	1	106° 42' 59.227" E	47° 41' 55.607" N
				2	106° 45' 21.241" E	47° 41' 46.880" N
				3	106° 45' 21.797" E	47° 41' 46.905" N
				4	106° 45' 21.813" E	47° 41' 46.929" N
				5	106° 45' 21.918" E	47° 41' 46.911" N
				6	106° 47' 38.655" E	47° 41' 53.134" N
				7	106° 49' 23.288" E	47° 41' 53.027" N
				8	106° 50' 16.678" E	47° 41' 49.845" N
				9	106° 53' 18.758" E	47° 41' 13.369" N
				10	106° 54' 20.123" E	47° 41' 1.055" N
				11	106° 54' 52.595" E	47° 40' 54.534" N
				12	106° 55' 10.852" E	47° 40' 50.867" N
				13	106° 55' 11.184" E	47° 40' 50.819" N
				14	106° 55' 4.445" E	47° 40' 33.734" N
				15	106° 55' 18.297" E	47° 40' 22.336" N
				16	106° 55' 19.373" E	47° 40' 21.596" N
				17	106° 55' 34.606" E	47° 40' 12.758" N
				18	106° 55' 35.215" E	47° 40' 12.442" N
				19	106° 55' 50.626" E	47° 40' 5.423" N
				20	106° 55' 51.500" E	47° 40' 5.083" N
				21	106° 56' 4.855" E	47° 40' 0.826" N
				22	106° 56' 20.786" E	47° 39' 55.748" N
				23	106° 56' 51.625" E	47° 39' 49.730" N
				24	106° 56' 51.829" E	47° 39' 49.368" N
				25	106° 56' 53.171" E	47° 39' 28.309" N
				26	106° 57' 30.006" E	47° 39' 31.194" N
				27	106° 58' 26.635" E	47° 39' 35.623" N
				28	106° 58' 37.273" E	47° 39' 36.454" N
				29	106° 58' 50.768" E	47° 39' 37.508" N
				30	106° 59' 17.103" E	47° 39' 40.039" N
				31	107° 0' 33.201" E	47° 39' 45.492" N
				32	107° 0' 35.118" E	47° 39' 20.263" N
				33	107° 0' 35.119" E	47° 39' 20.249" N
				34	107° 0' 35.136" E	47° 39' 20.199" N
				35	107° 0' 45.217" E	47° 38' 50.003" N
				36	107° 0' 47.182" E	47° 38' 43.947" N
				37	106° 58' 4.692" E	47° 38' 12.556" N
				38	106° 55' 34.853" E	47° 38' 0.752" N
				39	106° 55' 29.352" E	47° 36' 36.699" N
				40	106° 52' 46.731" E	47° 34' 18.902" N
				41	106° 52' 38.486" E	47° 34' 9.624" N
				42	106° 52' 8.726" E	47° 33' 36.129" N
				43	106° 49' 25.998" E	47° 30' 32.725" N
				44	106° 48' 57.482" E	47° 30' 50.362" N
				45	106° 47' 44.502" E	47° 31' 35.478" N
				46	106° 47' 18.229" E	47° 31' 51.711" N

				47	106° 46' 18.528" E	47° 32' 28.582" N
				48	106° 44' 25.948" E	47° 33' 38.049" N
				49	106° 44' 24.857" E	47° 33' 38.722" N
				50	106° 44' 24.032" E	47° 33' 39.231" N
				51	106° 44' 19.854" E	47° 33' 41.826" N
				52	106° 44' 18.421" E	47° 33' 42.769" N
				53	106° 44' 16.268" E	47° 33' 44.215" N
				54	106° 44' 13.914" E	47° 33' 45.828" N
				55	106° 44' 12.022" E	47° 33' 47.152" N
				56	106° 44' 10.686" E	47° 33' 48.097" N
				57	106° 44' 2.816" E	47° 33' 53.900" N
				58	106° 43' 57.156" E	47° 33' 58.337" N
				59	106° 43' 54.464" E	47° 34' 0.531" N
				60	106° 43' 51.860" E	47° 34' 2.706" N
				61	106° 43' 49.979" E	47° 34' 4.313" N
				62	106° 43' 46.847" E	47° 34' 7.056" N
				63	106° 43' 39.903" E	47° 34' 13.465" N
				64	106° 43' 34.325" E	47° 34' 18.978" N
				65	106° 43' 29.787" E	47° 34' 23.736" N
				66	106° 43' 27.999" E	47° 34' 25.683" N
				67	106° 43' 26.056" E	47° 34' 27.852" N
				68	106° 43' 24.870" E	47° 34' 29.198" N
				69	106° 43' 23.646" E	47° 34' 30.621" N
				70	106° 43' 22.292" E	47° 34' 32.214" N
				71	106° 43' 21.113" E	47° 34' 33.626" N
				72	106° 43' 19.118" E	47° 34' 36.073" N
				73	106° 43' 16.330" E	47° 34' 39.626" N
				74	106° 43' 14.755" E	47° 34' 41.699" N
				75	106° 43' 13.970" E	47° 34' 42.749" N
				76	106° 43' 13.580" E	47° 34' 43.274" N
				77	106° 42' 54.593" E	47° 35' 14.814" N
				78	106° 42' 3.963" E	47° 37' 24.840" N
				79	106° 42' 2.016" E	47° 37' 29.862" N
				80	106° 41' 50.372" E	47° 38' 0.066" N
				81	106° 41' 37.107" E	47° 38' 34.463" N
				82	106° 41' 28.594" E	47° 38' 52.282" N
				83	106° 41' 20.161" E	47° 39' 5.329" N
				84	106° 41' 11.191" E	47° 39' 16.668" N
				85	106° 40' 46.941" E	47° 39' 36.321" N
				86	106° 40' 25.757" E	47° 39' 53.484" N
				87	106° 40' 11.634" E	47° 40' 4.925" N
				88	106° 39' 43.785" E	47° 40' 27.196" N
				89	106° 39' 15.998" E	47° 40' 48.183" N
				90	106° 38' 58.301" E	47° 41' 1.694" N
				91	106° 38' 38.248" E	47° 41' 16.899" N
				92	106° 38' 12.589" E	47° 41' 36.332" N
				93	106° 37' 52.963" E	47° 41' 49.292" N
				94	106° 37' 37.978" E	47° 41' 57.421" N
				95	106° 37' 12.615" E	47° 42' 8.486" N
				96	106° 36' 50.461" E	47° 42' 15.880" N
				97	106° 36' 25.518" E	47° 42' 22.433" N
				98	106° 36' 1.486" E	47° 42' 28.569" N
				99	106° 35' 34.358" E	47° 42' 35.494" N

				100	106° 35' 4.115" E	47° 42' 43.211" N
				101	106° 34' 30.609" E	47° 42' 51.757" N
				102	106° 34' 3.859" E	47° 42' 58.705" N
				103	106° 34' 21.304" E	47° 43' 12.987" N
				104	106° 35' 34.732" E	47° 44' 11.588" N
				105	106° 35' 34.636" E	47° 44' 11.673" N
				106	106° 37' 10.820" E	47° 44' 41.403" N
				107	106° 40' 49.414" E	47° 42' 3.540" N
				108	106° 40' 57.676" E	47° 42' 3.036" N
				109	106° 41' 40.505" E	47° 42' 0.423" N
				110	106° 42' 59.227" E	47° 41' 55.607" N
Төв аймаг, Сэргэлэн сум	379646.9	Шинэ Зуунмод хот (Төр, захиргааны нэгдсэн цогцолбор)	1000.0	1	645889.0000	5291548.0000
				2	647187.5620	5289679.5080
				3	647775.1697	5289589.0338
				4	647969.1681	5288858.7394
				5	647058.2047	5287377.9492
				6	646128.8316	5287868.3240
				7	645018.7405	5287920.7953
				8	644634.0358	5287219.4963
				9	644206.6635	5290770.1276
Нийт			32501.3			

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

НИЙСЛЭЛ ХОТЫН ШИНЭ ЗУУНМОД ДАГУУЛ ХОТЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

УРЬДЧИЛСАН ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА	
Товчилсон үгийн жагсаалт	3
НЭГ.УДИРТГАЛ.....	4
1.1.Судалгааны зорилго:.....	4
1.2.Судалгааны арга зүй:	5
1.3.Судалгааны баг, тайлангийн бүтэц:	5
ХОЁР.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ.....	6
2.1.Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:	8
2.2.Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийг тодорхойлсон байдал:	17
2.3.Асуудлыг үүсгэж байгаа шалтгаан нөхцөл:	17
ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ	18
3.1.Шинэ Зуунмод дагуул хотыг байгуулснаар дараах эерэг үр дагавартай байна гэж үзлээ. Үүнд:.....	20
3.2.Шинэ Зуунмод дагуул хотод байгуулах эдийн засгийн тусгай бүс:	20
ДӨРӨВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ.....	21
4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө:.....	21
4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө:.....	24
4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө:	27
4.4 Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө:	30
4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх:	32
ТАВ. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА.....	33
ЗУРГАА.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	47
ДОЛОО.АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	49

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АН-З	Азийн хурдны зам - 3
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ЗГ	Засгийн газар
ЖАЙКА	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
ТЭЗҮ	Техник Эдийн Засгийн Үндэслэл
ТХХТ	Төр, хувийн хэвшлийн түншлэл
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний Статистикийн хороо
ЭЗТБ	Эдийн засгийн тусгай бүс
ЭЗЧБ	Эдийн засгийн чөлөөт бүс

НЭГ.УДИРТГАЛ

Сүүлийн жилүүдэд эдийн засаг, нийгмийн хөгжил эрчимтэй явагдсантай холбоотойгоор олон эерэг үр дүн гарсны зэрэгцээ тодорхой бэрхшээл тулгарч байна. Тухайлбал, хот байгуулалт, төлөвлөлтийн эрх зүйн баримт бичгүүдийг бүрэн мөрдөөгүйгээс болж замбараагүй барилгажилт, хүрээлэн буй орчин, иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчин нөхцөлд сөрөг үр дагавар бий болсоор байна.

Түүнчлэн хот, хөдөөгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн ялгаатай байдлаас болж хөдөө орон нутгаас хот, суурин газрууд руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн эрчимтэй нэмэгдэж Монгол Улсын нийт хүн амын 60 гаруй хувь нь буюу 2.2 сая хүн хот суурин газарт, үүнээс 1.4 сая хүн ам буюу нийт хүн амын 45% нь зөвхөн Улаанбаатар хотод амьдарч байна. Үүнтэй холбоотойгоор хот, суурин газарт амьдарч байгаа иргэдийн амьдралын түвшний ялгаа нэмэгдэж, нийслэлд гэр хорооллын газар нутаг өргөжин, улмаар хүрээлэн буй орчны бохирдлыг нэмэгдүүлж, оршин суугчдын тав тух, эрүүл мэндэд нөлөөлж нийгмийн олон сөрөг үзэгдлийг бий болгож байна.

Нийслэл хот руу шилжих хөдөлгөөнийг дагаад хөдөө орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжил саарч, зах зээл нь хумигдаж байгаа нь бүс нутгийг тэнцвэртэй хөгжүүлэх бодлогод сөрөг нөлөө үзүүлж байна. Тухайлбал 2008 онд Монгол Улсын ДНБ-ий 54.8%-ийг Улаанбаатар хотод үйлдвэрлэж байсан бол энэ үзүүлэлт тогтмол өссөөр 2018 онд 66.6%¹, 2023 онд 69.2% болж жил бүр өсөж байна.

Улаанбаатар хотын хүн амын өсөлт нь хот байгуулалт, төлөвлөлт, байгаль орчин, экологийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, төлөвлөлтгүй суурьшил бий болох, гэмт хэрэг, зөрчил ихсэх, замын хөдөлгөөнд хэт түгжрэл үүсэх, хүн амын эрүүл мэнд, нийгмийн халамж, үйлчилгээний салбар доголдох зэргээр эдийн засаг, нийгмийн бүх талын харилцаанд хүндрэл учирч байгаатай холбоотойгоор сүүлийн жилүүдэд дагуул хот, суурин газрыг шинээр байгуулах замаар нийслэлийг хөгжүүлэх талаар төрөөс хэд хэдэн бодлогын баримт бичиг батлагдаад байна.

Иймээс Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон холбогдох бусад бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдлыг багасгах, орон нутгийг бүсчлэн хөгжүүлэхийн тулд нийслэл хотын хүн ам, эдийн засаг, нийгмийн төвлөрлийг задлах, сааруулах, Монгол Улсын хотуудын эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх замаар тухайн хотуудын оршин байгаа бүс нутгийг хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаатай хандах, тухайн харилцааг заавал хуулиар зохицуулах шаардлагатай эсэх, хэрэгжүүлэх боломж нөхцөл, холбогдон гарах зардал, хууль зүй, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх нөлөөг сайтар судлах, хуулийн хэрэгцээ шаардлагыг тандан судлахаас эхлээд төсөл боловсруулах үе шатыг тодорхойлохоор заасны дагуу Шинэ Зуунмод дагуул хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагыг тандан судаллаа.

1.1.Судалгааны зорилго:

¹ <http://ubstat.mn/StatTable=372>

Нийслэлийн Шинэ Зуунмод (Аэро сити) дагуул хотын эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажлын зорилго нь нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэх, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, хүн амын эрүүл, аюулгүй, амар тайван орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хүний эдийн засаг, нийгэм, соёлын эрх, эрх чөлөөг хангасан дагуул хотыг хөгжүүлэхүйц эрх зүйн орчинг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилготой.

Нийслэл хотын нийгэм, эдийн засгийн харилцаанд тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлж, дагуул хот байгуулах шаардлагатай эсэх, мөн түүнчлэн бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэх, орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд дагуул хотын эрх зүйн зохицуулалтын үзүүлэх үр нөлөөг тодруулахыг зорилоо.

Түүнчлэн эерэг болон сөрөг талыг харьцуулан судалсны үндсэн дээр үр нөлөөг урьдчилан тооцож, уг асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг санал болгоход судалгааны зорилго чиглэнэ.

1.2.Судалгааны арга зүй:

Энэхүү судалгааг гүйцэтгэхэд Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасан шаардлага болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ыг баримталж, тогтоосон үе шатуудын дагуу судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Үүнд:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Асуудал шийдвэрлэх зорилгыг томъёолох;
3. Асуудал зохицуулах хувилбаруудыг тогтоож, харьцуулан судлах;
4. Хуулийн зохицуулалтын үр нөлөөг ерөнхийд нь тандан судлах;
5. Зөвлөмж боловсруулах.

Дээрх үе шатны дагуу Шинэ Зуунмод дагуул хот байгуулах тухай ойлголт, харилцааг судалж, Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эх сурвалж, олон улсын хууль тогтоомж, баримт бичиг, холбогдох ном, сурах бичиг, өмнө хийгдсэн судалгаа, судалгааны тайлан, илтгэл, өгүүлэл уншиж, судлах, харьцуулалт хийх болон бусад статистик мэдээллийг ашигласан бөгөөд асуудлын мөн чанар, түүний хамрах хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй нийгмийн бүлэг бий эсэх, шалтгаан нөхцөлийг тодорхойлов.

Энэхүү судалгааг хийхдээ нийслэл хотын талаар авч хэрэгжүүлж байгаа төрийн бодлого, түүний хэрэгжилт, бусад улс орны дагуул хотын эрх зүйн байдал, хот байгуулалтын талаарх зохицуулалт зэргийг судлахын сацуу холбогдох мэргэжлийн байгууллага, судлаачдаас зөвлөмж, мэдээлэл авлаа.

1.3.Судалгааны баг, тайлангийн бүтэц:

Судалгааны ажлыг Нийслэлийн дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газрын албан хаагчид гүйцэтгэлээ.

Энэхүү судалгааны тайланг удиртгал, дүн шинжилгээ, асуудлыг шийдвэрлэх зохицуулалтын хувилбар (томъёолол), зохицуулалтын хувилбаруудын үр нөлөө,

олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа, дүгнэлт, зөвлөмж гэсэн үндсэн 6 бүлгийн хүрээнд хийж гүйцэтгэн, ашигласан эх сурвалжаа тодорхойллоо.

ХОЁР.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”, Хорин тавдугаар зүйлийн 1.7-т “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна...” гэж тус тус заасан боловч сүүлийн жилүүдэд нийслэл Улаанбаатар хотод хэт төвлөрөл бий болсноос энэхүү Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэний үндсэн эрх зөрчигдөх, хөндөгдөх нөхцөлийг бүрдүүлж байна.

Энэ талаар төрөөс анхаарч Улсын Их Хурлаас дараах бодлогын баримт бичгийг үе шаттайгаар батлан гаргаж, бүсчилсэн хөгжил, Улаанбатаар хотын хөгжлийн чиг хандлага, дагуул хот байгуулах талаар бодлого, чиглэлийг тодорхойлж ирсэн нь нийслэлийн дагуул хот байгуулах хууль зүйн үндэслэл болж байна. Үүнд:

- Улсын Их Хурлын 2012 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” баримт бичигт Улаанбаатар хотын ундны усны нөөц, байгаль, экологийн тэнцвэрт байдлыг хангах, хүн амын өсөлтийг залж чиглүүлэх хандлагыг баримтлан Улаанбаатарын бүсийн түвшинд дагуул, хаяа хот, тосгодыг жигд, тэнцвэртэйгээр эрчимтэй хөгжүүлж хэт төвлөрлийг сааруулах зорилгоор Хөшигийн хөндийд баригдах шинэ нисэх онгоцны буудлыг даган хөгжих шинэ хотыг байгуулахаар төлөвлөсөн;
- Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баримт бичгийн 2.1.5-д “Хөшигийн хөндийд тээвэр логикийн төв байгуулж, Хөшигийн хөндийн нисэх буудлыг бүс нутгийн зангилаа төв болгон хөгжүүлэх”-ээр тодорхойлсон;
- Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго 9-д Улаанбаатар хотыг “Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлэх” зорилгыг дэвшүүлж, түүнийг хэрэгжүүлэх зорилт, үе шат, хүрэх үр дүнг нарийвчлан тодорхойлж, Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт баригдаж буй Улаанбаатар олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн Шинэ Зуунмод /Аэросити/ дагуул хотыг байгуулахаар төлөвлөсөн;
- Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 6.1-д “Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ.”, 6.2-т “Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.” гэж заасан;
- Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 4.2-т “Шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон

нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулна.” гэж тусгасан гэх мэт.

Ийнхүү дагуул хот байгуулах замаар нийслэл Улаанбаатар хотын тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэхээр дээр дурдсан бодлогын баримт бичгийг батлан гаргасан боловч дагуул хотыг хэрхэн байгуулах, түүний удирдлага зохион байгуулалт, чиг үүрэг нь ямар байх, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжтэйгээ хэрхэн харилцах зэрэг олон асуудал тодорхойгүй, тэдгээрийг зохицуулсан хуулийн зохицуулалт хангалтгүй явж ирсэн.

Улсын Их Хурал 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийг батлан гаргаж дагуул хот байгуулах талаар тодорхой хэмжээгээр зохицуулалт тусгагдсан нь дээр дурдсан бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлж эхлэх эрх зүйн орчныг бий болгосон. Тухайлбал, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 4.3-т “Нийслэл хот нь дагуул хоттой байна.”, 34.1-д “Нийслэл хотын дагуул хот нь нийслэл хоттой эдэлбэр газар, хүн ам, эдийн засаг, дэд бүтэц, тээвэр логистикийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, газар зүйн байрлал болон нийслэл хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэхэд стратегийн ач холбогдолтой хот бүрдүүлэгч дэд бүтэц бүхий суурин газар мөн”, 34.2-т “Дагуул хотыг нийслэлийн болон бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид, эсхүл хэд хэдэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид дамнан байгуулж болно.”, 35.1-д “Дагуул хотыг стратегийн ач холбогдол бүхий нөхцөлийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал байгуулна” гэж хуульчилсан.

Гэвч эдгээр зохицуулалт нь ерөнхий, дагуул хотыг дэлхийн бусад хотуудын жишгээр байгуулах, хөгжүүлэх, бүтэц зохион байгуулалт, удирдлага, бүтээн байгуулалттай холбоотой асуудлыг зохицуулсан зохицуулалт хангалттай бус байгаа тул дагуул хотыг байгуулах, эрх зүйн байдалтай холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгож, нийслэлийн дагуул хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулах нь гол хууль зүйн үндэслэл болж байна.

Мөн дээр дурдсан бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Засгийн газрын 2012 оны 217 дугаар тогтоол, 2022 оны 143 дугаар тогтоолоор Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тус тус баталсан ба энэхүү төлөвлөгөөгөөр Хөшигийн хөндий, Улаанбаатар олон улсын нисэх онгоцны буудлын талбай орчмын үүргийн бүсчлэлийг нарийвчлан тогтоож, олон улсын ачаа тээврийн логистикийн төв, чөлөөт бүс, засаг захиргаа, арилжааны зэрэг эдийн засгийн томоохон төв байхаар төлөвлөсөн байна.

Судалгааны хүрээнд хууль тогтоомжийн хоорондын уялдаа холбоо, хүний эрхийг хангахад чиглэсэн үндсэн зарчим, нийслэл Улаанбаатар хотод амьдрахад аятай таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, нийгэм, эдийн засгийн өсөлтийг бий болгох үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх, түүний ач холбогдол, эерэг болон сөрөг тал, дагуул хот байгуулах шаардлагатай эсэхийг судлан үзлээ.

Үүний тулд аргачлалын 3-т заасны дагуу дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн,

аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, асуудлыг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

2.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

Шинэ Зуунмод дагуул хот байгуулах, түүний эрх зүйн байдлыг хуулиар тодорхойлох хэрэгцээ шаардлагыг манай улсын хотжилт, түүний дотроос нийслэл хотын нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, хүн амын амьдралын чанар, дэд бүтцийн хангамж зэрэг асуудлыг тухайлан шинжлэн судалж тодорхойлов.

Хотжилт ба хүн амын амьдралын чанарт хийсэн дүн шинжилгээ:

Монгол Улсад хотжих үйл явц өнгөрсөн зууны хоёрдугаар хагаст хурдацтай өрнөж, үүнээс хойш өнөөг хүртэл нийт хүн амд хотын хүн амын эзлэх хувь өссөөр байна. Үндэсний статистикийн хорооны 2018 онд Монгол Улсын нийт хүн ам 3.2 сая бөгөөд үүнээс 2.2 сая хүн ам буюу 67% нь хот суурин газарт, үүний 1.4 сая буюу 45% нь Улаанбаатар хотод амьдарч байсан бол 2023 оны байдлаар нийслэлийн оршин суугчдын тоо 1,596,335 буюу манай улсын нийт хүн амын 47.4% хувьтай тэнцэх болсон.

1990 онд манай улсын нийт хүн амын 55.8 хувь нь хотынх байсантай харьцуулахад энэ үзүүлэлт нэлээн нэмэгдсэн байна. Түүнчлэн Улаанбаатар хотод манай улсын их дээд сургуулиудын 88.5 хувь нь байршиж, түүнд нийт оюутан сурагчдын 95.3 хувь нь суралцаж байгаа төдийгүй Монгол Улсын эдийн засгийн идэвхтэй хүн амын 39.7 хувь нь төвлөрчээ.

Өнөөгийн байдлаар манай улсад 1,0 саяас дээш хүн амтай хот 1 (Улаанбаатар), 50.0-100.0 мянган хүн амтай хот 2 (Дархан, Эрдэнэт), 20.0-50.0 мянган хүн амтай хот 12, 20.0 мянга хүртэл хүн амтай хот 7 байна.

Хотжилтын түвшин	Тоо	Хотын нэр
1,0 саяас дээш хүн амтай хот	1	Улаанбаатар
100,000 - 1,000,00 хүн амтай хот	1	Орхон
50,000 - 100,000 хүн амтай хот	1	Дархан
20,000 - 50,000 хүн амтай хот	12	Өлгий, Улаангом, Ховд, Цэцэрлэг, Баянхонгор, Арвайхээр, Хөвсгөл, Сайншанд, Даланзадгад, Сүхбаатар, Чойбалсан, Өндөрхаан
20,000 хүртэл хүн амтай хот	7	Алтай, Улиастай, Булган, Говьсүмбэр, Мандалговь, Зуунмод, Баруун-Урт

Ийнхүү хот, суурин газруудад хүн амын дийлэнх хэсэг төвлөрөн суурьшсантай холбоотойгоор хүн амын нягтрал хот, хөдөөд хэт ялгаатай болсон байна. Тухайлбал 2018 оны байдлаар Улаанбаатар хотын хүн амын нягтрал 317.3 болж улсын дунджаас 151 дахин өндөр болсон байна².

Нийслэл Улаанбаатар хотын ногоон байгууламж нь нийт газар нутгийн 0.06 хувийг, Дархан хотын ногоон байгууламж нь 1.45 хувийг тус тус эзэлж байгаагаас

² www.1212.mn

гадна Улаанбаатар хотод нэг хүнд 1.89 м² ногоон байгууламж оногдож байгаа бол Дарханд 19.3 м² ноогдож байна.

Улаанбаатар хотод суурьшиж байгаа хүн ам, өрхийн түүхэн динамикаас харахад жил ирэх тусам өсөн нэмэгдэж ирсэн бөгөөд Үндэсний статистикийн хорооноос гаргасан хүн амын тооны төсөөллийн дагуу цаашид ч Улаанбаатар хотод шинээр суурьших хүн ам, өрхийн тоо өсөх хандлагатай байна.

Хүн амын тооны төсөөлөл (мянга)³ (Эх сурвалж: ҮСХ)

Он	Нийт хүн ам	Улаанбаатар хотын хүн ам	Эзлэх хувь %
2020	3,151.1	1,668.8	53.0%
2025	3,377.5	1,903.6	56.4%
2030	3,576.9	2,103.2	58.8%
2035	3,768.1	2,280.2	60.5%
2040	3,947.0	2,441.7	61.9%

Энэхүү төвлөрлийг сааруулах зорилгорт шинэ суурьшлыг бий болгох зорилго, зорилт дэвшүүлж байгаа бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах нэг арга хэмжээ нь Шинэ Зуунмод дагуул хотыг байгуулах арга хэмжээ юм. Энэ зорилгын хүрээнд Шинэ Зуунмод хотын хүн ам зүйн үзүүлэлтийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт.Шинэ Зуунмод хотын хүн ам зүйн үзүүлэлт⁴

№	Хүн ам зүйн үзүүлэлт	2020	2025	2030	2040
1	Хүн амын тоо		5,944	23,159	34,000
2	Өрх тоо		1,899	7,399	10,858
3	1 өрхөд ногдох хүн		3.13	3.13	3.13
4	Хүн амын өсөлт:		5,944	17,215	10,841
	- Ердийн өсөлтөөр			491	4,252
	-Механик хөдөлгөөнөөр		5,944	16,724	6,589
5	Хөдөлмөрийн насны хүн ам		4,042	16,211	23,984
6	Ажиллагсад		3,447	13,201	13,586
7	Ясли-цэцэрлэг хүүхэд		654	2,474	3,633
8	Сургууль хүүхэд		1,283	4,999	7,339
9	Тэтгэвэр иргэд		747	2,909	4,271

Өрхийн орлого:

Монгол Улсын нэг өрхийн сарын дундаж орлого 2020 онд 1,482,690 төгрөг, 2021 онд 1,568,690 төгрөг, 2022 онд 1,786,656 төгрөг байсан бол 2023 онд 2,100,000 төгрөг, үүний голлох хэсгийг цалин, тэтгэвэр, тэтгэмж эзэлдэг байна.

Ажлын байрны тоо:

³Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх хүн амын хувьд тооцсон төрөлтийн дундаж бууралттай үеийн хүн амын тооны төсөөлөл.

⁴ Засгийн газрын 2022 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө. Боть-II: Төлөвлөлтийн шийдэл, хэрэгжүүлэх үе шатны төлөвлөгөө, 39 дэх талд, УБ.,2022 он.

Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр тус хотын эдэлбэр газрыг 8 бүстэй байхаар төлөвлөж уг бүсийн үүрэг, зориулалтаас нь хамаарч бий болох ажлын байрны тоог тооцоолсон байх ба 2040 оны байдлаар 80,000 гаруй ажлын байрыг Шинэ Зуунмод дагуул хотод бий болгохоор төлөвлөсөн байна.

Мөн Шинэ Зуунмод хот нь төлөвлөлтийн шийдлээсээ хамаарч 10.5 сая м2 талбай бүхий барилгажилт, бүтээн байгуулалтын ажил явагдаж, 80 мянга орчим ажлын байрыг шинээр бий болгохоор төлөвлөсөн байх ба нийт ажлын байрны 13.3 мянга нь Шинэ Зуунмод хотоос, үлдсэн 67.3 мянга нь Хөшигийн хөндийн бусад суурьшлын төвүүд, Улаанбаатар хот, Төв аймгаас хангагдана гэж үзжээ.

Хүснэгт. Барилгажилт ба ажлын байр⁵

Барилгажилт төрөл	Ажлын байр тоо	Үйлчлүүлэгч тоо/хоног	Барилгажилт
Орон сууц	217		871,113
Нийгмийн дэд бүтэц	2,158	38,328	170,688
Олон нийт	34,001	101,712	2,744,440
Их сургуулийн хотхон	3,900	49,500	580,000
Өндөр технологи, хөнгөн үйлдвэр бүс	6,200	6,300	420,000
Үйлдвэрийн бүс	5,200	-	520,000
Худалдааны бүс	3,360	25,500	366,000
Логистик бүс	2,500	-	250,000
Хөдөө аж ахуй /хүлэмж ба модны аж ахуй/	140	-	70,000
Карго төв	1,100		220,000
ХӨСҮТ-2	1,000		60,000
Чөлөөт бүс	21,139	84,556	4,227,779
Бүгд	80,913	305,895	10,500,000

Хөшигийн хөндийн түүхийн өв, дурсгалт зүйл, олон улсын нисэх онгоцны буудал, Майдар хотын бүтээн байгуулалттай холбоотойгоор аялал жуулчлал, амралтын бүс нэмж төлөвлөх нь ач холбогдолтой байна.

Газар зүйн байрлал, дэд бүтцийн хангамжид хийсэн дүн шинжилгээ:

Байгуулахаар төлөвлөж, эрх зүйн байдлыг нь тодорхойлох гэж буй нийслэлийн Шинэ Зуунмод дагуул хот нь Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт, одоо үйл ажиллагаа явуулж байгаа Улаанбаатар хотын Олон улсын нисэх буудлыг даган хөгжих бөгөөд газар зүйн байрлалын хувьд Улаанбаатар хотоос 53 км, Төв аймгийн Зуунмод хотоос баруун урагш 10 км-т байрлаж байна.

Засгийн газрын 2012 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Төв аймгийн Хөшигийн хөндийд баригдах нисэх онгоцны буудлыг даган хөгжих шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг нийт 1,350 га, цаашид өргөжин тэлэхэд зориулж 600 га нөөц талбайтай байхаар баталсан бол Засгийн газрын 2019 оны 29 дүгээр, 2022 оны 143 дугаар тогтоолоор тус тус энэхүү хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн баталсан боловч газар зүйн байрлалын хувьд өөрчлөлт ороогүй байна.

Мөн шинээр байгуулах хотын бүтээн байгуулалттай холбоотойгоор Засгийн газрын 2010 оны 140 дүгээр тогтоолоор тухайн байрлалд 12,000 га газрыг улсын

⁵ Засгийн газрын 2022 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө. Боть-II: Төлөвлөлтийн шийдэл, хэрэгжүүлэх үе шатны төлөвлөгөө, 41 дэх талд, УБ., 2022 он.

тусгай хэрэгцээнд авсан бөгөөд энэхүү газрын хэмжээ, хил заагт 2016⁶ онд өөрчлөлт орж 12,084.9 га болж нэмэгдүүлсэн байна. Мөн Засгийн газрын 2022 оны 377 дугаар тогтоолоор Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газрын зориулалтаар 20 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, газрын хилийн заагийн эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээг баталсан байна.

Шинээр төлөвлөж буй Шинэ Зуунмод хотын 31000 га нутаг дэвсгэрийг үүрэг зориулалтаар нь хот төлөвлөлтийн үндсэн 7 бүсэд хувааж хөгжүүлэхээр төлөвлөсөн байх ба эдгээр бүс нь газар нутгийн гадаргуугийн налуу, бусад хот төлөвлөлтөд нөлөөлөх хүчин зүйлсээс хамаарч, барилгажилтыг хязгаарлах, эсхүл дэмжих, нутаг дэвсгэрт хуваагдаж байна.

Зураг.Архитектур, орон зайн төлөвлөлт



- Орон сууц, олон нийтийн бүс 2134 га;
- Үйлдвэрийн бүс 1970 га;
- Инженерийн шугам сүлжээ ба зам тээврийн бүс 3500 га;
- Ногоон байгууламж, амралт зугаалгын бүс 16000 га;
- ХАА-н үйлдвэрлэлийн бүс 300 га;
- Тусгай зориулалтын бүс 100 га талбайг хамарч байна.

Эдгээр нөхцөл байдлаас дүгнэж үзвэл шинээр байгуулах Шинэ Зуунмод дагуул хот эдэлбэр газартай байх, түүний хэмжээ хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлогдсон байх хуулийн шаардлагад нийцэж байна⁷ гэж үзлээ.

Мөн Засгийн газрын 2021 оны 234 дүгээр тогтоолоор Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааг байгуулсан, УИХ-ын 2022 оны 10 дугаар тогтоолоор Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж тухайн газар нутагт дэд бүтцийг бий болгох талаар багагүй ажил хийгдсэн байна.

⁶ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 154 дүгээр тогтоол;

⁷ Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 34.3 дахь хэсэг, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйл.

Дагуул хотын инженерийн болон нийгмийн дэд бүтцийн хангамжийн асуудлыг одоо байгаа болон ирээдүйд бий болгохоор төлөвлөсөн байдлаар нь авч үзлээ.

1.Авто зам: Төрөөс Алтанбулагаас Замын үүд хүртэл Азийн олон улсын, Богдхан уулыг тойруулан цагирган хурдны замыг тус тус барьж байгуулахаар төлөвлөсөн байна. Үүнд:

- 992 км урт Азийн олон улсын хурдны зам нь Монгол Улсын хойд хилээс өмнөд хилийн хот болох Замын-Үүд хүртэл баригдах ба ШИНЭ ЗУУНМОД ХОТ энэ хурдны замд холбогдох бөгөөд энэ нь тус хотыг дотоод, гадаадын зах зээлтэй холбох эдийн засаг, нийгмийн чухал хөшүүрэг болох юм.

- Богдхан уулыг тойруулан барьж байгуулах 109 км урт цагираг хэлбэрийн хурдны зам нь Улаанбаатар хотын дагуул хотууд, олон улсын шинэ нисэх онгоцны буудал болон Төв аймгийг холбох ба энэхүү хурдны замтай манай улсын бусад аймаг, бүс нутгуудтай холбогдохоор төлөвлөгдсөн байна. Одоогоор энэхүү хурдны замын Буянт-Ухаа 2 хорооллын урд хэсгээс Хөшигийн хөндий дэх Улаанбаатар хотын Олон улсын нисэх буудал хүртэл бүрэн баригдаж ашиглалтад орсон ба ШИНЭ ЗУУНМОД хот нь энэхүү хурдны замтай холбогдсон байна.

2.Төмөр зам: Улаанбаатар хот, олон улсын шинэ нисэх онгоцны буудалтай холбох Богдхан уулын урдуур тавигдах шинэ төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх, үндэсний болон олон улсын тээвэр, логистикийн сүлжээг хөгжүүлж, “Хөшиг”-ийн хөндийд холимог тээвэр логистикийн төв байгуулахаар Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны уйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдан зарим судалгааны ажлууд хийгдсэн байх бөгөөд энэхүү төмөр замыг барьж байгуулснаар дагуул хотод хөнгөн үйлдвэрлэлийн эдийн засгийн тусгай бүсийг хөгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой байна.

3.Усан хангамж: Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд усны нөөц, унд, ахуйн усны зарцуулалтыг хэмнэх, дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн саарал усыг ашиглах цогц системийг төлөвлөсөн нь усан хангамжид эерэгээр нөлөөлөх хүчин зүйл болж байна. Мөн гадаргын болон хур борооны ус, цэвэрлэх байгууламжийн саарал усыг нисэх буудлын технологийн хэрэгцээнд ашиглахаар төлөвлөсөн⁸ нь усан хангамжинд эерэг нөлөөтэй байна.

Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлсон талбай нь гадаргын болон газрын доорх усны нөөц харьцангуй багатай нутаг дэвсгэрт хамаарч байна.

2007 онд Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлын унд ахуйн ус болон технологийн ус хангамжийн эх үүсвэр тодорхойлох газрын доорх усны хайгуул судалгаагаар $Q=45.4$ л/с ашиглалтын нөөцийг тогтоосон бол Зуунмод хотын унд-ахуйн ба техникийн төвлөрсөн усан хангамжийн өнөөгийн эх үүсвэрийн ашиглалтын нөөц баялгийг 73.55 л/с-ээр тогтоож байжээ.

Нийт төлөвлөлтийн хугацаанд шаардагдах ус хангамжийн хэрэглээг баруун эх үүсвэрээс хангахаар төлөвлөсөн байна. “Баруун” эх үүсвэр нь 2026 оноос ашиглалтад орох бөгөөд эхний ээлжинд Улаанбаатар хотын баруун урд хэсгийн

⁸ Засгийн газрын 2022 оны 143 дугаар батлагдсан Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө.

суурьшилд 35000м³/хон цэвэр ус нийлүүлэх боломжтой байна. Төлөвлөлтийн эхний ээлж буюу 2025 оны түвшинд хэрэгжих барилга байгууламжийн ус хангамжийн хэрэглээг Хөшигийн хөндийн нисэх онгоцны шинэ буудлын ус хангамжийн эх үүсвэрийн судалгаа хийгдсэн талбай, Зуунмод хотын ус хангамжийн эх үүсвэрийн судалгаа хийгдсэн талбайд шинээр цооног гарган ашиглах тооцооллыг тусгасан байна. Тус ус хангамжийн эх үүсвэрийн судалгаанаас батлагдсан нөөцөөс одоо Олон улсын "Чингис Хаан" шинэ нисэх онгоцны буудлын ус хангамжид 3 цооног ашиглаж байгаа ба хүчин чадал нь 1100м³/хон. Зуунмод хотын одоо ашиглаж байгаа 5 цооногоос 1200м³/хон усыг олборлож байна. Урьдчилсан тооцооллоор 3500м³/хон ус олборлох боломжтой гэж тооцжээ.

Эдгээр эх үүсвэрүүдээс Шинэ Зуунмод хотын суурьшлын бүсэд 2х1000м³ усан сан, логикийн төвийн 2х500м³ хүчин чадалтай усан сангуудыг хангана. Төлөвлөж буй усан сангаас төлөвлөлтийн бүс, дулааны эх үүсвэр хүртэл ф250мм-ийн голчтой 60.9 км-тай байхаар төлөвлөсөн байх бөгөөд төлөвлөлтийн хугацаанд Шинэ Зуунмод хотын унд ахуйн усны хэрэглээ 37744.2м³/хоног, 1887м³/цаг, 524.2л/сек байхаар тооцоолжээ.

4.Эрчим хүчний хангамж: Шинэ Зуунмод хот нь Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт байрлаж, Төв аймгийн төвөөс 10 км, нийслэлээс 53 км-т байрлаж байгаа тул Төв аймаг болон, нийслэлийн Хан-Уул дүүргийн эрчим хүчний эх үүсвэрүүдээс эрчим хүчээр хангагдах боломжтой байх бөгөөд "Олон улсын Чингис хаан нисэх онгоцны буудал"-ыг түшиглэн бий болох Богд хаан төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр, логикийн нэгдсэн төв, Хөшигийн хөндийд байгуулагдах хотуудын хүн ам, барилгажилтын урьдчилсан тооцооллыг үндэслэн төлөвлөлтийн бүсийн нийт цахилгаан ачаалал 124.5 МВт, цахилгаан хэрэглээ 29527.1 сая.кВт.ц байхаар тооцож цахилгаан хангамжийн төлөвлөлтийг хийсэн байна.

Хүснэгт. Цахилгаан хангамжийн системийн тооцоолол⁹

№	Хотуудын нэр	2020 оны ЦЭХ хэрэглэчийн тоо	2020 он		Төлөвлөлт	
			Цахилгаан ачаалал-Р _{max}	ЦЭХ-ний хэрэглээ- W _{жил}	Цахилгаан ачаалал-Р _{max}	ЦЭХ-ний хэрэглээ- W _{жил}
			МВт	сая.кВт.ц	МВт	сая.кВт.ц
1	Зуунмод хот	4762	6.7	46.05	30.6	97903.9
2	Шинэ зуунмод	1	2.3	6.55	47.5	64937.0
3	Майдар хот	-	-	-	24.3	77912.4
4	Сэргэлэн	107	0.1	0.00042	2.1	6685.0
5	Логистик	-	-	-	20	47835.7
Нийт		4870	9.1	52.6	124.5	295274.1

Хөшигийн хөндийд шинээр бий болох хотуудын инженерийн шийдлийг боловсруулахдаа ногоон хөгжлийн бодлогод нийцсэн эрчим хүч, нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, эрсдэлгүй сэргээгдэх

⁹ Засгийн газрын 2022 оны 143 дугаар батлагдсан Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө. Боть-II: Төлөвлөлтийн шийдэл, хэрэгжүүлэх үе шатны төлөвлөгөө, УБ.,2022 он.

эрчим хүчний эх үүсвэртэй, усны менежмент зэрэг шаардлагад нийцсэн төлөвлөлтийг боловсруулсан байна.

Эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээг дараах байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөлтийн баримт бичигт тусгасан байна:

- шинээр баригдах барилга нь эрчим хүчний В, А, А+, А++ үнэлгээнд багтсан эрчим хүчний хэмнэлттэй байна;
- Хөшигийн хөндийн шинэ хотуудын эрчим хүчний төлбөр тооцооны систем нь хэрэглээнд суурьлсан төлбөрийн тогтолцоотой байна;
- ногоон эрчим хүчний эх үүсвэрийг ашиглана;
- Майдар хотод 50 МВт хүчин чадалтай нарны цахилгаан станцыг барина;
- шинээр баригдах дулааны эх үүсвэрүүд нь газрын гүний дулааны станц, hydrogen, хийн түлшээр ажилладаг дулааны эх үүсвэрүүд байна.

Усны менежмент:

- цэвэршүүлсэн хаягдал усны 20-25%-ийг эргүүлэн ашиглана. /ДЦС, ДС технологийн хэрэглээ, усалгаа/
- томоохон барилгууд нь саарал ус эргүүлэн ашиглах технологитой байна.

Дамжуулах сүлжээний хувьд:

- 220 кВ-ын 1 дэд станц, 87 км ЦДАШ, 110 кВ-ын 1 дэд станц өргөтгөх, 5 дэд станц шинээр барих, 69.4 км урт 2 хэлхээт ЦДАШ барих;
- 220 кВ-ын их тойрог сүлжээ бий болгож Сонгино, Буянт Ухаа дэд станцуудыг холбосон 220/110/35 кВ-ын 2х200 МВА чадалтай Сэргэлэн дэд станц, 220 кВ-ын 2 хэлхээт 87 км урт ЦДАШ-ын хамт Сэргэлэн суманд барих;
- 220/110/35 кВ-ын Сэргэлэн дэд станцаас Шинэ зуунмод хотод баригдах 110/35/10 кВ-ын 2х40 МВА чадалтай Аэросити дэд станцыг 110 кВ-ын 7.2 км урт 2 хэлхээт ЦДАШ-аар холбох;
- 220/110/35 кВ-ын Сэргэлэн дэд станцаас Ложистикийн төвд 110/10 кВ-ын 2х25 МВА чадалтай Ложистик дэд станц, 110 кВ-ын 7.6 км урт 2 хэлхээт ЦДАШ-ын хамт барьж холбохоор төлөвлөсөн байна.

Мөн цахилгаан түгээх сүлжээний хувьд 35 кВ-ын 1 дэд станц өргөтгөх, 3 дэд станц шинээр барих, 31.2 км урт 2 хэлхээт ЦДАШ барих, 10 кВ-ын 16 иж бүрдэл хуваарилах байгууламж, 10 кВ-ын 1642 км хос кабель шугам, 470 иж бүрдэл кабелийн хуваарилах байгууламж барихаар төлөвлөжээ.

Эдгээр төлөвлөлтийн дагуу барьж байгуулахаар төлөвлөсөн, дулаан хангамж, цахилгаан хангамжийн эх үүсвэрийг нар, салхи, газрын гүний зэрэг сэргээгдэх эрчим хүчийг ашиглахаар төлөвлөсөн¹⁰ байгаа нь шинэ хотын хэрэглээг хангах боломжтой байна.

5. Дулаан хангамж:

Шинэ Зуунмод хотод архитектур төлөвлөлт, нийгэм эдийн засгийн даалгавраар 10,858 өрхийн 34,000 хүн амын НДБ, олон нийт, үйлдвэр орон сууцны зориулалттай 10.5 сая.м² барилга шинээр баригдахаар төлөвлөсөн байх ба төлөвлөлтийн хугацаанд баригдах барилгуудын дулаан хангамжын ачаааллыг дараах байдлаар тооцоолсон байна:

¹⁰ Засгийн газрын 2022 оны 143 дугаар батлагдсан Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө.

- дулаан нийт ачаалал 525 Гкал/цаг;
- халаалтын системийн ачаалал 399 Гкал/цаг;
- агаар сэлгэлтийн нийт ачаалал 60 Гкал/цаг;
- хэрэгцээний халуун усны ачаалал 65 Гкал/цаг байна.

Дулаан хангамжийн системийн хувьд эхний ээлжинд суурьшлын бүсийн баруун урд бүсэд 120 Гкал/ц хүчин чадалтай хатуу түлшний эх үүсвэрийг барьж байгуулах ба Шинэ Зуунмод хотын барилгажилттай уялдуулан эхний ээлжинд баригдсан дулааны эх үүсвэрийг 160 Гкал/ц-аар өргөтгөхөөр төлөвлөжээ.

Шинэ Зуунмод хотын эдийн засгийн чөлөөт бүс, тээвэр логистикийн бүсүүдийн дулааны хэрэглээг эхний ээлжинд баригдсан дулааны станцаас болон, бие даасан хэсэгчилсэн дулааны эх үүсвэрээс хангахба эдийн засгийн чөлөөт бүсийн барилгажилтын 30% бүрэн баригдаж дууссан тохиолдолд эдийн засгийн чөлөөт бүс, тээвэр логистикийн бүсийн дулааны хэрэглээг хангах 280 Гкал/ц хүчин чадалтай дулааны станцыг шинээр барьж, эхний ээлжинд баригдсан 280 Гкал/ц-ын станцтай холбоос шугамаар холбогдон хотын дулаан хангамжийн найдвартай ажиллагааг хангахаар тооцоолсон байна.

6.Нийгмийн дэд бүтэц: Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийгмийн дэд бүтцийн үйлчилгээ нь суурин хүн амд үйлчлэхээр төлөвлөгдсөн байх бөгөөд 10.8 мянган өрхийн 34 мянган хүнд үйлчлэх нийгмийн дэд бүтцийг БНБД 30-01-04 нормд заасны дагуу төлөвлөсөн байна.

Нийгмийн дэд бүтцийн хүрээнд 1.7 мянган ажлын байр бий болж суурьшлын хүн амаас энэхүү ажлын байруудад ажиллана гэж тооцжээ. Хотод 2-р шатлалын 1 эмнэлэг төлөвлөсөн ба өрхийн эмнэлгүүдийг орон сууцны хажууд суурьшилдаа ойрхон байхаар тооцож төлөвлөсөн нь дэвшилттэй бөгөөд хүний амьдралын чанарыг дээшлүүлэх хүчин зүйл болж байна.

Хүснэгт: Нийгмийн дэд бүтцийн төлөвлөлт

Нийгмийн дэд бүтэц	1-р ээлж		2-р ээлж		3-р ээлж		нийт	
	Хүчин чадал	объект тоо	Хүчин чадал	объект тоо	Хүчин чадал	объект тоо	Хүчин чадал	объект тоо
Цэцэрлэг	720 хүүхэд	3	1200	5	3,840	16	1920	8
Сургууль	640 хүүхэд	1	1920	3	1280	2	3,840	6
Өрхийн эмнэлэг	өдөрт 208 үзлэг	1	603	1	379	1	1,190	3
Спорт цогцолбор	6,800 м2	1	-	-	-	-	6,800 м2	1
Түргэн тусламжийн станц	1 машин	1	1 машин	1	1 машин	1	3 машин	3
Гал унтраах анги	1 машин	1	1 машин	1	1 машин	1	3 машин	3
Цагдаагийн хэсэг	1м2	3	1	3	1	3	3	9
Ахмад, хүүхдийн хөгжлийн төв,	250 хүнд үйлчлэх	2	-	-	-	-	250 хүнд үйлчлэх	2
Театр, соёлын төв	1122 суудал	1	-	-	-	-	1122 суудал	1
Нэгдсэн эмнэлэг	306 ортой	3	-	-	-	-	306 ортой	3

Хэрвээ энэхүү төлөвлөлтийнхөө дагуу Шинэ Зуунмод хотыг байгуулж, хөгжүүлж чадвал Улаанбаатар хотыг үйлдвэрийн тусгай бүс дагуул хот бүхий олон улсын жишигт нийцсэн улс төр, нийгэм, эдийн засаг, урлаг, соёл, зорчигч, ачаа, тээвэр, аялал жуулчлалын томоохон зангилаа төв болгон хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлж байна.

Иймээс газар зүйн байршлын хувьд Монгол Улсын хойд зүгээс өмнө зүг рүү дайран өнгөрөх төлөвлөж буй шинэ хурдны зам, Улаанбаатар хот, олон улсын шинэ нисэх онгоцны буудалтай холбох Богдхан уулын урдуур тавигдах шинэ төмөр замтай холбогдох тул чухал ач холбогдолтой байна.

Шинэ Зуунмод хотын бүс нь нисэх буудал, төмөр зам, авто замын зангилаа болох нөөц бололцоо ихтэй тул дагуул хот болгон хөгжүүлэх боломж бусад бүсээс харьцангуй өндөр байна.

Нийслэлийн дагуул хот байгуулах, тухайн хотын эрх зүйн байдлыг хуулиар тодорхойлох нь нийслэл хотод тулгамдаж байгаа олон тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, тухайлбал, нийслэлийн иргэдийн аж амьдрал, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлж, Үндсэн хуульд заасан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдах хууль зүйн баталгааг бүрдүүлэх ач холбогдолтой байна.

Мөн түүнчлэн өнгөрсөн хугацаанд хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжин суурьшилт болон шинэ төрөлтөөр нийслэл хотын хүн ам огцом, эрс нэмэгдсэний улмаас хүн амын хүнсний хангамж, эрүүл орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, хүнсний болон орчны аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах, нийслэлийн нутаг дэвсгэрийн экологийн тэнцвэрийг хадгалах, хамгаалах, гамшиг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг жигд, тогтвортой, тасралтгүй нэмэгдүүлэх, нийгмийн халамж, төрийн үйлчилгээнд үүсч буй зохиомол ачааллыг бууруулах зэрэг хүний эдийн засаг, нийгэм, соёлын эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх, шаардлага өдрөөс өдөрт өсөн нэмэгдсээр байна.

Хотжилт нь төлөвлөгөөтэйгээс гадна аяндаа бий болдог нийгмийн үзэгдэл тул нийслэлийн нутаг дэвсгэрт амьдралын хэв маяг, эдийн засаг, нийгмийн ашиг сонирхлоороо нэгдсэн хүн ам төвлөрсөн хот, тосгон, суурингууд үүссээр байна. Мөн хот, тосгоны өдөр тутмын амьдралыг зохицуулсан, оршин суугчид руугаа чиглэсэн, нийтийн эрх ашигт нийцсэн, иргэдийн эрүүл, аюулгүй, тав тухтай оршин суух орчныг бүрдүүлэх зорилготой дүрмээ оршин суугчид батлан мөрдүүлэх эрх зүйн орчинг бий болгож, хот, тосгон тулгамдсан асуудлаа өөрийн онцлогт тохируулан шийдвэрлэх, бие даан хөгжих боломжийг олгох шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Дээрх нөхцөл байдал, хэрэгцээ шаардлага нь манай улсын улс төр, эдийн засаг, нийгмийн, соёл, бүтээн байгуулалтын төв нийслэл Улаанбаатар хотын олон талт зангилаа асуудал, тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлж байгаа бөгөөд тэдгээрийг өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нийслэлийн эрх зүйн байдлыг тодорхойлсон Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиар нэг мөр, бүрэн төгс зохицуулах боломжгүй байна.

Иймд Нийслэлийн Шинэ Зуунмод дагуул хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, батлах нь нийслэлийн төдийгүй Төв аймаг, цаашлаад төвийн бүсийн иргэдийн аж амьдрал, аж ахуйн нэгж, байгууллагын үйл

ажиллагаанд эерэг нөлөө үзүүлж, Үндсэн хуульд заасан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдах хууль зүйн баталгааг бүрдүүлэх, цаашлаад бүс, орон нутгийг хөгжүүлэхэд ач холбогдолтой байна.

2.2.Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийг тодорхойлсон байдал:

Шинэ Зуунмод хотыг Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр, Хөшигийн хөндийд байгуулах бөгөөд суурьшил үүсээгүй, иргэн, аж ахуйн нэгж байгууллага үл хөдлөх эд хөрөнгө барьж байгуулаагүй, үйл ажиллагаа явуулаагүй байршлыг сонгон байгуулахаар төлөвлөсөн байна.

Хот байгуулахаар төлөвлөсөн 31.5 мянган га талбайг Засгийн газрын тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан байх бөгөөд нийт 3,000 гаруй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж, өмчилж байгаа газрын эрхийг Шинэ Зуунмод хотын төлөвлөлттэй уялдуулан зориулалтыг өөрчлөх, нөхөх олговортойгоор газрыг нь эргүүлэн авах, өөр байршилд солих арга хэмжээг холбогдох хуульд заасны дагуу авч хэрэгжүүлж байгаа тул тэдгээрийн эрх, ашиг сонирхол шууд хөндөгдөхгүй байна гэж үзлээ.

2.3.Асуудлыг үүсгэж байгаа шалтгаан нөхцөл:

Нийслэл Улаанбаатар хот нь Монгол Улсын газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг ба нийт хүн амын 49 хувь нь амьдарч байна. Нийслэл хотын эрх зүйн байдлыг тодорхойлсон хуулийн зохицуулалт байгаа боловч суурьшлыг тэлэх, шинээр дагуул хот байгуулах, тухайн дагуул хотын бүтэц, зохион байгуулалт, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, төсөв санхүүгийн талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй байгаа нь нийслэл хотын нийгэм эдийн засгийн харилцаанд, цаашлаад нийслэл хотын иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх дараах асуудлыг шийдвэрлэхэд түлхэц болж чадахгүй байна гэж үзлээ. Үүнд:

- нийслэл хотын төлөвлөлт, орчны аюулгүй байдал, стандарт алдагдсанаас оршин суугчид төдийгүй нийслэлд байнга оршин байгаа төрийн дээд байгууллага, олон улсын болон дипломат төлөөлөгчийн газрын хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхүйц асуудал үүсгэж байна. Жишээлбэл, нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, хүртээмж, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж хүрээлцээ муугаас иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байна.
- Улаанбаатар хотод хэт төвлөрч, агаар, хөрсний бохирдол, авто замын түгжрэл, орчны аюулгүй байдал алдагдах гэх мэт.

Тухайлбал, хүн амын хэт төвлөрлөөс үүдэн агаарын бохирдол 0.34 мг/м³ хүрч Монгол Улсын стандартаас 7 дахин их, ДЭМБ-ын зөвлөмжөөс 14 дахин их¹¹, тээврийн хэрэгслийн тоо 2021 онд 662,644.0¹² байсан бол 2023 онд 692,453.0 болсон, авто замын түгжрэлийн түвшин VCR 1 байхаас VCR 3.0-т хүрч авто замын

¹¹ Үндэсний статистикийн хороо, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гаргасан “Улаанбаатар хотын агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө” 2020 он, Т-14

¹² https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1200_013V3&13999001_select_all=0&13999001SingleSelect=_T8&SOUSelect_all=0&SOUSelectSingleSelect=_5_511&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2021&viewtype=table

даац хэтэрсэн.¹³ Мөн их дээд сургууль, коллежийн 89.77%, нийт суралцагчдын 93.0%, аж ахуйн нэгжийн 71.0%, төрийн байгууллагын дийлэнх нь нийслэл хотын төвд байрлаж байна¹⁴. Мөн Монгол Улсад олон улсын тээвэр зууч буюу логистикийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 200 гаруй аж ахуйн нэгж байдаг¹⁵ бөгөөд дийлэнх нь Улаанбаатар хотын төв хэсэг болон баруун хэсэгт байрласан, түүнчлэн барилгын материал борлуулдаг томоохон цэгүүд төвлөрсөн байгаа нь хотын хэт төвлөрөл, замын түгжрэл үүсэх нөхцөлийг бий болгож байна.

Ийм учраас хэт төвлөрлийг задалж, суурьшлыг тэлж дагуул хот, суурин газар шинээр байгуулах, тэдгээрийн эрх зүйн байдлыг тодорхойлсон нарийвчилсан зохицуулалт бүхий хуулийн төсөл боловсруулж батлах, хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага бий болсон байна.

ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Шинэ Зуунмод /Аэро сити/ хотыг нийслэлийн дагуул хот байхаар тусгасан, 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нийслэл хотыг дагуул хоттой байна гэж заасан, Засгийн газрын 2022 оны 143 дугаар тогтоолоор Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг баталсан зэрэг нь Шинэ Зуунмод дагуул хотыг байгуулах, түүний эрх зүйн байдлыг нарийвчлан тодорхойлох үндэслэл болж байна.

Иймд ирээдүйд бий болох нөхцөл байдлыг үнэлж, энэхүү үнэлгээний тайлангийн 2.3-т заасан асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага урган гарч байгаатай холбогдуулан Аргачлал 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгыг "иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, ногоон хөгжил, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг бий болгох үүднээс шинжлэх ухааны үндэслэлтэйгээр дагуул хотыг байгуулах, түүний эрх зүйн байдлыг хуулиар тодорхойлох" гэж тодорхойллоо.

Монгол Улсын нийслэлийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа онцлог нэгж болох Улаанбаатар хот дагуул хоттой байх зохицуулалт байгаа боловч хэрэгжилт хангалтгүй, ямар нэг үр дүн гараагүй, зохицуулалт нь ерөнхий бөгөөд хязгаарлагдмал байгаа нь хуулийн төсөл боловсруулах нэг үндэслэл болж байна. Тухайлбал:

- Улаанбаатар хотын хүн амын өсөлт нь хот байгуулалт, төлөвлөлт, байгаль орчин, экологийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, төлөвлөлтгүй суурьшил бий болох, гэмт хэрэг, зөрчил ихсэх, замын хөдөлгөөнд хэт түгжрэл үүсэх, хүн амын эрүүл мэнд, нийгмийн халамж, үйлчилгээний салбар доголдох зэргээр эдийн засаг, нийгмийн бүх талын харилцаанд хүндрэл учруулж байгаа боловч уг асуудлыг дагуул хот байгуулах замаар суурьшлыг тэлэх, шинэ суурьшил үүсгэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг тодорхойлсон нарийвчилсан зохицуулалт байхгүйгээс тодорхой үр дүнд хүрч чадахгүй байна.

¹³ Нийслэлийн Засаг даргын Тамгын газар "Төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний баримт бичиг" 2022 он, Т-4

¹⁴ <https://ulaanbaatar.mn/home>, Үндэсний статистикийн хорооны мэдээлэл.

¹⁵ Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбооны 2022.05.30-ны олон улсын тээвэр логистикийн өнөөгийн байдал, импортын ачааны саатал, шийдлүүд танилцуулгын 3 дахь нүүр

- манай улсын нийт хүн амын 50 орчим хувь, нийт аж ахуйн нэгж байгууллагын 74 орчим хувь нь нийслэл хотод амьдарч, үйл ажиллагаа явуулж байгаа нь хэт төвлөрөл, нийгэм, эдийн засгийн байдал эрс өөрчлөгдсөн зэрэг нь агаар, хөрс, автомашины бохирдлыг үүсгэж, инженерийн болон нийгмийн дэд бүтцийн хүртээмжгүй байдлыг бий болгож улмаар иргэд, оршин суугчдын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх, зөрчигдөхөд хүргэж байгаа асуудлыг шийдвэрлэх нэг гол арга зам бол дагуул хот байгуулах асуудал болохыг төрөөс бодлогын баримт бичгүүдэд тусгаж байна.

Иймд одоогийн болон ирээдүйд бий болох нөхцөл байдлыг үнэлж дүгнэн нийслэлийн Шинэ Зуунмод дагуул хотын эрх зүйн байдлыг бусад хот болон засаг захиргааны нэгжээс ялгамжтай байдлаар авч үзэж нийслэл хотын онцлогт нь нийцсэн аргаар зохицуулах шаардлагыг харгалзан энэхүү үнэлгээний тайлангийн нэгд заасан асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага урган гарч байгаатай холбогдуулан Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

1. Монгол Улсын Үндсэн хуульд заасан нийслэлийн чиг үүргийг хэрэгжүүлэх Улаанбаатар хотын хөгжлийн үзэл баримтлал, Төв аймгийн Зуунмод хот болон тус аймгийн Сэргэлэн сумын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулсан, Шинэ Зуунмод дагуул хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байгаль орчин, нийгэм, эдийн засаг, санхүү, бизнес, татварын бодлогыг оновчтой, эерэг үр нөлөөтэй тодорхойлох замаар нийслэлийн Шинэ Зуунмод дагуул хотын эрх зүйн байдлыг тодорхойлох;
2. улсын нийслэлийн хувьд хуулиар бусад засаг захиргааны нэгжээс онцлог, тусгай чиг үүрэг хэрэгжүүлж байгаад нийцүүлэн эдийн засгийн бие даасан байдлыг хангасан байдлаар нийслэлийн дагуул хот, эдийн засгийн тусгай бүс байгуулах, нийслэлийн дагуул хотын төсвийн орлогыг тухайн хотын оршин суугчдын болон нийслэл, Төв аймгийн Сэргэлэн сумын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь хангахад зарцуулдаг байх эрх зүйн орчинг бүрдүүлэх;
3. Шинэ Зуунмод дагуул хотыг урт хугацаанд, удирдлага, зохион байгуулалт, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын хувьд тогтвортой хөгжүүлэх бодлого, зарчмыг тодорхойлох;
4. дагуул хотыг хөгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын таатай орчин, баталгааг хангах эрх зүйн үндсийг бүрдүүлэх;
5. Шинэ Зуунмод дагуул хотоос нийслэл болон Төв аймаг цаашлаад бусад засаг захиргааны нэгжүүдтэй улсын чанартай болон хурдны зам, метро, төмөр зам, агаарын замаар хурдан шуурхай холбогддог байх;
6. Шинэ Зуунмод дагуул хотод төрийн үйлчилгээ хүртээмжтэй, ил тод байх;
7. нийслэл болон Төв аймаг, тус аймгийн Сэргэлэн сумын удирдлагаас зарим чиг үүргээ Шинэ Зуунмод хотын удирдлагад шилжүүлэх замаар чиг үүргийн давхардлыг арилгах, төрийн байгууллагын ачааллыг багасгах гэх мэт.

Хуулийн төсөл батлагдаж эдгээр зорилгыг хэрэгжүүлснээр:

- нийслэл Улаанбаатар хот 1.5 сая орчим хүн амтай, дэлхийн 400 гаруй метрополис хотын нэгэн адил өөрийн тогтвортой үзэл баримтлал бүхий эрүүл, аюулгүй орчинтой, олон төвт суурьшлын тогтолцоонд суурилсан, иргэд, олон нийтийн оролцоонд тулгуурласан, стандартын шаардлагад нийцсэн, сайн засаглалтай, олон улсад өрсөлдөх чадвартай томоохон төв болох эрх зүйн орчин бүрдэнэ;
- нийслэлийн дагуул хотын хөгжлийн талаар баримтлах бодлого, хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойлогдож, хотын удирдлага, бүтэц, зохион байгуулалт, бүрэн эрх, хүлээх хариуцлага тодорхойлогдоно;
- нийслэлээс дагуул хот руу шилжин суурьших хүсэлтэй иргэн, ААНБ-ын тоо нэмэгдэнэ;
- нийслэл хотын зарим чиг үүргийг дагуул хотод шилжүүлэн хэрэгжүүлэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоотой нийслэлийг болон бүс, орон нутаг, дагуул хотыг хөгжүүлэх боломж бүрдэнэ;
- нийслэлд тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдах, амьдралын чанар дээшлэх ач холбогдолтой.

3.1.Шинэ Зуунмод дагуул хотыг байгуулснаар дараах зэрэг үр дагавартай байна гэж үзлээ. Үүнд:

1. бодлогын баримт бичигт тусгагдсан дагуул хот байгуулах зорилтуудыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ;
2. нийслэл Улаанбаатар хотын суурьшлыг тэлж, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд зэрэг нөлөө үзүүлнэ;
3. нийслэлийн төдийгүй Төв аймаг, цаашлаад төвийн бүсийн иргэдийн аж амьдрал, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд зэрэг нөлөө үзүүлж, Үндсэн хуульд заасан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдах хууль зүйн баталгааг бүрдүүлэх, бүс, орон нутгийг хөгжүүлэхэд ач холбогдолтой;
4. дагуул хотод бий болох эдийн засгийн тусгай бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжид татварын болон татварын бус дэмжлэг, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэж бизнесийн таатай орчин бүрдэж, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, хүчин чадал нэмэгдэж, олон тулгуурт эдийн засагтай байх бодлогод нийцсэн алхам болно;
5. жилд шинээр 820 орчим ажлын байр бий болж, ДНБ-ний хэмжээ 0.024%-иар нэмэгдэн 2040 оны байдлаар 16 мянга гаруй ажлын байр бий болж “Халамжаас-Хөдөлмөрт” шилжих Засгийн газрын бодлого хэрэгжихэд түлхэц болж, Улаанбаатар хотын төвлөрсөн суурьшлыг тэлнэ;
6. Шинэ Зуунмод дагуул хотыг хүрээлэн буй орчинд ээлтэй, эдийн засгийн үр өгөөжтэй, хүний амьдрах, ажиллах нэн таатай орчин бүрдсэн тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангасан, дэлхийн жишигт нийцсэн дагуул хот бий болно.

3.2.Шинэ Зуунмод дагуул хотод байгуулах эдийн засгийн тусгай бүс:

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8.1-д Нийслэл хот нь эдийн засгийн тусгай бүстэй байж болно. Тусгай бүсийг нийслэлийн нутаг дэвсгэр, дагуул хот болон бусад орон нутагт тухайн засаг захиргааны нэгжтэй тохиролцсоны үндсэн дээр Засгийн газрын шийдвэрээр байгуулна гэж заасан байх тул Хөшигийн хөндий дэх олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн хөнгөн үйлдвэрлэлийн эдийн засгийн тусгай бүс, тээвэр, логистикийн төвийг байгуулах боломжтой. Ингэснээр Шинэ Зуунмод дагуул хотын нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх эерэг нөлөө үзүүлнэ. Төлөвлөж буй дагуул хот нь нийслэл хотын төвөөс 53 км орчим зайд байгаа бөгөөд төлөвлөлтийн талбайн 10.7%-ийг суурьшлын бүс, 10.4%-ийг Агаарын зорчигч болон ачаа тээврийн төв, 6.32%-ийг Хөнгөн үйлдвэрлэлийн эдийн засгийн тусгай бүс, 8.4%-ийг төвийн бүсийн логистик төв болгон хөгжүүлэхээр төлөвлөсөн байгаа нь эдийн засгийн тусгай бүсийг байгуулах боломжийг нэмэгдүүлж байна.

ДӨРӨВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 5.4-т заасны дагуу хуулийн төсөл боловсруулах нэг хувилбарыг сонгосон ба сонгосон хувилбарын үр нөлөөг тус аргачлалын 6.2-т заасан ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргасан ба хувилбарын хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг Хүснэгт 1, 2, 3, 4-р харуулав.

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө:

Шинэ Зуунмод дагуул хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулах нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж заасантай уялдуулж, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци зэрэгт нийцэж байгаа эсэх, улмаар хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх эрсдэлээс хамгаалах, хариуцлагыг нэмэгдүүлэх зэргээр хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн зохицуулалтыг бий болгох нь ойлгомжтой байна.

Өөрөөр хэлбэл, хуулийн төсөл боловсруулах нь хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа нь Аргачлалын 6.2-т заасан хүний эрхэд үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт Хүснэгт1-ээр тодорхойлогдож байна.

Хүснэгт 1

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх ба хуулийн төсөлд тодорхой үндэслэл бүхий шалгуур тавьж, хязгаарлалт тогтоож болох боловч үүнийг ялгаварлан гадуурхсан зохицуулалт биш болно.

	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	иргэн, хуулийн этгээдэд ээлтэй байх зарчимд тулгуурлан сөрөг үр дагаварыг буруулахад зохицуулалтын зорилго чиглэгдэх.
	1.1.3.Хүний эрхийн олон улсын баримт бичигт нийцэх эсэх	Тийм	Үгүй	
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөлд иргэд, холбогдох байгууллагаас санал авах, төр, мэргэжлийн ТББ, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн мэдээлэл солилцох оролцоог хангасан байх ёстой.
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах, нийслэлийн иргэдийн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангах, хамгаалах, хүний халдашгүй эрхийн баталгааг хангахад чиглэх.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Хүн бүр тэгш эрхтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлэх.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тогтоох зарчмыг баримтлах.
	2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй
2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	Үгүй	Иргэн, хуулийн этгээдэд, зөвшөөрсөн болон хориглосон үйл ажиллагааг тодорхойлж

				болох ба энэхүү хязгаарлалт нь хуулийн хүрээнд, хяналтын доор хэрэгжих ёстой. Энэхүү хязгаарлалт нь нийтийн эрх ашгийн үүднээс зайлшгүй шаардлагатай бөгөөд Үндсэн хуульд заасан зайлшгүй нөхцөлд хамаарна.
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм		Дагуул хотын оршин суугч, нийслэлийн болон Төв аймгийн иргэн, хуулийн этгээд /өмчийн хэлбэр харгалзахгүйгээр
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх зохицуулалт тусгагдах
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм	Үгүй	Хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гадаадын иргэн зэрэгт тэгш боломжийг олгох.
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Төр, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, иргэд оршин суух, үйл ажиллагаа явуулахдаа ямар үүрэг хүлээх, иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх төрийн байгууллага, албан тушаалтан ямар үүрэг хүлээхийг тодорхойлох.
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл хүний эрхийн суурь зарчимд нийцэж, хүйсээр ялгаварлах зохицуулалт тусгагдахгүй байх.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөлд жендэрийн тэгш байдал зөрчигдөх зохицуулалт тусгагдахгүй.

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө:

Нийслэл, орон нутаг, дагуул хотын захиргааны байгууллага болон оршин суугч, аж ахуйн нэгж байгууллагад санхүүгийн эрх мэдэл, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, урамшуулал олгох эрх зүйн орчныг бий болгосноор дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага дэлхий болон дотоодын зах зээл дээр өрсөлдөх чадварт эерэг нөлөө үзүүлэх ба макро эдийн засгийн тогтвортой байдал, өрхийн орлого, зарлага, олон улсын харилцаа зэрэгт сөрөг нөлөө үзүүлэхгүй нь Аргачлалын 6.2-т заасан эдийн засагт үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт Хүснэгт 2-оор тодорхойлогдож байна.

Хүснэгт 2

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй. Нийслэл, орон нутаг, дагуул хотын эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн эрх зүйн зохицуулалт сайжирснаар дэлхийн эдийн засгийн хямралын нөлөөлөл багасна.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	сөрөг нөлөөгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй. Нийслэлийн хөгжлийн бодлого, чиг үүргийг хэрэгжүүлэх хотын хөгжлийн түүх, хэтийн төлөвийг тодорхойлох, хотжилт, хот байгуулалт, хүн ам, хүрээлэн байгаа орчны асуудал, олон нийтийн санаа бодлыг судлах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй. Нийслэл, орон нутаг, дагуул хотын хөгжилд иргэн, ААНБ-ын оролцоог нэмэгдүүлж, төр хувийн хэвшлийн түншлэлийг чухалчлах, хөрөнгө оруулалтын баталгааг хангах зохицуулалт тусгах.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй. Санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулж, тодорхой эерэг нөлөө үзүүлнэ.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй. Санхүүгийн тогтвортой байдлыг хангаснаар үнийн тогтвортой байдалд нөлөөлж

				хэрэглэгчдийн эрх ашигт эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй. Үйлдвэр, үйлчилгээний байгууллагад ажлын байр нэмэгдэж, санхүү, татварын бодлогоор дэмжих.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй. Татварын бодлогоор дэмжих. Санхүүгийн тогтвортой байдлыг хангаснаар эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх боломжийг бүрдүүлж, бизнесийн таатай орчин бий болох эерэг нөлөө үзүүлнэ.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нийлэлийн тусгай чиг үүрэгт нь зориулж улсын төсвөөс хөрөнгө оруулалт хийнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй. Чиг үүргийн зөв хуваарилалт, менежмент бүхий Хотын зөвлөл, Захирагч түүний ажлын алба шинээр байгуулагдан ажиллана.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй бөгөөд шинээр суурьшил үүссэнээр ажлын байр нэмэгдэх, үйл ажиллагаа нь өргөжих, орлого нь нэмэгдэх эерэг нөлөөтэй.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй бөгөөд төсвийн болон төсвийн бус эх үүсвэрээр дагнасан болон хамтарсан хөрөнгийн сан үүсгэж, хөрөнгө оруулалт хийх таатай орчныг бий болгож, зах зээлийн тогтвортой байдал хангагдах эерэг нөлөө үзүүлнэ.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг байдлаар зөрчилдөхгүй.

Хуулийн төслийг оновчтойгоор боловсруулж баталснаар тодорхой хэмжээнд төсвийн орлогыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ төрийн үйлчилгээнд менежментийн инноваци¹⁶ болон түүнтэй холбогдох судалгаа шинжилгээний ажлыг нэвтрүүлэх боломжийг нэмэгдүүлнэ. Мөн эдийн засгийн эрсдэл буурах, нийслэлийн болон орон нутгийн эдийн засаг тогтвортой өсөх боломж бүрдэж, амьдралын чанар дээшилнэ гэж үзлээ.

4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө:

Аргачлалын 6.2-т заасан нийгэмд үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт Хүснэгт 3-аас харахад нийгэмд үзүүлэх ямар нэг сөрөг үр нөлөө байхгүй ба төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, иргэдийн амьдралын чанарт эерэгээр нөлөөлөхөөр байна.

Хүснэгт 3

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлд шинэ ажлын байр нэмэгдэх боломжтой. Шинээр суурьшил үүссэнээр үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлалын салбарт ажлын байр нэмэгдэх, үйл ажиллагаа нь өргөжих, орлого нь нэмэгдэнэ.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй Шинээр суурьшил үүссэнээр ажлын байр нэмэгдэх, үйл ажиллагаа нь өргөжих, орлого нь нэмэгдэх эерэг нөлөө үзүүлнэ.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй Шинээр суурьшил үүссэнээр ажлын байр нэмэгдэж хөдөлмөрийн насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд эерэг нөлөөтэй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй Чиг үүрэг, бүрэн эрх, хариуцлага, хяналт тодорхой болсноор ажлын чанар дээшилж, шаардлагатай стандарт батлагдаж хэрэгжина.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

¹⁶Инновацийн тухай хуулийн 3.1.1."инноваци" гэж шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах цогц үйл явцыг; 3.1.3."инновацийн үйл ажиллагаа" гэж шинэ санаа, шинэ мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, технологи, ажил, үйлчилгээг бий болгож зах зээлд нийлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг;

	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй. Хотын хөгжилтэй уялдуулан дэлхийн жишигт хүрсэн үйлчилгээг нэвтрүүлэх, орчны аюулгүй байдлыг хангахтай холбоотой шинэ стандарт гарах боломжтой.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй. Үйлдвэрлэл, технологийн дэвшил, инновацийн хөгжүүлэлттэй холбоотой эерэг нөлөө бүхий өөрчлөлт бий болно.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй. Хөгжлийн бодлого, эрх зүйн орчин боловсронгуй болсноор төрийн байгууллагын үүрэг, үйл ажиллагааны чанар, хүртээмж сайжирна.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Зарим чиг үүрэг, хариуцлага тодорхой болж төрийн албан хаагчийн ажиллах орчинг сайжруулж, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ, үйлчилж байгаа хүн амын тоо, ажлын ачааллаас хамаарч ангилал, зэрэглэлийг нь нэмэгдүүлнэ.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй. Агаар, орчны бохирдол буурч, нийслэлийн газар экологийн тэнцвэртэй байдал хангагдсанаар хувь хүний эрүүл мэнд, сэтгэл зүйд эергээр нөлөөлнө.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй бөгөөд шинээр суурьшил үүссэнээр Улаанбаатар хотын төвлөрөл саарч хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхүйц дуу чимээ, агаар, хөрсний чанарт эерэг нөлөөтэй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй. Үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч эерэг нөлөө гарна.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй бөгөөд нийслэлийн хүний нөөцийн төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой чиг үүрэг хүлээж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын ажилтан, албан хаагч, иргэдийн боловсрол, давтан сургалтанд хамрагдахад эерэг нөлөөтэй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй бөгөөд дагуул хотод их дээд сургуулийг хотхон хэлбэрээр төлөвлөх, суурьшуулах боломжтой болно.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Амьдрах орчин, үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч эерэг нөлөө гарна.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нийслэлд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, эрүүл, аюулгүй орчноор хангагдах нөхцөл бүрдэж эерэг нөлөө үзүүлнэ.

	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Түүх, соёл, архитектурын өвийг хамгаалах, орчны аюулгүй байдлыг хангах талаар чиг үүрэг хүлээж, амьдрах орчин нөхцөл сайжрах, иргэдийн үүрэг оролцоо, хариуцлага нэмэгдэнэ.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Иргэд тодорхой эрх эдэлж, үүрэг хүлээх ба тэдний оролцоо, хяналт хангагдах эерэг нөлөөтэй

Нийслэлийн Шинэ Зуунмод дагуул хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж батлуулснаар нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид эергээр нөлөөлж, нийслэл Улаанбаатар хотод тулгамдаад байгаа агаар, ус, хөрсний бохирдол, дэд бүтэц, хүн амын нягтаршил, замын хөдөлгөөний ачааллыг бууруулах, нийслэл хот, орон нутаг, хотын оршин суугчид, иргэдийн эдийн засаг, нийгэм, соёлын эрх, эрх чөлөөг хангасан орчин үеийн дэвшилтэт хөгжил бүхий дагуул хотыг хөгжүүлэх ач холбогдолтой байна.

4.4 Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө:

Байгаль орчинд ямар нэг шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй ба хот байгуулалт, төлөвлөлт журамлагдаж, төлөвлөлтгүй суурьшил, замын хөдөлгөөнд хэт түгжрэл үүсэх зэрэг хүндрэлтэй асуудал шийдвэрлэгдсэнээр байгаль орчныг хамгаалахтай холбоотой хуулийн хэрэгжилт хангагдах эерэг нөлөөтэй.

Хүснэгт 4

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй бөгөөд шинээр суурьшил үүссэнээр Улаанбаатар хотын төвлөрөл саарч агаар, хөрсний бохирдлыг бууруулах эерэг нөлөөтэй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй ба шинээр суурьшил үүссэнээр Улаанбаатар хотын төвлөрөл саарч тээврийн хэрэгслийн тоо буурах, замын хөдөлгөөний түгжрэл багасгах, тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээ буурах эерэг нөлөөтэй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөөтэй бөгөөд шинээр суурьшил үүссэнээр Улаанбаатар хотын төвлөрөл саарч инженерийн дэд бүтцийн даац нэмэгдэхгүй байх эерэг нөлөөтэй.

	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд үзүүлэх эсэх нөлөө	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй бөгөөд шинээр суурьшил үүссэнээр Улаанбаатар хотын төвлөрөл саарч тээврийн хэрэгслийн тоо буурах, замын хөдөлгөөний түгжрэл багасах, улмаар тээврийн хэрэгслийн хэрэглээний улмаас үүсэх агаарын бохирдол буурах эерэг нөлөөтэй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй бөгөөд нийслэлийн эдэлбэр газрын бүсчлэлтэй холбоотойгоор тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах, зөвхөн аялал жуулчлалын зориулалтаар ашиглах эерэг нөлөөтэй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй бөгөөд эдэлбэр газрын бүсчлэл, шинэ суурьшил үүсгэж Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулснаар цэвэр усны хэрэглээг одоогийн түвшнээс багасах, бохирдлыг бууруулах эерэг нөлөөтэй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй. Зөв, үр нөлөөтэй, ээлтэй төлөвлөлт, эдэлбэр газрын бүсчлэлийн зүй зохистой, хяналттай ашиглах эерэг нөлөөтэй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	
7.Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх нь чадавхыг	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

байгалийн баялаг	алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх			
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөөгүй

Бүс, орон нутаг, дагуул хотын экологийн тэнцвэр болон байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй. Байгалийн баялаг ашиглалт, нөхөн сэргээлтийн чиглэлд мэргэжлийн байгууллагуудын хяналтыг нэмэгдүүлэх магадлалтай.

Шинэ Зуунмод хотын төлөвлөлт, үйл ажиллагаа нь:

- түүхий эд болон эрчим хүчний хэрэглээг аль болох бага байлгах;
- байгаль орчинд хор хөнөөл багатай байлгах;
- хүрээлэн буй орчноо хамгаалах;
- тээврийн хэрэглээг багасгах;
- бүсийн болон хот, орон нутгийн хангамжийн урсгалыг үр ашигтай болгох;
- тогтвортой хөгжлийг хангах;
- хүний үйл ажиллагааны асуудалд анхаарал хандуулах;
- иргэдийн сэтгэл зүйн таатай байдал, нийгмийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх;
- сайн засаглалын үндэс суурийг бий болгох;
- олон салбар бүхий эдийн засгийг бий болгох;
- хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх замаар амьдралын өртгийг бууруулахад чиглэх нь байгаль орчин, хүн амьтанд ээлтэй, амьдрахад таатай, эко хот болж хөгжих гол нөхцөл болохыг хуулийн төсөл боловсруулахдаа анхаарах нь зүйтэй юм.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх:

Манай улсын нийт хүн амын 50 орчим хувийг нийслэлийн оршин суугчид эзэлж байгаа бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Арвангуравдугаар зүйлийн 1-д "Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн", Арвангуравдугаар зүйлийн 2-т "Монгол Улсын нийслэлийн эрх зүйн үндсийг хуулиар тогтооно" хэмээн хуульчилсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд зааснаар Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, сурч боловсрох зэргээр үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэх ба тус хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн энэхүү суурь зарчим нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийг нэг мөр хэрэгжүүлж, түүнийг хэрэгжилтийг хангах, зохицуулалтыг боловсронгуй болгож, нийслэлийн оршин суугчдын Үндсэн хуульд заасны дагуу үндсэн эрхээ эдлэх, баталгаагаар хангагдах үндэс суурь нь болж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1 зааснаар хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, Улаанбаатар хотын хүн амын өсөлт нь хот байгуулалт, төлөвлөлт, байгаль орчин, экологийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, төлөвлөлтгүй суурьшил бий болох, замын хөдөлгөөний түгжрэл үүсэх, хүн амын эрүүл мэнд, нийгмийн халамж, үйлчилгээний салбар доголдох зэргээр эдийн засаг, нийгмийн бүх талын харилцаанд хүндрэл учруулах болсон тул Нийслэлийн Шинэ Зуунмод дагуул хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлага байна гэж үзлээ.

Аливаа гэрээнд нэгдэн орсон улс Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцийн 27 дугаар зүйлийн 1-д заасны дагуу ямар нэгэн шалтгаан заалгүйгээр тухайн гэрээг заавал биелүүлэх үүрэгтэй байдгийг тэргүүн ээлжинд онцолдог ч манай улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээг дагаж мөрдөхгүй байхаар хуульчилсан байдаг. Олон улсын гэрээг соёрхон батлах асуудлыг Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай 1993 оны хууль, Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтыг баримтлан шийдвэрлэдэг ба Монгол Улсын Их хурал 1994, 2011 онуудад “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-ыг баталсан нь олон улсын гэрээний талаар баримтлах бодлогын үндэс юм.

Нийслэлийн дагуул хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулах ажил нь дээр дурдсан эрх зүйн зохицуулалттай харшлахгүй бөгөөд 2015 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Монгол Улсад 12 чиглэлийн хүрээнд өгсөн зөвлөмжийн дагуу хүний эрхийг хангах, хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хийж буй шинэчлэлийг үргэлжлүүлж байна.

Иймд Нийслэлийн Шинэ Зуунмод дагуул хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулах нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд өнөөдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжийг аливаа хэлбэрээр зөрчөөгүй, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хүндэтгэх, хууль тэгшээр үйлчлэх зарчимд бүрэн нийцэж байна гэж дүгнэлээ.

ТАВ. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Энэ асуудлын хүрээнд бусад улсуудын хотын эрх зүйн байдал болон энэ талаар манай улсад өмнө хийгдсэн судалгааг тухайлан авч үзэж судаллаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлт, шинэчлэлттэй холбогдуулан хотын эрх зүйн байдал, бусад улсын туршлага, зохицуулалтыг нарийвчлан судалсан хэд хэдэн судалгаа хийгдсэн байна:

- Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УБ. 2016 он.
- Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээлэл, лавлагаа. УБ. 2017 он.
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь /Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж/. УБ. 2019 он.

Эдгээр судалгаа, шинжилгээний баримт бичигт хотын эрх зүйн байдалтай холбоотой асуудлууд тодорхой хэмжээгээр тусгагдсан байна.

Тухайлбал, олон улсын хэмжээнд хотуудад тавих нэгдсэн стандарт байхгүй ч ерөнхий зарчим, зүй тогтлыг анхаарахыг зөвлөдөг бөгөөд хотын үндсэн шинжийг дараах байдлаар тодорхойлсон байдаг¹⁷ гэжээ. Үүнд:

1. төсвөө бие даан бүрдүүлдэг;
2. дэд бүтэц болон бусад барилга байгууламж, хотын хэлбэрээ өөрөө тодорхойлдог;
3. төсөв, хөрөнгөө өөрөө зарцуулдаг;
4. бусдаас буюу Засгийн газар, засаг захиргааны нэгжээс хараат бусаар бие даан хөгжих чадвартай байх.

Энэ судалгаанд Монгол Улсын хот суурин газрын статус, эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалж, хот, суурин газруудын тулгамдаж буй асуудлыг БНХАУ, Япон, БНСУ, Турк зэрэг улсын зохицуулалттай харьцуулан авч үзсэн байна.

Мөн 2016 онд Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, судалгааны баг доор дурдсан дүгнэлтийг хийжээ. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хуульд засаг захиргааны бүтцийг тодорхойлсон боловч Хот, тосгоны эрх зүйн байдлыг хуулиар тогтоохоор заасан бөгөөд Улаанбаатар хот бол Монгол Улсын нийслэл хот мөн гэж томьёолсон нь төрийн захиргааны нэгж, хотын эрх зүйн байдал хоёр тусдаа байхаар эрх зүйн үндэслэлийг тогтоосон байна. Гэтэл Хот, тосгоны эрх зүйн байдлын хуульд нутаг дэвсгэр дэх төрийн захиргааны нэгж, тухайн нутаг дэвсгэр дэх хот, тосгоны харилцааны нарийвчилсан зохицуулалтыг хийгээгүй орхигдуулснаас төрийн захиргааны нэгжийн удирдлага нь хот нийтийн аж ахуй, хөрөнгө төсөвт хэт хутгалдан, төр, аж ахуйн зааг ялгааг зөрчих явдал нэг талаас гарах, нөгөө талаас хот тосгон нь бүхий л ажил амьдралаа тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн төлөөллийн байгууллага, засаг даргын тамгын газарт даатган, хотын өөрийн удирдлагын үүрэг, зорилгыг алдагдуулах явдал нийтлэг байна¹⁸ гэжээ.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр хийсэн судалгаанд БНСУ, Япон, ОХУ, БНКУ, Испаний вант улсын хотын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалж, Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 1-д заасны дагуу нэгжийн удирдлагыг төрийн удирдлагатай хэрэгжүүлэх нэрийн дор орон нутгийн, тэр дундаа хот, тосгоны өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагаа, бүрэн эрх, чиг үүрэгт зарим талаар сөргөөр нөлөөлөх эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. Иймд орон нутгийн өөрийн удирдлагын зарчимд тулгуурлан хот, тосгоны удирдлагыг шинэтгэн сайжруулахын тулд холбогдох хуульд дараах чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай¹⁹ гэжээ.

¹⁷ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээлэл, лавлагаа. УБ. 2017 он. 361 дэх тал.

¹⁸ Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УБ. 2016 он. 369 дэх тал

¹⁹ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь /Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж/. УБ. 2019 он. 169 дэх тал.

1. Монгол Улсын засаг захиргааны нэгжийн болон хот, тосгоны удирдлагын бүрэн эрх, чиг үүргийн давхцалыг багасгах;
2. орон нутгийн өөрийн удирдлагын зарчимд тулгуурлан хот, тосгоны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны хүрээг тодотгох;
3. хот, тосгоны удирдлагыг сонгох, сонгогдох, иргэдэд ажлаа тайлагнах, хариуцлага тооцох механизмыг сайжруулах;
4. хот, тосгоны удирдлагын санхүү, төсөв, эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бататгах.

Дүгнэлт: Дээр дурдсан судалгааны хүрээнд дүгнэж үзэхэд засаг захиргааны нэгжийн хувьд ч, хотын хувьд ч орон нутгийн удирдах ёс, бие даасан байдлыг хангах нь чухал байх бөгөөд Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулахдаа хотын удирдлага хотынхоо нийгэм, эдийн засгийн асуудлаа бие даан шийдвэрлэх боломжтой байдлыг нь хангаж өгсөн зохицуулалтыг тусгах нь Үндсэн хууль болон олон улсын хотуудын эрх зүйн байдалтай нийцэхээр байна.

Улсын Их Хурал, Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс 2013-2016 онд хэрэгжүүлсэн “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн хүрээнд ажилласан эрдэмтдийн баг 2016 онд Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ хийсэн байх бөгөөд уг судалгаанд манай улсын хотын эрх зүйн байдалтай холбоотой дараах санал дүгнэлтийг тусгасан²⁰ байна. Үүнд:

- Үндсэн хуулийг боловсруулагчид зөвхөн Улаанбаатарыг хотын статустайгаар тодорхойлсон. Гэвч цаг хугацаа өнгөрөхийн хэрээр хоёрдогч хотууд томорч, тэдгээрийг тойрсон сумдын хамт засаг захиргааны ялгаатай зохион байгуулалт, удирдлагын бүтэц шаардлагатай болоод байна.

- Хөдөө орон нутагт тохируулан боловсруулсан захиргааны тогтолцоо хотын асуудлыг шийдвэрлэхэд тохиромжгүй тул нийслэл хотоос гадна хотуудын ангиллыг бий болгох шаардлага тулгарч байна. Үүнтэй холбогдуулж нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд, Үндсэн хуультай хамт батлагдсан, түүнтэй адил хүчин чадалтай Монгол Улсын Үндсэн хуулийн хавсралт хуулийн Дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт: “Хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтоож, түүний дагуу тэдгээрийн өөрийн удирдлагыг зохион байгуулах хүртэл Дархан, Чойр, Эрдэнэт хот одоогийн нутаг дэвсгэртээ аймагтай адилсах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалттай байна” гэж зааснаас үзвэл эдгээр хот зөвхөн түр хугацаагаар буюу Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль батлагдаж, түүнд улсын чанартай хотуудын өөрийн удирдлагын үндсийг тогтоох хүртэл аймгийн статустай байхаар заажээ. Гэтэл Улсын Их Хурал хот, тосгоны эрх зүйн байдлыг хуулиар тодорхойлохдоо зөвхөн орон нутгийн чанартай хотуудын эрх зүйн үндсийг тогтоосон нь Үндсэн хуулийн шинжтэй хуулиар өгсөн үүргийг биелүүлэхээс зайлсхийсэн гэж үзэх үндэстэй байна. Иймд улсын чанартай хотуудын эрх зүйн үндсийг тогтоох тухай 20 гаруй жилийн өмнөх Үндсэн хуулийн хүчинтэй заалтыг хожуу ч гэсэн хэрэгжүүлэх шаардлага Улсын Их Хурлын өмнө тулгарч байна.

²⁰ Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УБ., 2016 он. 149 дэх талд.

- Аймгийн төвийн сумдад ч мөн адил хотын асуудал үүсээд байгаа нөхцөл байдлыг харгалзан үзэж зохицуулалтын зохистой бүтцийг бий болгох шаардлагатай байгааг анхаарах хэрэгтэй.

- Орон нутгийн хотын статусыг байхгүй болгоод аймгийн төвийн сум бий болгосон нь аймагт давхар захиргаа бий болж чиг үүрэг нь давхцах болсон. Эдгээр сумдад ч мөн адил хотын асуудал үүсээд байгаа бөгөөд хөдөөгийн сумтай харьцуулахад үйлчлэх хүн амын тоо олон байдаг зэргийг харгалзан ялгаатай зохицуулалт шаардагдаж байгаа.

Энэхүү судалгааны тайланд дээр дурдсан санал дүгнэлтээ үндэслэн "Нийслэлээс гадна зарим нутаг дэвсгэрийн нэгжийг хот гэж хүлээн зөвшөөрөх шаардлага байгааг харгалзан Үндсэн хуульд "хот"-ын ангиллыг нэмж тусгах шаардлагатай" гэсэн зөвлөмж²¹ өгч байжээ.

Дээр дурдсан судалгаанаас гадна Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) болон Алмек корпораци, СиТи Ай Инженеринг Интернэйшнл ХХК, Ориентал консалтантс глобал ХХК хамтран Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгааг 2022 онд хийж гүйцэтгэсэн байна.

Энэхүү судалгаанд бусад улсуудын хот байгуулалтын туршлагыг жишээ болгон тусгасан ²² байх бөгөөд тэдгээрээс Хөшигийн хөндийд байгуулахаар төлөвлөж буй Шинэ Зуунмод хоттой газар нутаг, хүн ам, тээвэр ложистик гэх мэт нөхцөл байдал ойролцоо хотуудыг сонгон авч тэдний туршлага, хууль эрх зүйн зохицуулалтын талаарх мэдээллийг энэхүү судалгаанд ашиглалаа.

А.Япон улсын Цүкүба сургалт-судалгааны хотын тухай:

1950-аад онд Токио хотын хүн амын хурдацтай өсөлтөөс болж хэт ачаалалтай болсон Токио хотын төвлөрлийг сааруулах зорилгоор нийслэлийн зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх зорилгоор нийслэл Токио хотоосоо 50 км зайд орших газар тариалангийн бүс нутагт төрөөс санаачлан **Цүкүба сургалт-судалгааны хотыг** байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд шинжлэх ухаан, технологийн төвүүдээс (төрийн өмчит судалгааны хүрээлэн, их дээд сургууль) бүрдэх сургалт-судалгааны дүүрэг, түүний эргэн тойронд байрлах орон сууц, худалдаа үйлчилгээний байгууламж, аж үйлдвэрийн цогцолбор зэргээс бүрддэг байна. 1969 оны эхний төлөвлөгөөнд 4000 га талбайд (улсын байгууллагуудын барилга байгууламж 1,550 га, шинэ суурьшлын бүс 260 га, хувийн орон сууцны талбай 860 га, цэцэрлэгт хүрээлэн 28.5 га) 160,000 хүн ам амьдрахаар тусгагджээ.

Энэхүү хотыг байгуулах ажлыг дэмжих зорилгоор 1970 онд Цүкүба сургалт-судалгааны хотыг байгуулах тухай хуулийг баталсан байна. Уг хуулийг баталснаар төсөл хэрэгжүүлэх бүс нутаг болон төслийн оролцогч талуудын (Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа, төслийн хэрэгжүүлэгч хот дахин төлөвлөлтийн агентлаг/UR) үүрэг хариуцлага тодорхой болсон байна. Мөн төрийн байгууллагууд шинээр байгуулагдаж байгаа хотруу нүүж очих, эрдмийн хорооллоос гадна ойр орчмын

²¹ Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УБ., 2016 он. 150 дахь талд.

²² Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгааны тайлангийн II хавсралт-Хот байгуулалтын жишээ. Жайка, УБ.,2022 он,

газар нутгийн хот байгуулалтын үйл ажиллагааг хуулийн хамрах хүрээнд багтааснаар бүс нутгийн хэмжээний бүтээн байгуулалтын ажил хэрэгжих боломжтой болсон. Ингэснээр орон нутгийн засаг захиргаа нүүлгэн шилжүүлэх ажлыг дэмжин ажилласан²³ байна.

Түүнчлэн уг хуульд “санхүүжилтийн эх үүсвэр”-ийг тодорхой зааж, Засгийн газраас төслийн санхүүжилтийг хийх, тэгэхдээ Засгийн газрын боломжит санхүүжилтийн эх үүсвэрт багтааж төслийг хэрэгжүүлэх үүрэгтэй байхаар хуульчилсан байна. Мөн орон нутгийн захиргаа, олон нийтийн байгууллагад хандаж санхүү, техник, технологи, мэргэжлийн тусламж дэмжлэг үзүүлэх амлалт өгөх зэргээр тухайн төсөлд оролцох Засгийн газрын байр суурийг маш тодорхой зааж өгсөн байна.

Хуулийн бүтэц, агуулгыг доор үзүүлбэл:

Нэгдүгээр бүлэг.Зарчим

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго: ...хот байгуулалттай холбоотой нэгдсэн төлөвлөлтийг боловсруулж, түүнийг хэрэгжүүлснээрСургалт-судалгааны хотыг байгуулахын зэрэгцээ түүнд түшиглэсэн газар тариаланг хөгжүүлэх, нийслэл орчмын хүн амын хэт төвлөрлийг сааруулах...

2 дугаар зүйл.Тодорхойлолт

Хамрах хүрээ: Нийт 6 тосгон сууриныг хамруулах, Сургалт-судалгааны бүс, бусад бүс гэсэн 2 хэсэгт хуваах

Хоёрдугаар бүлэг.Сургалт-судалгааны хот байгуулах төлөвлөгөө

3 дугаар зүйл.Сургалт-судалгааны хот төлөвлөлтийн агуулга: Хүн амын болон газар ашиглалтын асуудлууд, нүүлгэн шилжүүлэх болон шинээр байгуулах байгууллагуудад зориулсан барилга байгууламжийг шинээр барих, тэдгээрт шаардагдах нийтийн аж ахуйн байгууламжууд, төрийн байгууллага, орон сууцуудыг барьж байгуулахтай холбоотой асуудлуудыг нийтэд нь хамарсан.

4 дүгээр зүйл.Сургалт-судалгааны хот байгуулах төлөвлөгөөг батлах: Газар, дэд бүтэц, тээвэр, аялал жуулчлалын сайд

5 дугаар зүйл.Сургалт-Судалгааны хот байгуулах төлөвлөгөөний өөрчлөлт
6 дугаар зүйл.Нийслэл орчмыг хөгжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулах

Гуравдугаар бүлэг.Дагуул хотыг хөгжүүлэх бүсийн төлөвлөлт

7 дугаар зүйл.Дагуул хотыг хөгжүүлэх бүсийн төлөвлөлтийн агуулга: Нийтийн аж ахуйн болон нийтийн эзэмшлийн байгууламжуудыг барьж байгуулах, газар тариаланд шинэ технологи нэвтрүүлэхэд шаардагдах байгууламжууд, хүн амын хэмжээнд тохируулан газар зохион байгуулалтыг хийх, нийслэл хот орчмыг хөгжүүлэх төлөвлөгөөтэй уялдсан Сургалт-судалгааны хотын төлөвлөлтийг боловсруулах, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх

²³ Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгааны тайлангийн II хавсралт-Хот байгуулалтын жишээ, А-24 дэх талд. Жайка, УБ.,2022 он,

8 дугаар зүйл. Дагуул хотыг хөгжүүлэх бүсийн төлөвлөлтийг боловсруулах: Орон нутгийн засаг захиргаа боловсруулан Дэд бүтэц, тээвэр, аялал жуулчлалын сайд батлах

Дөрөвдүгээр бүлэг.Сургалт-судалгааны хот байгуулах төлөвлөгөө болон Ойр орчмын төлөвлөлтийг хэрэгжүүлэх

9 дүгээр зүйл.Хэрэгжүүлэгчид: Төр, орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллагууд, Хот дахин төлөвлөлтийн хүрээлэн, бусад холбогдох оролцогчид

10 дугаар зүйл.Хамтын ажиллагаа

11 дүгээр зүйл.Олон нийтийг мэдээллээр хангах

12 дугаар зүйл.Хэрэгжилтийн нөхцөл байдал: Засгийн газраас парламентад төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах

13 дугаар зүйл.Санхүүжилтийн эх үүсвэр: Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг Засгийн газар бүрдүүлэх ба төрөөс тогтоосон санхүүжилтийн хүрээнд багтаан гүйцэтгэх. Мөн хэрэгжилтийг хангахад зайлшгүй шаардлагатай эдийн засгийн, санхүүгийн болон техник технологийн туслалцааг холбогдох байгууллагуудад үзүүлэх.

Энэ хуулийн дагуу Цүкүба сургалт судалгааны хотыг хөгжүүлэхдээ эхний ээлжинд улсын чанартай эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудыг нүүлгэн шилжүүлэх тухай хуулийг баталж хэрэгжүүлсэн байх бөгөөд зарим арга хэмжээний үр дүнгийн талаар авч үзвэл:

- анх Цүкүба сургалт, судалгааны хотод Токио дахь бүх их, дээд сургуулийг нүүлгэн шилжүүлж, 700 мянган хүн амтай хот байгуулах урьдчилсан төлөвлөгөөг хэлэлцэж байсан бол үүний дараа “Токио хотын нутаг дэвсгэр дээр заавал байх шаардлагагүй төрийн байгууллагын зарим нэгжийг (улсын сургууль г.м) нүүлгэн шилжүүлэх асуудлыг яаралтай хэлэлцэх” тухай Засгийн газрын шийдвэр гарсан байна. 1967 оны 9-р сард Засгийн газрын хуралдаанаар 6 яам, 36 байгууллагыг (түүний дараа 43 болж нэмсэн) нүүлгэн шилжүүлэхээр шийдвэрлэсэн боловч ихэнх байгууллагын барилгын ажил эхлээгүй тул 1970 оны 5-р сард Цүкүба сургалт, судалгааны хотын Барилгын тухай хуулийг хэрэгжүүлж улсын төсвийн хөрөнгөөр барилга байгууламжийг төлөвлөгөөтэйгөөр барьж байгуулан нүүлгэн шилжүүлэх ажлыг эрчимжүүлэх тогтолцоог бий болгожээ. Үүний үр дүнд Цүкүба их сургуулийн хамтаар 300 орчим эрдэм шинжилгээний байгууллага, 13,000 орчим судлаачийг нүүлгэн шилжүүлэх ажлыг 1980 онд дуусгасан;

- төрийн байгууллагуудыг нүүлгэн шилжүүлж дууссаны дараа 1982 онд хувийн хэвшлийн судалгаа, шинжилгээний цогцолбор (Токодай цогцолбор) байгуулагдаж, 1985 онд шинжлэх ухааны олон улсын үзэсгэлэн (экспо) зохион байгуулагдсанаар олон улсад танигдаж хувийн компаниуд ихээр суурьших болсон;

- хотын бүтээн байгуулалтын эхэн үед Засгийн газрын санаачилгаар орон сууц, худалдаа үйлчилгээний байгууламжийн бүтээн байгуулалт өрнөж байсан бол 1990 оноос хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн бүтээн байгуулалт эрчимжсэн;

- төр, хувийн хэвшлийн эрдэм шинжилгээ, судалгааны хамтын ажиллагаа идэвхжиж, олон улсын байгууллагууд үйл ажиллагаагаа өргөжүүлж эхэлсэн;

- 1970 онд 78,110 хүн амтай байхаар төлөвлөсөн хотын хүн ам эхний 10 жилд 127,401 болж анхны төлөвлөгөөнөөс 1.6 дахин, 50 жилийн дараа 2020 онд 240,383 болж 3 дахин нэмэгдсэн;

- 2005 онд Токиотой холбосон төмөр замын хурдан галт тэрэгний шугам Цүкүба экспресс нээгдсэний дараа шугам дагуух үл хөдлөх хөрөнгийн бүтээн байгуулалтын ажлыг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж хийж гүйцэтгэх болсон байна.

Цүкүба сургалт-судалгааны хотын хот байгуулалтын тойм²⁴



Цүкүба сургалт, судалгааны хотыг Судалгааны хот байгуулалтыг дэмжих төв зөвлөлөөс боловсруулсан бодлого, төлөвлөлтийн дагуу Газар, дэд бүтэц, зам тээвэр, аялал жуулчлалын яам голлох үүрэг гүйцэтгэн барилгын ажлыг хийж, хотын барилгын төслийг тус бүрийн холбогдох хуулийн дагуу Хот сэргээн босгох байгууллага, холбогдох яам, агентлаг, Ибараки мужийн захиргаа, Цүкүба хотын захиргаа болон бусад холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлжээ.

1963 оны сургалт-судалгааны хот байгуулах тухай Засгийн газрын тогтоол гарахаас өмнө нийслэлийн хүн амын төвлөрлийг сааруулах зорилгоор Нийслэлийн хөгжлийн хороо (Одоогийн Газар, дэд бүтэц, зам тээвэр, аялал жуулчлалын яам) нь эрдмийн хот, төрийн байгууллагууд байрлах хот, нийслэлийн дагуул хотуудын хот байгуулалт, хотын хөгжлийн үзэл баримтлалыг хэлэлцэж байжээ. 1963 оны сургалт-судалгааны хот байгуулах тухай Засгийн газрын тогтоол гарсны дараа холбогдох яам, агентлагийн уялдаа холбоог зохицуулах, төслийн явцыг эрчимжүүлэх зорилгоор Газар, дэд бүтэц, тээвэр, аялал жуулчлалын сайдаар ахлуулсан холбогдох яамдын төрийн нарийн бичгийн дарга нараас бүрдсэн Сургалт-

²⁴ Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгааны тайлангийн II хавсралт-Хот байгуулалтын жишээ, А-17 дахь талд. Жайка, УБ.,2022.

судалгааны хотын барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх төв зөвлөл байгуулах Засгийн газрын шийдвэр 1964 онд гарчээ. Энэхүү төв зөвлөл нь “Цүкүба сургалт-судалгааны хотын хот байгуулалтын төлөвлөгөөний тойм зураглал”, “Цүкүба сургалт-судалгааны хотын олон нийтийн барилга байгууламж барих төлөвлөгөөний тойм”, “Цүкүба сургалт-судалгааны хот руу байгууллагуудыг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний тойм” болон Цүкүба сургалт-судалгааны хот байгуулах тухай хуульд үндэслэн “Эрдмийн (сургалт-судалгааны) хороолол барих төлөвлөгөө”-г боловсруулсан байна. Барилгын ажлын нэгдсэн зохицуулалтыг Газар, дэд бүтэц, зам тээвэр, аялал жуулчлалын яамнаас хийж, мастер төлөвлөгөө боловсруулах, газар чөлөөлөх, инженерийн бэлтгэл ажлыг хийх зэрэг суурь дэд бүтцийн ажлыг Японы орон сууцны корпораци (Одоогийн Хот дахин төлөвлөлтийн агентлаг (UR) гүйцэтгэсэн байна²⁵.

Энэхүү арга механизм нь Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, задлах зорилгоор Шинэ Зуунмод дагуул хотыг байгуулах, түүний эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулахдаа авч хэрэгжүүлэх боломжтой, үр дүнтэй туршлага болохоор байна гэж дүгнэлээ.

Б.Япон улсын Макүхари шинэ төвийн бүтээн байгуулалтын тухайд:

Макүхари шинэ төв нь барилгажсан суурьшлын бүсийн дэргэд байгуулагдсан тул Монгол Улсад байгуулахаар төлөвлөж буй дагуул хотын бүтээн байгуулалтаас нөхцөлийн хувьд ялгаатай хэдий ч, төлөвлөж буй хүн амын тоо нь Шинэ Зуунмодтой ойролцоо тул жишээ болгон авч үзэв. Ижил хэмжээний хүн амын багтаамжтай бүтээн байгуулалт учир барих байгууламжууд, тэдгээрийн багтаамж, хөдөлмөр эрхлэгч хүн амын тооцоололд жишиг болгон авч үзэх боломжтой²⁶ гэж энэхүү хотын бүтээн байгуулалтыг харьцуулан үзсэн байна.

Макүхари шинэ төв нь Токио хот, Нарита нисэх онгоцны буудлын дунд, Токио хотоос 30 орчим км зайд байрлах далайг булж барьсан 552 га талбайд төлөвлөгдсөн, мужаас хэрэгжүүлсэн хот байгуулалтын төсөл юм. Төлөвлөгөөнд 36,000 (2008 онд 26,000 байсан) хүн амтай, 150,000 ажлын байртай байхаар тусгагдсан байна. Нарита нисэх онгоцны буудалд ойрхон тул олон улсын бизнесийн чиг үүрэг хэрэгжүүлэх хүрээнд жуулчид хүлээн авах зочид буудал, аутлет зэрэг худалдаа үйлчилгээний байгууламж, Нарита нисэх онгоцны буудлын ачаа тээвэрлэлт түгээлтийн агуулах зэргийг барьж байгуулсан нь Шинэ Зуунмод төслийн функцтэй төстэй гэж Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгааны баг үзсэн ба энэхүү судалгааны тайланд дараах арга хэмжээ, тоо баримтыг чухалчлан үзсэн:

- Макүхари Мессе үзэсгэлэнгийн танхимыг түшиглэн олон улсын бизнес, орчин үеийн дэвшилтэт, хөгжиж буй аж үйлдвэрийн салбар голчилсон судалгаа хөгжүүлэлт, дэвшилтэт технологийн салбарт тохирсон өндөр ур чадвар бүхий хүний нөөцийг хөгжүүлэх эрдэм шинжилгээ, боловсролын байгууллагуудыг багтаасан шинэ эрин үеийн нийгмийн хэрэгцээ, амьдралын хэв маягт тохирсон ажил, орон сууц, боловсрол, энтертейнмент гэсэн 4-н үндсэн цогц функцийг

²⁵ Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгааны тайлангийн II хавсралт-Хот байгуулалтын жишээ, А-23 дахь талд. Жайка, УБ., 2022.

²⁶ Мөн судалгааны тайлангийн II хавсралт-Хот байгуулалтын жишээ, А-23 дахь талд. Жайка, УБ., 2022.

нэгтгэсэн үзэл баримтлал бүхий олон улсын бизнесийн хот болох зорилготойгоор байгуулагдсан. Гэхдээ энэ бүтээн байгуулалт нь төмөр замтай, дэргэдээ суурьшлын бүстэй байршилд хийгдсэн учир, гаднаас ирж ажиллах хүн амын тоог нэмэгдүүлэх тал дээр гол анхаарлаа хандуулан, соёл боловсролын байгууллага, амралт зугаалгын газар, аж ахуйн нэгжийн барилга байгууламж барих зэрэг ажлаас бүтээн байгуулалтыг эхлүүлсэн байна.

- 1975 онд боловсруулсан үндсэн төлөвлөгөөний дагуу соёл-боловсролын бүс 1981 онд байгуулагдаж эхэлсэн ба 1985 онд батлагдсан хот байгуулалтын суурь төлөвлөгөөний дагуу хотын дэд бүтэц, 72 га хиймэл эрэг бүхий далайн эргийн цэцэрлэгт хүрээлэн, 54,000 га үзэсгэлэнгийн байгууламж (дараа нь 72,000 га болж өргөтгөсөн), мэргэжлийн бейсболын цэнгэлдэх хүрээлэн, бизнесийн хороолол барих бүтээн байгуулалтыг хийсэн. 1995 онд орон сууцны барилга ашиглалтад орж, иргэд шилжин суурьшиж эхэлж, оршин суугчдын тоо 2001 онд 10 мянга байсан бол суурь төлөвлөлт боловсруулснаас хойш 30 жилийн дараа буюу 2006 онд 20 мянга давсан байна.
- 2016 оноос нийт 17,5 га талбайд 10,000 оршин суугчтай, 4,500 орчим айлын өндөр давхрын 6 орон сууцны барилгыг тойрсон офис, худалдаа үйлчилгээний төв бүхий шинэ хотхоныг цогцоор байгуулах ажлыг эхлүүлэн одоо ч төсөл хэрэгжих шатандаа явж байна.
- төмөр замын шугамтай, ойр орчимдоо суурьшлын бүстэй тул боловсрол, судалгааны байгууллага, бизнесийн бүс болгон хөгжүүлэхээр зорьж хөдөлмөр эрхэлж буй хүн амыг суурин хүн амын тооноос олон байна гэж үзсэн байна. Гэтэл хөдөлмөр эрхэлж буй хүн амын тоо дөнгөж 40 мянга байгаа нь төлөвлөсөн хөдөлмөрийн хүн амын дөнгөж 27 хувьтай тэнцэж байна.

Макухари шинэ төвийн бүтээн байгуулалтын агуулга²⁷



²⁷ Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгааны тайлангийн II хавсралт-Хот байгуулалтын жишээ, А-18 дахь талд. Жайка, УБ.,2022.

В.Япон улсын Тама шинэ суурины тухайд:

Тама шинэ суурины бүтээн байгуулалтыг 1963 онд батлагдсан Шинэ суурьшлын бүс хөгжүүлэх тухай хуульд үндэслэн хэрэгжүүлжээ. Энэ хууль нь хүн амын нягтрал хэт их хот, суурин газрын эргэн тойрны бүсэд дан орон сууцны хороолол барих, орон сууцаар хангагдаагүй иргэдэд амьдрах таатай орчин бүрдүүлсэн орон сууцыг олноор нийлүүлэх зорилготой байсан ба бүс нутгийг бүхэлд нь суурь дэд бүтцээр хангах үүднээс дан ганц орон сууцаар зогсохгүй зам, цэцэрлэгт хүрээлэн, сургууль, эмнэлэг, худалдааны төв, оффис зэрэг хотын цогц үүрэг гүйцэтгэх шинэ хороолол барих бүтээн байгуулалт болсон байна.²⁸

Энэ бүтээн байгуулалт нь Хачи-Ожи, Мачида, Тама болон Инаги гэсэн 4 хотыг хамарсан нийт 2,853 га, 14 км өргөн, 2-3 км урт газарт төлөвлөгдсөн, Токио хотоос хэрэгжүүлсэн шинэ суурин байгуулах төсөл юм. 1963 онд төлөвлөлт эхэлсэн бөгөөд анх 300,000 оршин суугчтай, ажиллах хүн ам 50,000 байхаар тооцсон байв. 1971 онд анхны оршин суугчдаа хүлээн авсан ба 2019 оны байдлаар 220,000 хүн амтай болсон. Төсөл хэрэгжүүлэгч нь Токио хотын захиргаа, Токио хотын орон сууцны корпораци/UR. 1963 онд Өмнөд Тама хотын хот байгуулалтын нэгдсэн төлөвлөгөө боловсруулах хороо байгуулагдаж, ерөнхий төлөвлөгөөг боловсруулснаар төсөл эхэлсэн. 1966 онд холбогдох байгууллагын уялдааг хангах зорилгоор "Өмнөд Тама хот байгуулалтын захиргаа"-г Токио хотын захиргааны харьяанд байгуулж газар зохион байгуулалт зэрэг ажлыг хэрэгжүүлж, 1970 онд холбогдох хотуудтай тохиролцож 5 түвшний зохицуулалтын бүтцийг бий болгосон байна²⁹. Үүнд:

Тама шинэ суурины бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх бүтэц

Бүтэц	Гишүүд
1.Төлөвлөлтийн хороо (Хотын захирагч ахалдаг дээд шатны хурал)	Хотын захирагч, дэд захирагч, холбогдох хотуудын дарга, Хот дахин төлөвлөлтийн агентлагийн дарга, Төрийн өмчит компанийн ТУЗ-ийн дарга, Шинэ хотын төв ХК-н захирал
2.Хэрэгжилтийг хангах зөвлөл (Бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах)	Өмнөд Тама шинэ хот байгуулалтын захиргааны дарга, тухайн захиргааны барилгын хяналтын дарга, холбогдох хотуудын даргын туслах, Хот дахин төлөвлөлтийн агентлагийн Өмнөд Тама хариуцсан газрын дарга, төрийн байгууллагуудын газрын асуудал хариуцсан байгууллагын дарга
3.Ажлын хэсэг (2-д дурдсан хорооны дэд хэсэг бөгөөд тулгарсан асуудлыг шийдэх)	Шинэ Тама хот байгуулалтын захиргааны төлөвлөлт хариуцсан нарийн бичиг, тухайн захиргааны болон холбогдох хотуудын төлөвлөлтийн албаны дарга, Хот дахин төлөвлөлтийн агентлагийн Өмнөд Тама бүтээн байгуулалтын нэгжийн, төрийн байгууллагын газрын асуудал хариуцсан албаны дарга
4.Шинэ хотхоны хуралдаан (хотын түвшний төлөвлөлтийн асуудалд чиглэсэн арга хэмжээ, судалгаа, шинжилгээ, иргэдийн хүсэлтийг сонсох)	Холбогдох хотуудын захирагч нар болон хурлын дарга нар
5.Шинэ хотын ажлын хэсэг (4.-т дурдсан хурлын дэд хэсэг бөгөөд хотын түвшинд ажлыг уялдуулах)	Холбогдох хотуудын дарга нар

²⁸ Мөн тайлангийн II хавсралт-Хот байгуулалтын жишээ, А-26 дахь талд. Жайка, УБ.,2022 он,

²⁹ Мөн тэнд.

Япон улсад Цүкүба, Макүхари 2 шинэ хот байгуулсан туршлагаас Шинэ Зуунмод хотыг байгуулах үйл ажиллагаанд жишиг болгон ашиглах боломжтой санааг Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгааны баг дараах байдлаар тодорхойлсон³⁰ байгааг хуулийн төсөл боловсруулахдаа анхаарч үзэх нь зүйтэй юм.

- **Нийслэлийн чиг үүргийг шилжүүлэн хуваарилах:** Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын зорилго нь дээрх 2 хотын адилаар нийслэлийн хэт төвлөрлийг саармагжуулах явдал юм. Цүкүба хот нь шинжлэх ухаан, технологийн гол төв болох, Макүхари нь үзэсгэлэнгийн танхим түшиглэн олон улсын бизнесийн харилцаа болон орчин үеийн дэвшилтэт, хөгжиж буй аж үйлдвэрийн салбар голчилсон үйл ажиллагаа, судалгаа хийх үүрэг бүхий хот юм. Ихэнх байгууламж нь дэвшилтэт технологиор тоноглогдсон, зай талбай ихтэй, тухтай орчин нөхцөлийг бүрдүүлж чадсан юм. Жишээлбэл Малайзын Путражая хот, Египетийн Каир хотын чиг үүргийг өөр хотод шилжүүлэх үед захиргааны чиг үүрэг, холбогдох ажилтнуудыг шилжүүлэх ажил хийгдэж байсан бол Шинэ Зуунмод хотод захиргааны чиг үүргийг шилжүүлэх төлөвлөгөө байхгүй байна. Ялангуяа Японд их, дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн түшиглэсэн хот байгуулалтын жишээ олон байдаг бөгөөд Цүкүба сургалт судалгааны хот нь үүнийг төлөөлөхүйц бүтээн байгуулалт юм. Цүкүба сургалт судалгааны хотод томоохон хотод байрлах шаардлагагүй эрдэм шинжилгээний хүрээлэн, их дээд сургуулиудыг нийтэд нь нүүлгэх бодлого баримталсан байна.
- **Хэрэглэгчийг татах механизм бүрдүүлэх:** Эдгээр хот байгуулалт нь үл хөдлөх хөрөнгийн болон аж үйлдвэрийн бүтээн байгуулалтаар зогсохгүй гаднаас хэрэглэгч татах механизмыг бүрдүүлж өгсөн байна. Цүкүба хот нь олон улсын экспо нээх замаар олны анхаарлыг татаж, олон улсын хурал зөвлөгөөнийг зохион байгуулж сургалт судалгааны хотын статусаа гадаад дотоодод таниулж ирсэн. Макүхари хотын хувьд цэнгэлдэх хүрээлэн, асар том үзэсгэлэнгийн танхимдаа төрөл бүрийн үзэсгэлэн худалдаа, концерт зэргийг зохион байгуулж хэрэглэгчдийг татан авчирч байна. Иргэд цуглах, зочид айлчлан ирэх боломжийг бий болгосноор олонд танигдаж, танил дотно мэдрэмж төрүүлэхийн зэрэгцээ орон нутгийн дүр төрхийг тодорхойлж, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэн бүс нутгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг. Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалт ч мөн адил Монголд цөөн байдаг үзэсгэлэнгийн танхим байгуулж, томоохон арга хэмжээ (жишээлбэл, Монгол судлалын эрдэм шинжилгээний хурал, олон улсын хурал зөвлөгөөн)-г зохион байгуулах замаар хэрэглэгчдэд танигдаж, тэднийг татах механизмыг хот байгуулалтын төлөвлөгөөнд тусгах нь зүйтэй юм.
- **Нутгийн иргэдийн ашиг сонирхлыг хүндэтгэн үзэх:** Цүкүба сургалт судалгааны хотын бүтээн байгуулалтыг хийх зорилгоор 1966 оноос эхлэн газар чөлөөлөх бодлогын хүрээнд тариаланчдын хөдөлмөр эрхлэлт, амьжиргааг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсний зэрэгцээ уугуул болон шинээр шилжин суурьшсан суугуул иргэдийн хамтран амьдрах орчныг бүрдүүлэх тал дээр сайтар бодолцон төслийг хэрэгжүүлсэн байна. Монгол Улсын хувьд Зуунмод, Сэргэлэн сум нь газар тариалан, мал аж ахуй зонхилсон нутаг болохын хувьд бэлчээр нутагт нь бүтээн байгуулалт хийснээр малчид, тариаланчдын амьжиргаанд урт

³⁰ Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгааны тайлангийн II хавсралт-Хот байгуулалтын жишээ, А-19, 20 дахь талд. Жайка, УБ., 2022 он,

хугацаандаа нь сөрөг нөлөө үзүүлэхгүй байх тал дээр сайтар анхаарч, шинээр суурьшсан иргэдтэй эдийн засгийн ялгаа гарахгүй байхаар малчид, тариаланчдын ирээдүйг харсан төсөл хэрэгжүүлэх шаардлагатай. Түүнчлэн, уугуул, суугуул иргэд хоорондын зөрчилдөөн гарахгүй байх бодлого боловсруулах шаардлагатай юм гэжээ.

Г.Нисэх онгоцны буудал түшиглэн хөгжиж буй хотуудын сайн туршлагын тухайд:

БНСУ-ын Инчон нисэх онгоцны буудлын сайн жишээ нь “нисэх онгоцны буудлыг түшиглэсэн хот байгуулалт” гэдгээр дэлхий дахины анхаарлыг татаж байгаа болохыг 2019 онд батлагдсан Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган бий болох шинэ хотын ерөнхий төлөвлөгөөний тодотголд дурдсан байна. Түүнчлэн Амстердамын Шипхолл нисэх онгоцны буудал (Нидерланд), БНХАУ-ын Зэнзоу нисэх онгоцны буудал орчмын хот байгуулалтыг уг ерөнхий төлөвлөгөөнд жишээ болгон дурдсан байдаг ч эдгээр нисэх онгоцны буудлын цар хүрээ Монголтой харьцуулах аргагүй маш том тул Шинэ Зуунмодын хот байгуулалттай жиших нь өрөөсгөл болно. Гэвч эдгээр хот байгуулалтын туршлагыг дараах 2 зүйлд жишиг болгон ашиглах боломжтой гэж Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгааны баг үзсэн³¹ байна. Үүнд:

1.Нисэх онгоцны буудлыг түшиглэсэн хот байгуулалтын онцлогийг ашиглах: Дээр дурдсан нисэх онгоцны буудлын хотууд нь эргэн тойрон 20-30 км тойрог радиус дотор тээврийн сүлжээгээр холбогдсон байх бөгөөд нисэх буудлын хамаарал бүхий байгууллага болон холбогдох орон сууцны барилгын хорооллоос бүрдэж эдгээр хороолол, кластер тус бүр нисэх онгоцны буудалтай саадгүй холбогдох байдлаар тээврийн сүлжээг төлөвлөж өгсөн байна. Ингэснээр ханган нийлүүлэгч, үйлчлүүлэгч, хамтран ажиллагч байгууллагуудын холбогдох цаг хугацааны болон бодит зардлыг хамгийн бага хэмжээнд барихаас гадна үр ашгийг хамгийн их байлгах хот байгуулалтын зорилгыг биелүүлэх боломжтой болдог аж. Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах, цаг хугацааны алдагдлыг багасгах, дотооддоо болон олон улстай холбогдох өндөр хурдны төмөр зам зэрэг ачаа тээврийн сүлжээ, логистикийн асуудал нь хамгийн чухал нөхцөл юм. Түүнчлэн сэтгэл татам хот болгон хөгжүүлэхийн тулд өндөр орлоготой ажлын байр, боловсрол, энтертейнментээр хангах, тухайн хотод ажилладаг иргэд болон онгоцоор ойр ойрхон зорчдог үйлчлүүлэгчдэд зориулсан орон сууц, худалдааны цогцолборуудыг хөгжүүлэх замаар амьдрах орчныг сайжруулах шаардлагатай юм. Шинэ Зуунмод хот ч мөн адил эдгээр нөхцөлүүдийг зайлшгүй хангах шаардлагатай.

2.Ирээдүйд тэлэх боломжтой газрын нөөцтэй байх: Жишээлбэл Шипхолл онгоцны буудал зорчигчдын болон ачаа тээврийн өсөлттэй холбогдуулан олон жил тасралтгүй өргөтгөл хийсээр ирсэн бөгөөд онгоцны буудлын талбай томрохын хэрээр ойр орчмын хотын цар хүрээ томордог байна. Шинэ Зуунмод хот ч мөн адил ойр орчмын томоохон газрыг улсын тусгай хэрэгцээнд аван ирээдүйд өргөжүүлэх боломжийг хадгалах нь зүйтэй гэжээ.

Д.Казакстан улсын Астана хотын эрх зүйн зохицуулалтын тухайд:

³¹ Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгааны тайлангийн II хавсралт-Хот байгуулалтын жишээ, А-20, 21 дэх талд. Жайка, УБ.,2022 он,

Астана хот 2001 онд тус улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2027 оны 12-р сар хүртэл эдийн засгийн тусгай бүсийн статустайгаар албан ёсны үйл ажиллагаа явуулахаар байгуулагдсан байна.

1) Бүсийн тойм/ онцлог

Астана шинэ хот ЭЗТБ



Захиргааны/ Бизнесийн төв/ Эрүүл мэнд болон боловсролын бүс/ Олон улсын санхүүгийн төв
- талбай: 6603.5 га

1996 онтой харьцуулахад Астана шинэ хотын ЭЗТБ нь дараах байдлаар хөгжиж байна (2017 оны байдлаар);

- ДНБ: 187 дахин
- Хүн ам: 3 дахин
- * Астана хот 2020 оны байдлаар 1.2 сая хүн амтай.
- Жилийн хөрөнгө оруулалтын хэмжээ: 40 дахин
- * Астана хотын ЭЗТБ нь 15 тэрбум ам. доллартай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтын 2,5 тэрбум ам.долларыг хүлээн авсан.
- ЖДҮ-ийн тоо: 21 дахин



ЭЗТБ нь дараах чиглэлээр SMART-City технологийг нэвтрүүлэхээр чармайж байна;

- эрчим хүч хэмнэх
- Олон нийтийн үйлчилгээний тарифын төлбөр
- Ослын эрсдэлийг хянах

Астана хотын бүтээн байгуулалт, хөгжүүлэлтийг Эдийн засаг, аж үйлдвэрийн тусгай бүсийн тухай хууль (2011/19), "Астана-Шинэ хот"-ын тухай журам (2017)-аар зохицуулдаг байна.

Эдийн засаг, аж үйлдвэрийн тусгай бүсийн тухай хуулиар доор дурдсан харилцааг зохицуулж байна. Үүнд:

- Засгийн газрын чиг үүрэг, оролцоо /Төрийн захиргааны төв байгууллага, эрх бүхий байгууллага, улсын төлөвлөлтийн газар, татвар, гааль, бүс, хот, нийслэлийн гүйцэтгэх байгууллагын чиг үүрэг, хэрэгжүүлэх ажлууд/;
- ЭЗТБ-ийг байгуулах, ажиллуулах, татан буулгах /ЭЗТБ байгуулах журам, ЭЗТБ-ийн үйл ажиллагааны нөхцөл, ЭЗТБ-ийн оролцогчоор үйл ажиллагаа эрхлэх болон үндсэн бус үйл ажиллагаа эрхлэх хүсэлтийг шалгах журам, ЭЗТБ-ийн тэргүүлэх ач холбогдолтой үйл ажиллагааны жагсаалтад оруулах журам, ЭЗТБ-д төрийн үйлчилгээ үзүүлэх, ЭЗТБ-ийг татан буулгах, ЭЗТБ-ийг удирдах компани байгуулах, чиг үүрэг, удирдлагын үйл ажиллагаа эрхлэх иргэдийг сонгох, ЭЗТБ-ийн оролцогчид болон үндсэн бус үйл ажиллагаа эрхэлдэг иргэдийн эрх үүрэг, хэрэгжилтэд хяналт тавих, удирдах компанийн санхүүжилт/;
- ЭЗТБ-ийн удирдлага /ЭЗТБ-ийг удирдах компани байгуулах, чиг үүрэг, удирдлагын үйл ажиллагаа эрхлэх иргэдийг сонгох, ЭЗТБ-ийн оролцогчид болон үндсэн бус үйл ажиллагаа эрхэлдэг иргэдийн эрх, үүрэг, хэрэгжилтэд хяналт тавих, удирдах компанийн санхүүжилт/;
- ЭЗТБ-ийн үйл ажиллагааны эрх зүйн тусгай дэглэм ба нөхцөл /ЭЗТБ-ийн тусгай эрх зүйн дэглэм, оролцогч/удирдах компаниудын татвар, гаалийн зохицуулалт,

гаалийн чөлөөт бүсийн гаалийн журамд оруулсан бараа, ЭЗТБ-д гадаадын ажиллах хүч татах, ЭЗТБ-ийн оролцогчдын эрх зүйн хамгааллын баталгаа, ЭЗТБ-ийн төр, хувийн хэвшлийн түншлэл/.

Казахстан улс дээрх хуулийн дагуу нийт 13 ЭЗТБ байгуулсан байх бөгөөд эдгээрийн дотор "Астана Шинэ Хот" ЭЗТБ нь тусгай журмаар зохицуулагддаг. Энэ журмаар зорилго, дэмжих эдийн засгийн үйл ажиллагааны төрөл, менежмент, татвар, гаалийн дэглэм, гадаадын иргэдийг ажиллуулах, нэвтрүүлэх журам зэргийг тодорхойлсон байдаг.

Бусад улсуудын хувьд авч үзвэл эдийн засгийн тусгай бүсийн тухай хуулийн дагуу хотыг байгуулж, хөгжүүлж байгаа улсууд цөөнгүй байна.

Манай улсын хувьд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нийслэл эдийн засгийн тусгай бүстэй байх, эдийн засгийн тусгай бүсийг нийслэлийн нутаг дэвсгэр, дагуул хот болон бусад орон нутагт тухайн засаг захиргааны нэгжтэй тохиролцсоны үндсэн дээр Засгийн газрын шийдвэрээр байгуулах зохицуулалт тусгагдсан ³² бөгөөд одоогийн байдлаар ЭЗТБ байгуулагдаагүй байна.

Ийм учраас Шинэ Зуунмод хотын эрх үйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулахдаа Шинэ Зуунмод хотын эдийн засгийн бүсийн асуудлыг тусгаж өгөх нь зүйтэй байна.

Е.Япон улсын Кансай соёл, шинжлэх ухаан, судалгааны хот (Kansai Science City)-ын тухайд:

Кансай хот 15 мянган га орчим талбайтай ба тооцоолсон хүн амын тоо 410,000 ба 2023 оны 4 дүгээр сарын байдлаар 254,000 хүн амтай болсон байна.

Соёл, эрдэм шинжилгээ, судалгааны дүүрэгтэй ба хотын бүтээн байгуулалтын ач холбогдол ба философи нь соёл, шинжлэх ухаан, судалгаа шинжилгээний шинэ хөгжлийн үндсийг бий болгох, Японд төдийгүй дэлхийн хэмжээнд соёл, шинжлэх ухаан, судалгааг хөгжүүлэхээс гадна улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, ирээдүйд анхдагч мэдлэг бүтээгч хотын үндэс суурь болох явдал бөгөөд хотын бүтээн байгуулалтын үйл ажиллагааг 1987 онд батлагдсан Кансай соёл, шинжлэх ухаан, судалгааны хотын бүтээн байгуулалтыг дэмжих тухай хуулиар зохицуулж байна.

Энэхүү хуулийн төслийн бүтцийг авч үзвэл:

1 дүгээр зүйл.Зорилго: (Кансай соёл, шинжлэх ухаан, судалгааны хотын бүтээн байгуулалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, түүний хэрэгжилтийг дэмжсэнээр соёл, шинжлэх ухаан, судалгааны төв болох хотыг байгуулан манай улс болон дэлхийн соёлын хөгжил, үндэсний эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой.)

2 дугаар зүйл.Нэр томьёо

3 дугаар зүйл.Үндсэн зарчмыг тодорхойлох, өөрчлөх (Газар, дэд бүтэц, тээвэр, аялал жуулчлалын сайд холбогдох мужийн захирагчийн саналыг хүлээн

³² Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 38.1 дэх хэсэг.

авч, холбогдох төрийн захиргааны байгууллагын удирдлагатай зөвшилцөнхотын хот байгуулалтын үндсэн зарчмыг тодорхойлно.)

4 дүгээр зүйл.Үндсэн зарчмын агуулга

5 дугаар зүйл.Барилгын ажлын төлөвлөгөө боловсруулах (Холбогдох байгууллагатай хамтран ажиллах, процедур зэрэг)

6 дугаар зүйл.Барилгын ажлын төлөвлөгөөний агуулга

7 дугаар зүйл.Барилга байгууламж барих (ЗГ-ын хариуцлага, дэмжлэг)

8 дугаар зүйл. Санхүүжилт (ЗГ-ын хариуцлага, дэмжлэг)

9 дүгээр зүйл.Орон нутгийн бондын тухай заалт

10 дугаар зүйл.Татварын арга хэмжээ (Аж ахуй нэгжийн татварын элэгдэл тооцох тусгай зохицуулалт)

11 дүгээр зүйл.Орон нутгийн татварыг ялгавартай ногдуулах тухай

12 дугаар зүйл.Тариалангийн газрын тухай хуульд заасан зөвшөөрөл.

Гадаад орны туршлагаас харахад хот байгуулалтын суурь нь төлөвлөлт бөгөөд эдийн засгийн үр өгөөж, иргэдийн эрх, ашиг сонирхлыг нэгдүгээрт тавьсан байгаа нь дагуул хот байгуулах үндсэн зорилго, хөгжлийн бодлогын хувьд адил байна гэж үзлээ.

ЗУРГАА.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэсэн энэхүү судалгааны үндсэн дээр “Шинэ Зуунмод” дагуул хот байгуулах, түүний эрх зүйн байдлыг тодорхойлох асуудлыг нийслэлээс бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байгуулж байгаа онцлогийг нарийвчлан тусгасан, нийслэлд болон Төв аймагт аль алинд нь эерэг үр нөлөө үзүүлэх боломжтой байдлаар хуулийн төсөл боловсруулж батлах нь Үндсэн хууль болон олон улсын хотуудын эрх зүйн байдалтай нийцэхээр байна гэж дүгнэж байна.

Үүний тулд хуулийн төсөл боловсруулахдаа дараах санал, зөвлөмжийг харгалзан үзэж холбогдох зохицуулалтыг тусгах нь зүйтэй байна. Тухайлбал:

- засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд ч, хотын хувьд ч орон нутгийн удирдах ёс, бие даасан байдлыг хангах нь чухал байх тул хотын удирдлага хотынхоо нийгэм, эдийн засгийн асуудлаа бие даан шийдвэрлэх эрх зүйн үндсийг тогтоож өгөх;
- Шинэ Зуунмод хотыг шинээр бүтээн байгуулах үйл ажиллагаа нь хөрөнгө, санхүүгээс шууд хамаарах тул хөрөнгө оруулалтын асуудлыг, түүний дотор хотын төсвийн “санхүүжилтийн эх үүсвэр”-ийг тодорхой зааж, УИХ, Засгийн газар, нийслэл, орон нутаг хотын бүтээн байгуулалтын санхүүжилтийг тодорхой хугацаанд, тодорхой хэмжээгээр заавал бүрдүүлэх үүрэгтэй байхаар хуульчлах;
- хотын удирдлагын тогтолцоог олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн тодорхойлж, хотын удирдлагаа оршин суугчид нь сонгодог байх, бүтээн

байгуулалтын ажлыг төр, хувийн хэвшлийн оролцоотой хуулийн этгээд /developer/ хэрэгжүүлдэг байх эрх зүйн орчныг бий болгох;

- Токиотой холбосон төмөр замын хурдан галт тэрэгний шугам болох Цүкүба экспресс нээгдсэний дараа шугам дагуух үл хөдлөх хөрөнгийн бүтээн байгуулалтын ажлуудыг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж хийж гүйцэтгэх болсон сайн туршлагыг нэвтрүүлэх эрх зүйн орчныг бий болгох;
- нийслэлийн төвлөрлийг сааруулах зорилго болон Шинэ Зуунмод хот нь хүн амын нягтрал хэт их хот, суурин газрын эргэн тойрны бүсэд хамаарах тул нийслэлээс иргэд шилжин очих чухал нөхцөл болох орон сууцны хороолол барих, орон сууцаар хангагдаагүй иргэдэд амьдрах таатай орчин бүрдүүлсэн орон сууцыг нийлүүлэхийн тулд бүс нутгийг бүхэлд нь суурь дэд бүтцээр хангах, орон сууцаар зогсохгүй зам, цэцэрлэгт хүрээлэн, сургууль, эмнэлэг, худалдааны төв, оффис зэрэг хотын цогц үүрэг гүйцэтгэх шинэ хорооллыг барихдаа нийслэлийн алдааг давтахгүй байх, зөв төлөвлөх, төлөвлөлтөө зөрчихгүй байх, зөрчсөн тохиолдолд хатуу хариуцлага хүлээх нөхцөлийг бүрдүүлэх;
- төрийн байгууллага, их, дээд сургууль, МСҮТ, эрдэм шинжилгээний байгууллагуудыг нүүлгэн шилжүүлэх зарчим, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх зарчмыг тогтоож, төрийн байгууллага манлайлах үүрэгтэй болохыг тодорхойлох, хувийн хэвшлийг урамшуулах, дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бий болгох;
- томоохон хот буюу нийслэлд байрлах шаардлагагүй эрдэм шинжилгээний хүрээлэн, их дээд сургуулиудыг нийтэд нь нүүлгэх бодлого, хэрэгжүүлэх механизмыг тодорхойлох;
- хот байгуулалт нь үл хөдлөх хөрөнгийн болон аж үйлдвэрийн бүтээн байгуулалтаас гадна олон улсын экспо нээх, олон улсын хурал зөвлөгөөн, үзэсгэлэн худалдаа, урлаг соёлын үйл ажиллагаа зохион байгуулах, замаар бусад улсын анхаарлыг татаж гадаад, дотоодын хэрэглэгчийг татах механизм бүрдүүлэх;
- эдийн засгийн тусгай бүсийн тухай хуулийн дагуу хотуудыг байгуулж, хөгжүүлж байгаа олон улсын туршлага болон МУНУБХЭЗБТХ-ийн дагуу Шинэ Зуунмод хотод эдийн засгийн тусгай бүс байгуулах асуудлыг тодорхойлох;
- уугуул иргэд болон шинээр шилжин суурьших иргэдийн хамтран амьдрах орчныг бүрдүүлэх, орон нутгийн иргэдийн ашиг сонирхлыг хүндэтгэн үзэх гэх мэт.

ДОЛОО.АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль;
3. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль;
4. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль;
5. Инновацийн тухай хууль;
6. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050";
7. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө;
8. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 154 дүгээр тогтоол;
9. Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө;
10. Үндэсний статистикийн хороо, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гаргасан "Улаанбаатар хотын агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө" 2020 он;
11. Үндэсний статистикийн хороо, Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх хүн амын хувьд тооцсон төрөлтийн дундаж бууралттай үеийн хүн амын тооны төсөөлөл;
12. Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбооны 2022.05.30-ний олон улсын тээвэр логиستيкийн өнөөгийн байдал, импортын ачааны саатал, шийдлүүд танилцуулга;
13. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар "Төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний баримт бичиг" 2022 он;
14. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Статистик мэдээлэл;
15. Нийслэлийн статистикийн газар, Дотоодын нийт бүтээгдэхүүний мэдээлэл;
16. Нийслэлийн статистикийн газар, Хотжилт ба хүн амын амьдралын чанарт хийсэн дүн шинжилгээ;
17. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УБ., 2016 он;
18. Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал орчмын хот байгуулалтын талаар мэдээлэл цуглуулах судалгааны тайлан. Жайка, УБ., 2022 он;
19. Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбооны 2022.05.30-ны олон улсын тээвэр логиستيкийн өнөөгийн байдал, импортын ачааны саатал, шийдлүүд танилцуулга;
20. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь /Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж/. УБ. 2019 он.
21. Үндэсний статистикийн хороо, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гаргасан "Улаанбаатар хотын агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө" 2020 он, Т-14
22. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар "Төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний баримт бичиг" 2022 он, Т-4
23. <https://ulaanbaatar.mn/home>, Үндэсний статистикийн хорооны мэдээлэл.

-----oOo-----

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

“ШИНЭ ЗУУНМОД” ХОТЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА	
УДИРТГАЛ	3
НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ	4
ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ	6
2.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал:	6
2.2.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал:	6
2.3.“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал:	7
2.4.“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал:	8
2.5.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал:	8
ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ	10
3.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:	10
3.2.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:	14
3.3.“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:	20
3.4.“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:	21
3.5.“Хуулийн төслийн харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:	23
ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ	26
4.1.Баримтжуулалт	26
4.2.Үнэлэлт, дүгнэлт	26
4.2.1.Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр:	26
4.2.2.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр:	26
4.2.3.“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтээр:	28
4.2.4.“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр:	28
4.2.5.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр:	29
4.3.Зөвлөмж	29
ТАВ.АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	31

УДИРТГАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 1.1-д хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлнэ гэж тусгасан. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалыг баталсан.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/1542 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн боловсруулсан Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл /цаашид "хуулийн төсөл" гэх/ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22.1.1-д заасан анхдагч хуулийн төсөлд хамаарч байх тул уг хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, судалгааны тайлан боловсруулах ажлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 1.4-т заасны дагуу дараах үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх;
4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх.

Энэхүү судалгааны зорилго нь Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн практикт хэрэгжих боломж, харилцан уялдаа, үүсэх үр дагавар зэргийг тооцох, эрх зүйн зохицуулалтын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж өгөхөд оршино.

НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд дурдсан үндсэн шалгуур үзүүлэлтээс дараах 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

- 1.Зорилгод хүрэх байдал;
- 2.Практикт хэрэгжих боломж;
- 3.Ойлгомжтой байдал;
- 4.Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
- 5.Харилцан уялдаа.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгож авахдаа дараах үндэслэлийг харгалзан үзсэн болно.Үүнд:

1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хувьд Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн “1.1.Энэ хуулийн зорилго нь бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон зайн оновчтой төлөвлөлт бүхий дагуул хот байгуулах зорилтын хүрээнд Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлыг тогтоож, хотын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тогтвортой хөгжлийг дэмжих бодлогыг тодорхойлоход оршино.” гэсэн зохицуулалт, холбогдох арга хэмжээ нь хуулийн төслөөр тавьсан зорилгодоо хүрч чадах эсэхийг тооцон судлахад ашиглана.

Мөн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 9.5.2, 9.5.3-т Хөшигийн хөндийд байрлах олон улсын нисэх онгоцны буудлыг даган байгуулагдах “Шинэ Зуунмод” шинэ дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, инженерийн шугам сүлжээ, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд тус үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах хүрээнд Шинэ Зуунмод хотыг нийслэлийн дагуул хотын статустайгаар эрх зүйн байдлыг тодорхойлсон хуулийн төслийг боловсруулж батлах хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна гэж хууль санаачлагч үзсэн байна.

Иймд дээрх зорилтод хүрэх ач холбогдол бүхий зүйл, заалт төсөлд тусгагдсан эсэхийг шинжилнэ.

2.”Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгадаг тул тус үзүүлэлтийг сонгон авлаа.

3.“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд хэл зүй, найруулгын хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэхийг шалгах, үнэлэх юм.

Хууль ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөтэй тул тухайн хуулийн төслийн үг хэллэг нь хоёрдмол утга санаагүй, Монгол хэл бичгийн дүрэмд нийцсэн, утга найруулгын хувьд зөв хэрэглэсэн эсэхийг тодруулах шаардлагатайг харгалзан энэ шалгуур үзүүлэлтийг сонгосон.

4.“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийг “тухайн хуулийн төсөлд төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгох, чиг үүрэг нэмэх зохицуулалтыг тусгасан бол шалгах хэрэгслийн хүрээнд судалгааг хийнэ” гэж аргачлалд заасны дагуу сонгон авч судаллаа.

5. “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд болон уг төслийн зүйл, заалт өөр хоорондоо нийцсэн эсэх, төрийн байгууллагын чиг үүрэг давхардсан, зөрчилдсөн эсэх асуудлыг шалгаж, улмаар уг хуулийн төслийн чанарыг сайжруулах үүднээс “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын 4.10-т заасан стандарт асуултуудад хариулах замаар үнэлэхээр энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгон авлаа.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэ хэсэгт хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий зохицуулалтыг сонгон авч үр нөлөөг нь судлав. Түүнчлэн уг хуулийн төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсэж болохуйц, тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой субъектэд шинээр чиг үүрэг хүлээлгэж байгаа, тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинээр нэгж (газар, хэлтэс гэх мэт) бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон.

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт тус бүрээр авч үзэв. Үүнд:

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал:

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн “1.1. Энэ хуулийн зорилго нь бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон зайн оновчтой төлөвлөлт бүхий дагуул хот байгуулах зорилтын хүрээнд Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлыг тогтоож, хотын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тогтвортой хөгжлийг дэмжих бодлогыг тодорхойлоход оршино.” гэсэн зохицуулалт болон холбогдох арга хэмжээ нь хуулийн төслөөр тавьсан зорилгодоо хүрч чадах эсэхийг тооцон судлахад ашиглана.

Мөн хуулийн төслийн үзэл баримтлалд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 55 дугаар тогтоолоор Нийслэл Улаанбаатар хотын хүн амын хэт төвлөрөл, хүрээлэн байгаа орчинд үзүүлж буй агаар, ус, хөрсний бохирдол, сөрөг нөлөөг бууруулах, олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн эдийн засгийн тодорхой салбаруудыг тогтвортой хөгжлийн зорилтод нийцүүлэн хөгжүүлэх, хүн амыг эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлалыг дэмжих зорилгоор Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт орон нутгийн зэрэглэлтэй “Шинэ Зуунмод” хотыг шинээр байгуулсан боловч өнөөг хүртэл тус хотын засаг захиргаа, удирдлагын тогтолцоо тодорхойгүй, хотын бүтээн байгуулалтын ажил зогсонги байдалтай байна гэжээ.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 9.5.2, 9.5.3-т Хөшигийн хөндийд байрлах олон улсын нисэх онгоцны буудлыг даган байгуулагдах “Шинэ Зуунмод” шинэ дагуул хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, инженерийн шугам сүлжээ, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд тус үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах хүрээнд Шинэ Зуунмод хотыг нийслэлийн дагуул хотын статустайгаар эрх зүйн байдлыг тодорхойлсон хуулийн төслийг боловсруулж батлах хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна гэж хууль санаачлагч үзсэн байна.

Иймд хуулийн төслийн 1.1-ээс гадна дээрх зорилгод хүрэхэд хотын чиг үүргийг тодорхойлсон хуулийн төслийн 10 дугаар зүйлд заасан зохицуулалтыг шууд нөлөөтэй гэж үзэж шинжлэн судалж, үнэлгээ хийхээр сонгон авлаа.

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал:

Хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгах шалгуур үзүүлэлтийн хүрээнд Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн дараах зүйл, заалтыг сонгон авлаа. Үүнд:

- 4 дүгээр зүйлийн "4.4.Шинэ Зуунмод хот нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 34.4-т заасан дүрэмтэй байх бөгөөд дараах асуудлыг тусгана¹";

- 5 дугаар зүйлийн "5.1.Шинэ Зуунмод хот нь Хөшигийн хөндий дэх олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт байрлана. 5.2.Шинэ Зуунмод хотын эдэлбэр газрын хэмжээг Монгол Улсын Их Хурал тогтооно.";

- 8 дугаар зүйлийн "8.1.Хотын нутаг дэвсгэр нь нь дараах бүсчлэлтэй байна:

- 8.1.1.эдийн засгийн чөлөөт бүс;
- 8.1.2.амралт, аялал жуулчлалын бүс;
- 8.1.3.олон нийт, худалдаа, үйлчилгээний бүс;
- 8.1.4.засаг захиргааны бүс;
- 8.1.5.оюутны хотхон, судалгаа шинжилгээний бүс;
- 8.1.6.зах, худалдаа, бөөний төвийн бүс;
- 8.1.7.тээвэр, логистик, үйлдвэрлэлийн бүс;
- 8.1.8.олон улсын нисэх онгоцны буудал, агаарын каргоны бүс;
- 8.1.9.аж ахуй, нөөц бүс.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан бүсчлэлийн хуваарийг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлно. 8.3.Шинэ Зуунмод хотын бүсчлэлийн дүрмийг хотын Зөвлөл батална.";

- 22 дугаар зүйлийн "22.1.Шинэ Зуунмод хот нь доор дурдсан үйл ажиллагаанд зарцуулах сантай байна:

22.1.1.инженерийн болон нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх;

22.1.2.нийтийн эдэлбэрийн газрын ашиглалт, хамгаалалт, цэцэрлэгт хүрээлэн, тохижилт, ногоон байгууламж бий болгох.".

2.3."Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектын хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулсан эсэхийг шалгах ба хууль ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөтэй тул тухайн хуулийн төслийн үг хэллэг нь хоёрдмол утга санаагүй, Монгол хэл бичгийн дүрэмд нийцсэн, утга найруулгын хувьд зөв хэрэглэсэн эсэхийг тодруулах шаардлагатайг харгалзан хуулийн төслийг бүхэлд нь авч үзэж, дүн шинжилгээ хийнэ.

¹ 4.4.1.хотын Зөвлөлийн үйл ажиллагаа, хуралдааны дэг;
4.4.2.хотын Захирагч, түүний ажлын албаны чиг үүрэг, үйл ажиллагаа;
4.4.3.хотын Ерөнхий архитектор, түүний ажлын албаны чиг үүрэг, үйл ажиллагаа;
4.4.4.хотын бэлгэдэл тэмдэг;
4.4.5.хотын оршин суугчийн оролцоо, иргэний танхим;
4.4.5.ашиг сонирхлын зөрчил, ёс зүйн хороо.".

2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал:

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, хуулийн этгээдэд ачаалал хүндрэл үүсгэх зохицуулалтыг шалгах хэрэгслийн хүрээнд “Хүлээн зөвшөөрөгдөх байдал”-ын судалгааг хийнэ, “тухайн хуулийн төсөлд төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгох, чиг үүрэг нэмэх зохицуулалтыг тусгасан бол шалгах хэрэгслийн хүрээнд судалгааг хийнэ” гэж заасны дагуу энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн дараах зүйл, заалтыг сонгон авч судаллаа. Үүнд:

- 12 дугаар зүйлийн “12.1.Шинэ Зуунмод хотын удирдлага дараах тогтолцоотой байна.

- 12.1.1.хотын Зөвлөл;

- 12.1.2.хотын Захирагч;

- 12.1.3.хотын Ерөнхий архитектор;

- 12.1.4.Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпораци.”;

- 18 дугаар зүйлийн “18.1.Төрөөс хотын бүтээн байгуулалтад татварын болон татварын бус дэмжлэг үзүүлнэ.”;

- 19 дүгээр зүйлийн “19.1.Нийслэл хот нь Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтад зориулж холбогдох хууль, журмын дагуу үнэт цаас гаргаж болно.”.

2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг тогтоосон байдал:

Хуулийн төслийн зүйл, заалт нь хоорондоо эсвэл бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжтой нийцсэн эсэх, төрийн байгууллагын чиг үүрэг давхардсан, зөрчилдсөн эсэх асуудлыг үнэлэх үүднээс энэ шалгуур үзүүлэлтийг сонгон авсан бөгөөд Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн дараах шалгуураар хуулийн төслийг бүхэлд нь судлан үзнэ. Үүнд:

- Хуулийн төслийн “хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиуд тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;

- Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;

- Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;

- Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд тодорхой тусгагдсан эсэх;

- Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;

- Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;

- Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;

- Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;

-Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;

- Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан эсэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх, авлига, хүнд суртал, шударга бус өрсөлдөөн бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;

- Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.

Хүснэгт 1

Хуулийн төслийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр сонгон авсан зохицуулалтууд

Үнэлгээний хүрээ	Сонгосон зохицуулалт	Шалгуур үзүүлэлт
Хуулийн зорилго	1.1	Зорилгод хүрэх байдал
Хотын чиг үүрэг	10.1-10.4	
Дагуул хот дүрэмтэй байх, түүгээр зохицуулах харилцаа;	4.4	Практикт нийцэж байгаа байдал
	5.1	
Хотын бүсчлэл, бүсчлэлийн дүрэм;	8.1, 8.1.1-8.1.9, 8.2-8.3	
	9.3	
Газар ашиглуулах; Дэд бүтцийг хөгжүүлэх сантай байх	22.1, 22.1.1.-22.1.2	
Хуулийн төслийг бүхэлд нь авч үзэх	-	Ойлгомжтой байдал
Хотын удирдлагын тогтолцоо	12.1; 12.1.1-12.1.4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал
Төрийн болон нийслэл, орон нутгийн оролцоо	18.1, 19.1	
Хуулийн төслийг бүхэлд нь авч үзэх	-	Харилцан уялдаа

ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ

Өмнөх үе шатанд хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тус тус тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар тодорхойлов.

Хүснэгт 2

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн: 1 дүгээр зүйлийн 1.1; 10 дугаар зүйлийн 10.1-10.4	Зорилгод дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн: 4 дүгээр зүйлийн 4.1, 4.4; 5 дугаар зүйлийн 5.1; 8 дугаар зүйлийн 8.1-8.3; 9 дүгээр зүйлийн 9.3; 22 дугаар зүйлийн 22.1	Практикт тухайн төрлийн харилцаа, чиг үүргийг хэрэгжүүлж буй байдалд дүн шинжилгээ хийх.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь авч үзнэ.	Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийн зохицуулалтуудыг шалгах замаар ойлгомжтой байдлыг шалгах.
4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийн: 12 дугаар зүйлийн 12.1; 18 дугаар зүйлийн 18.1; 19 дүгээр зүйлийн 19.1	Холбогдох байгууллагуудаас санал авах, мэргэжилтэнтэй ярилцах.
5	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь авч үзнэ.	Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар шалгах.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтүүдэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд хуулийн зорилгыг “1.1.Энэ хуулийн зорилго нь бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон зайн оновчтой төлөвлөлт бүхий дагуул хот байгуулах зорилтын хүрээнд Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлыг тогтоож, хотын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тогтвортой хөгжлийг дэмжих бодлогыг тодорхойлоход оршино.” гэж тодорхойлжээ.

Энэхүү зорилго нь бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон зайн оновчтой төлөвлөлт бүхий дагуул хот байгуулах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байх тул нийслэлчүүдийн амьдарч, ажиллах аятай таатай зохистой орчинг бүрдүүлж чадах эсэх буюу Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд тусгагдсан нийслэлийн дагуул хотын чиг үүргийг хэрэгжүүлж чадах эсэх, шинэ хотын бүтээн байгуулалт, төлөвлөлтийн бодлого нь хуулийн зорилгодоо нийцэж байгаа эсэх зэрэг асуудалд анхаарлаа хандуулж үр нөлөөг тодорхойлохыг зорилоо.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан судалж, уг судалгаагаар Шинэ Зуунмод нийслэлийн дагуул хотыг байгуулах, түүний эрх зүйн байдлыг тодорхойлсон хуулийн төслийг боловсруулж батлах хэрэгцээ шаардлага байна гэж дүгнэсэн нь энэхүү хуулийн төслийн зорилго нь нийслэлийн төвлөрлийг сааруулах, шинэ хотод нийслэлчүүдийн ажиллаж, амьдрах аятай таатай орчныг бий болгоход чиглэж, уг үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой нийгмийн харилцааг зохицуулах шаардлагыг тодорхойлсон байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго 9-д Улаанбаатар хотыг "Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлэх" зорилгыг дэвшүүлж, түүнийг хэрэгжүүлэх зорилт, үе шат, хүрэх үр дүнг нарийвчлан тодорхойлсон байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 6.1-д "Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ." гэж, 6.2-т "Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ." гэж заасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын 4.2-т "Шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулна." гэж тусгасан.

Хөшигийн хөндий дэх олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэр дээр "Шинэ Зуунмод" нийслэлийн дагуул хотыг байгуулах, түүний эрх зүйн байдлыг тодорхойлсон хуулийн төсийн 1.1-д заасан хуулийн зорилго нь дээр дурдсан бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан хэрэгжүүлэх арга хэмжээ байх бөгөөд нийгэм, эдийн засгийн хөгжил цаашлаад хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх суурь болохоор байна.

Мөн түүнчлэн уг хуулийн төслийн зорилгодоо хүрэх байдлыг Засгийн газрын 2022 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд:

- Шинэ Зуунмод хотыг эрчимтэй хөгжүүлэх замаар Улаанбаатар хотын хэт төвлөрлийг задлахад тэргүүлэх хувь ач холбогдолтой;

- Хөшигийн хөндий дэх орон зайн төлөвлөлтийн концепци хэрэгжсэнээр Монгол улсын эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, олон тулгуурт тогтвортой эдийн засагтай, дунджаас дээгүүр хөгжилтэй улс орон болон хөгжихөд томоохон хувь нэмэр оруулна;

- Шинэ Зуунмод дагуул хот нь УБ хотын үйлдвэрлэлийн төвлөрлийг задлах, тээвэр логиستيкийн үйлчилгээ, аялал жуулчлалын болон суурьшлын гэсэн үндсэн 4-н үүрэг функцтэйгээр байгуулагдахаар тусгагдсан байна.

Эдгээр хотын үүрэг функцийг дагасан хот байгуулалтын төлөвлөлт хийгдсэн бөгөөд хот байгуулалтын норм, дүрэм холбогдох хууль эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурласан ба "Шинэ Зуунмод" дагуул хотод шилжин суурьшилт болон хүн амын

есөлтөөр 2040 онд 11,000 орчим өрх, 34,000 орчим хүн ам бүхий байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн хэмнэлттэй сэргээгдэх эрчим хүч, саарал усны технологийг нэвтрүүлсэн орчин үеийн эко, ногоон хот байхаар төлөвлөсөн байна.

Хуулийн төслийн 1.1-д тодорхойлсон зорилго нь ерөнхий утгаараа Үндсэн хууль болон бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилттой нийцэж байх бөгөөд тус хуулийн төслийн 10 дугаар зүйлд тодорхойлсон Шинэ Зуунмод хотын чиг үүрэгтэй нягт холбоотой хэрэгжихээр байна. Учир нь шинээр байгуулагдах хотын чиг үүрэг нь Үндсэн хууль болон бусад хуулиар тодорхойлсон болон хуулийн төслийн зорилгодоо нийцсэн байх нь уг хуулийн зорилгод хүрэх байдлыг илэрхийлнэ, үр нөлөөг тодорхойлох гол зохицуулалт болж байна гэж үзлээ.

Иймд Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 10 дугаар зүйлд заасан Шинэ Зуунмод хотын чиг үүрэг болон Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан нийслэлийн дагуул хотын чиг үүргийг харьцуулан судалж үр нөлөөг нь тодорхойлохыг зорив.

Хүснэгт 3

Хотын чиг үүрэг

МУНУБХЭЗБТХуулийн 36 дугаар зүйл.Дагуул хотын чиг үүрэг	ШЗХЭЗБТХ-ийн 10 дугаар зүйл.Шинэ Зуунмод хотын чиг үүрэг
36.1.1.нийслэл хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилт; 36.1.2.хот тохижилт, олон нийтийн амралт, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалт; 36.1.3.унд, ахуйн хэрэгцээний ус хангамж; 36.1.4.авто замын арчлалт, хамгаалалт; 36.1.5.авто зогсоолын төлөвлөлт, арчлалт, хамгаалалт; 36.1.6.орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ; 36.1.7.хөшөө дурсгалын арчлалт, хамгаалалт; 36.1.8.гэрэлтүүлгийн арчлалт, хамгаалалт; 36.1.9.хуульд заасан бусад. 36.2.Дагуул хот шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 8.2, 8.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.	10.1.Шинэ Зуунмод хот нь тус хотын эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх, өөрийн эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг хууль тогтоомж, хотын дүрмийн хүрээнд хотын оршин суугч, хөрөнгө оруулагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн чиг үүрэгтэй байна. 10.2.Шинэ Зуунмод хот нь нийслэлийн дагуул хот болохын хувьд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 36.1-д заасан болон Засгийн газар, нийслэл, бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаас холбогдох хуулийн дагуу шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.
	10.3.Засгийн газар, нийслэл, бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж энэ хуулийн 10.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төрийн болон орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах эрхийг хууль

	тогтоомжид нийцүүлэн Шинэ Зуунмод хотод шилжүүлж болно.
	10.4.Шинэ Зуунмод хот хуульд заасан чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах эрхтэй.

Хүснэгт 3-аас харвал хуулийн төслөөр тодорхойлсон Шинэ Зуунмод хот МУНУБХЭЗБТХ-иар тодорхойлсон нийслэлийн дагуул хотын чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд үүн дээр нэмж дараах шинэ зорилгыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1.Шинэ Зуунмод хот нь Засгийн газар, нийслэл, бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаас холбогдох хуулийн дагуу шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.Хотын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төрийн болон орон нутгийн өмчийг Шинэ Зуунмод хотод шилжүүлэх;

3.Шинэ Зуунмод хот хуульд заасан чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах.

Дээрх 3 төрлийн зохицуулалтыг тус бүрд нь авч үзвэл:

- Хуулийн төслийн 10.2-т Шинэ Зуунмод хот Засгийн газар, нийслэл, бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тухайлбал, Төв аймаг, Сэргэлэн сум, Алтанбулаг сумаас шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан нь төрийн байгууллагын чиг үүрэг давхардахгүй байх эерэг үр нөлөөтэй байх боловч ямар чиг үүргийг шилжүүлэх талаар хуулийн төсөл болон түүнийг дагалдан гарах бусад хуулиудад тухайлан зааж өгөөгүй байгаа нь энэхүү зохицуулалт хэрэгжихгүй байх, үр нөлөөгүй байх үр дагаврыг бий болгож байна. Иймд Захиргааны ерөнхий хуулийн 8.1-д "хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно" гэж заасантай нийцүүлэн хуулийн төсөл болон холбогдох бусад хуульд нийслэлийн дагуул хотын удирдлагад шилжүүлэх бүрэн эрхийг тухайлан заасан зохицуулалтыг тусгаж өгөх шаардлагатай байна.

- Хуулийн төслийн 10.3-т хотын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төрийн болон орон нутгийн өмчийг Засгийн газар, нийслэл, бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж буюу Төв аймаг, Сэргэлэн, Алтанбулаг сумдаас Шинэ Зуунмод хотод шилжүүлж болохоор хуулийн төсөлд тусгасан боловч хэрхэн шилжүүлэх асуудлыг холбогдох хуулиар зохицуулахаар заасан байна. Иймд хуулийн төслийн 10.3 дахь зохицуулалт нь шууд хэрэгжих боломжгүй буюу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд хотод өмчийн эрх шилжүүлэх заалтыг тусгах шаардлагатай байна.

- Хуулийн төслийн 10.4-т хотын удирдлага эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даасан шийдвэр гаргах эрхтэй гэж заасан боловч манай улсын Төсвийн тухай хуульд хотын төсөв гэсэн ангилал байхгүй, манай улс нэгдсэн төсөвтэй байх зарчмын хүрээнд хотын төсвийг нийслэлийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байхаар хуулийн төслийн 20.1-д зохицуулалт тусгасан байна. Иймд хотын бие даасан байдлыг хангах, улмаар хуулийн төслийн 1.1-д заасан зорилгыг бүрэн хангахын тулд хуулийн төслийн 20.1-д заасны дагуу нийслэлийн төсөвт жил бүр хотын төсвийг шаардлагатай хэмжээгээр тусгаж, баталж өгч байх шаардлагатай байна.

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд Шинэ Зуунмод хотын эрх зүйн үндэс буюу хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн “4.1.Шинэ Зуунмод хот нь хуулиар тусгайлан тогтоосон чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалт, эдийн засагтай, нийслэл хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэхэд стратегийн ач холбогдол бүхий Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын дагуул хот байна.”, “4.4.Шинэ Зуунмод хот нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 34.4-т заасан дүрэмтэй байх”, Шинэ Зуунмод хотын байрлал, эдэлбэр газар буюу 5 дугаар зүйлийн “5.1.Шинэ Зуунмод хот нь Хөшигийн хөндий дэх олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт байрлана.”, “5.2.Шинэ Зуунмод хотын эдэлбэр газрын хэмжээг Монгол Улсын Их Хурал тогтооно.” гэсэн зохицуулалтуудыг судлан үзэж, практикт хэрэгжих боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

А.Шинэ Зуунмод хотын эрх зүйн үндэс, зохион байгуулалтын тухайд:

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1-д Шинэ Зуунмод хот нь хуулиар тусгайлан тогтоосон чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалт, эдийн засагтай, нийслэл хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэхэд стратегийн ач холбогдол бүхий Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын дагуул хот байна гэж, 4.4-т Шинэ Зуунмод хот нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 34.4-т заасан дүрэмтэй байхаар тусгажээ.

Шинэ Зуунмод хот нь нийслэлийн дагуул хот байх, хотын дүрэмтэй байх боломжтой эсэхийг судалж үзвэл 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 4.3-т Нийслэл хот нь дагуул хоттой байна”, 34.4-т “Дагуул хот дүрэмтэй байна. Хуулиар зохицуулснаас бусад дагуул хоттой холбоотой асуудлыг Засгийн газраас баталсан дүрмээр зохицуулна” гэж хуульчилсантай нийцэж байна. Мөн энэ хууль батлагдахаас өмнө мөрдөгдөж байсан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.4-т Нийслэл нь эдийн засгийн дэд бүтцийг тэнцвэртэй хөгжүүлэх, хүн амын хэт төвлөрөл болон хотын хангамж, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах, оршин суугчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгаль орчны зохистой харьцааг хадгалах үүднээс дагуул хот (алслагдсан дүүрэг, хаяа хот, тосгон)-той байж болно гэж заажээ.

Нийслэлд дагуул хот байгуулагдаж байсан эсэх, дагуул хот нь дүрэмтэй байсан эсэх талаар судалж үзвэл, Нийслэлийн Багануур, Налайх дүүрэгт иргэдийн оролцоотойгоор дагуул хот байгуулах шийдвэр гаргах, хотын дүрэм батлуулах ажлыг 2015 оноос эхлүүлсэн байх бөгөөд Налайх дүүрэгт 2015 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр, Багануур дүүрэгт 2015 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс 22-ны өдрүүдэд тухайн дүүрэгт дагуул хот байгуулахыг дэмжих эсэх талаарх санал асуулгыг сонгуулийн эрх бүхий иргэдээс авч байжээ. Тодруулбал,

- Налайх дүүрэгт бүртгэлтэй сонгууль өгөх эрх бүхий 19535 иргэнээс санал асуулгад оролцсон 12180 (нийт иргэдийн 62.35%) иргэнээс Налайх дүүрэгт дагуул хот байгуулахыг дэмжсэн 11708, дэмжээгүй 374 буюу сонгууль өгсөн иргэдийн 96.8% нь дүүрэгтээ хот байгуулах ажлыг дэмжсэн;

- Багануур дүүрэгт бүртгэлтэй сонгууль өгөх эрх бүхий 16260 иргэнээс санал асуулгад оролцсон 12659 (нийт иргэдийн 77.9%) иргэнээс Багануур дүүрэгт дагуул хот байгуулахыг дэмжсэн 12094, дэмжээгүй 532 буюу сонгууль өгсөн иргэдийн 95.6% нь дүүрэгтээ хот байгуулах ажлыг дэмжсэн байна.

Улмаар нийслэлийн эдийн засгийн дэд бүтцийг тэнцвэртэй хөгжүүлэх, хүн амын хэт төвлөрлийг сааруулах, хотын хангамж, үйлчилгээг сайжруулах, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжин зохицуулах, оршин суугчдын нийгмийн асуудлыг шуурхай шийдвэрлэх зорилгоор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Нийслэлийн дагуул хот байгуулах тухай” 25/07 дугаар тогтоолоор нийслэлийн дагуул Багануур хотыг Багануур дүүрэгт, нийслэлийн дагуул-Налайх хотыг Налайх дүүрэгт тус тус байгуулж байжээ.

Гэвч тухайн байгуулсан дагуул хотуудын чиг үүрэг, төсөв санхүү, өмч хөрөнгө, бүтэц, зохион байгуулалт гэх мэт үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн орчин тодорхойгүй байснаас хотын үйл ажиллагаа эрчимжиж, хөгжиж чадаагүй байна.

Мөн түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Улаанбаатар ба дагуул хотуудыг хөгжүүлэх асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан. Тухайлбал:

Зорилт 9.4.Хууль, эрх зүйн тогтвортой орчинтой, хотын дүрэм, стандартыг хангуулсан сайн засаглалтай хот болно.

Зорилт 9.5.Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд Азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ.

I үе шат (2021-2030): Хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлж, үйлдвэрлэлийн бүс нутгийг тэлэх үе.

1.Олон төвт хотын тогтолцоог хэрэгжүүлж, “Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ дагуул хотын бүтээн байгуулалтыг эхлүүлж, инженерийн шугам сүлжээ, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.Аж үйлдвэрийн бүсүүдийг салбар чиглэл бүрд төлөвлөн, кластер байдлаар дагуул хотуудыг хөгжүүлнэ.

II үе шат (2031-2040): Нутагшилт суурьшлын зөв тогтолцоотой, эдийн засгийн төрөлжилтийг эрчимжүүлэх үе.

3.Шинэ техник технологи, инновац шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг дагуул хаяа хот, тосгонд нэмэгдүүлсэн байна.

4.Зарим их, дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж, дагуул хотуудад хотхон байгуулан шилжүүлнэ.

5.Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг нэгдсэн бодлого төлөвлөлттэйгээр дагуул хотуудад шилжүүлнэ.

III үе шат (2041-2050): Олон улсад өрсөлдөхүйц эрчимтэй хөгжлийн үе.

Энэ үе шатанд дагуул, хаяа хот, тосгон тус бүрд нь худалдаа, үйлчилгээ, соёл боловсрол, хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлалын чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулсан байна гэж тодорхойлсон байна.

Иймд дээрх харилцаа нь практикт хэдийн хэрэгжсэн бөгөөд холбогдох бодлогын баримт бичгүүдэд тусгагдаж, хууль тогтоомжийн уялдаа холбоо хангагдсан байх тул Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан Шинэ Зуунмод хот нь хуулиар тусгайлан тогтоосон чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалт, эдийн засагтай, нийслэл хотын тусгай чиг

үүргийг гүйцэтгэхэд стратегийн ач холбогдол бүхий Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын дагуул хот байна, 4.4-т заасан Шинэ Зуунмод хот нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 34.4-т заасан дүрэмтэй байх” гэсэн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой байна гэж дүгнэлээ.

Б.Шинэ Зуунмод хотын байрлал, эдэлбэр газрын тухайд:

Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-д Шинэ Зуунмод хот нь Хөшигийн хөндий дэх олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт байрлана, 5.2-т Шинэ Зуунмод хотын эдэлбэр газрын хэмжээг Монгол Улсын Их Хурал тогтооно гэж заасан.

Нийслэлийн дагуул хотыг нийслэлийн болон бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид, эсхүл засаг захиргааны нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжид дамнан байгуулж болно гэж Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 34.2-т заасан байна. Мөн Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 5.2-т Хот, тосгоны эдэлбэр газар нь хэд хэдэн сумын нутаг дэвсгэрийг дамнан байрлаж болох зохицуулалт тусгагдсан байна.

Иймд Шинэ Зуунмод хот нь бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид буюу Хөшигийн хөндий дэх Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт дамнан байрлах тухай хуулийн төслийн 5.1 дэх зохицуулалт практикт хэрэгжих боломжтой байна.

Мөн түүнчлэн, хуулийн төслийн 5.2-т “Шинэ Зуунмод хотын эдэлбэр газрын хэмжээг Монгол Улсын Их Хурал тогтооно” гэж заасан нь Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д “хот байгуулалтын талаарх төрийн бодлогыг тодорхойлох”, 5.1.2-т “хотыг шинээр байгуулах болон татан буулгах, нүүлгэн шилжүүлэх тухай шийдвэр гаргах” бүрэн эрхийг Улсын Их хурал хэрэгжүүлэхээр зохицуулсантай болон Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 35.1-д Дагуул хотыг стратегийн ач холбогдол бүхий дараах нөхцөлийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал байгуулна, 35.2-т Дагуул хотыг байгуулах шийдвэрт хотын нэр, эдэлбэр газрын хэмжээ, байршлыг тусгана гэж заасантай тус тус нийцэж байгаа тул уг зохицуулалт практикт хэрэгжих боломжтой байна гэж дүгнэлээ.

В.Шинэ Зуунмод бүсчлэлийн тухайд:

Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1-д Шинэ Зуунмод хотын нутаг дэвсгэр доор дурдсан 8 бүстэй байхаар хуульчилсан байна. Үүнд:

- 8.1.1.эдийн засгийн чөлөөт бүс;
- 8.1.2.амралт, аялал жуулчлалын бүс;
- 8.1.3.олон нийт, худалдаа, үйлчилгээний бүс;
- 8.1.4.засаг захиргааны бүс;
- 8.1.5.оюутны хотхон, судалгаа шинжилгээний бүс;
- 8.1.6.зах, худалдаа, бөөний төвийн бүс;
- 8.1.7.тээвэр, логистик, үйлдвэрлэлийн бүс;
- 8.1.8.олон улсын нисэх онгоцны буудал, агаарын каргоны бүс;
- 8.1.9.аж ахуй, нөөц бүс.

Шинэ Зуунмод ямар бүстэй байх талаар хуульчилсан нь тогтвортой байх, ямар нэг төлөвлөлтөөр тэр бүр өөрчлөхгүй байх давуу талтай байна.

Энэхүү бүсэд баримтлах дүрмийг Хотын Зөвлөл батлахаар тусгасан нь тухайн хотын нийгэм, эдийн засгийн асуудлаа бие даан шийдвэрлэх зарчимд

нийцэж байгаа боловч хуулийн төслийн 8.1-д бүсчлэлийн хуваарийг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлохоор хуульчилж бүсчлэлийн дүрмийн зохицуулалтын хүрээ хязгаарыг тодорхойлсон нь практикт хэрэгжих боломжтой байна.

Харин хуулийн төслийн 8.1-д Шинэ Зуунмод хотын нутаг дэвсгэрийн бүсчлэл гэж томьёолсон нь хот нутаг дэвсгэртэй байх агуулгыг илэрхийлж байгаа тул Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйлийн 2-т "Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана." гэж заасантай нийцэхгүй байна.

Ийм учраас Газрын тухай хуулийн 12.1², Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 35.2³ болон Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 5.2-т заасантай нийцүүлэн хуулийн төслийн 8.1 дэх хэсгийг "Хотын эдэлбэр газар нь дараах бүсчлэлтэй байна." гэж томьёолох шаардлагатай байна.

Г.Шинэ Зуунмод хот дэд бүтцийн сантай байх зохицуулалтын тухайд:

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд Шинэ Зуунмод хот дэд бүтцийн сантай байх зохицуулалтыг тусгасан бөгөөд уг сангийн хөрөнгийг зөвхөн доор дурдсан үйл ажиллагаанд зарцуулахаар хуульчилсан байна. Үүнд:

- 22.1.1.инженерийн болон нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх;
- 22.1.2.нийтийн эдэлбэрийн газрын ашиглалт, хамгаалалт, цэцэрлэгт хүрээлэн, тохижилт, ногоон байгууламж бий болгох.

Сантай холбоотой эрх зүйн зохицуулалтыг авч үзвэл:

- Төсвийн тухай хуулийн 60.1-д "Тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий Орон нутгийн хөгжлийн сантай байна.";

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 17 дугаар зүйлийн 17.1-д "Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь энэ хуульд заасан өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий Төсвийн тухай хуульд зааснаас өөр бусад сантай байж болно. Уг санг бүрдүүлэх эх үүсвэр нь төсвийн бус хөрөнгө байна";

- Иргэний хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-т "Нэг буюу хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай, нэгдмэл зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан гишүүнчлэлгүй хуулийн этгээдийг сан гэнэ";

- Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 17.1-д "Нийслэл нь нийслэлийг хөгжүүлэх сантай байж болно." гэж тус тус заасан байна.

² 12 дугаар зүйл.Хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газар

12.1.Хот, тосгон, бусад суурины газар болон нийслэл хотын эдэлбэр газарт хот, тосгон, бусад суурины барилга байгууламж, үйлдвэр, уурхайн дэвсгэр газар, инженерийн дэд бүтэц, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийн газар, нийтийн эдэлбэрийн газар болон цаашид тэлж хөгжих нөөц газар хамаарах бөгөөд эдэлбэр газрын хэмжээ, заагийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталж, тогтооно.

³ Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйл.Дагуул хотыг байгуулах

35.2.Дагуул хотыг байгуулах шийдвэрт хотын нэр, эдэлбэр газрын хэмжээ, байршлыг тусгана.

Нийслэлд сан байгуулж байсан талаар судалж үзвэл, 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчингүй болсон Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Нийслэлийг хөгжүүлэх зориулалтаар дотоод гадаадын аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс өргөсөн хандив, буцалтгүй тусламж, бусад орлогоос бүрдсэн сан байж болох бөгөөд сангийн хөрөнгийг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлаас баталсан журмын дагуу Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч захиран зарцуулж, гүйцэтгэлийн тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр тайлан тавина" гэснийг үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1997 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Улаанбаатар санг үүсгэн байгуулж байсан байна.

"Улаанбаатар сан"-ийн зорилгыг "Нийслэл хотын эдийн засаг, хот байгуулалт, түүний дэд бүтцийг хөгжүүлэх, хотын аж ахуйг өргөтгөж, хүн амын хангамж үйлчилгээ, нийгмийн асуудлыг сайжруулах, байгаль орчныг хамгаалах" гэж тодорхойлсон байна.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2000 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 50 дугаар тогтоолоор "Улаанбаатар сан" Улсын Үйлдвэрийн газар болж гэрчилгээндээ нэмэлт өөрчлөлт хийсэн.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2002 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар "Улаанбаатар сан" УҮГ-ыг "нийслэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх, хот тохижилтийг сайжруулах, хотын төсөв санхүүгийн чадамжийг нэмэгдүүлэх, иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх" зорилгоор ОНӨААТҮГ болгон өөрчлөн байгуулж байжээ.

Тус сангийн хөрөнгөөр нийслэлийн хот, нийтийн аж ахуйн чиглэлээр багагүй хэмжээний ажил гүйцэтгэж байжээ. Тухайлбал 1998-2005 онуудад Нийслэлийн хөрөнгө оруулалтын ажилд 4643,6 сая төгрөг зарцуулж Төв музейн урд талбайн тохижилтын ажил, Энх тайвны өргөн чөлөөний гэрэлтүүлгийн ажил, дүүргийн тохижилтын ажил /Цас цэвэрлэх төхөөрөмж/, гэр хорооллын гэрэлтүүлэг, ойжуулах ажил, зам засварын асфальтны үйлдвэр, Хотын цаг, Нийслэлийн цагдаагийн газрын парк шинэчлэлт, Занабазарын гудамжны цэцэрлэгжүүлэлт, Сүхбаатарын хөшөөний сэргээн засварлалтын ажил гэх мэтээр гүйцэтгэж байжээ.

Иймд "практикт хэрэгжих боломж" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 22 дугаар зүйлд заасан "Шинэ Зуунмод хотын дэд бүтцийн сан"-тай байх зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэлээ. Харин хуулийн төслийн 22.3-т зааснаар Хотын зөвлөлөөс батлах энэхүү санг байгуулах, түүний хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журмын зохицуулалтаар илүү нарийвчлан зохицуулах шаардлагатай болохыг анхаарах нь зүйтэй байна.

Мөн энэхүү сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хуулийн төслийн 22.2-т нарийвчлан зааж өгсөн байх бөгөөд эдгээр эх үүсвэр нь Хотын удирдлагаас үл хамаарах эх үүсвэрүүд байгаа тул холбогдох хууль болон дүрэмд нь тухайлан зааж өгөх шаардлагатай байна. Жишээлбэл, Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпорацийн дүрэм, Нийслэлийн төсвийн хуваарилалт гэх мэт.

Д.Шинэ Зуунмод хотын эдэлбэр газраас бүсдэд ашиглуулах асуудлын тухайд:

Хуулийн төслийн 9.3-т "Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу нийгмийн болон инженерийн суурь дэд бүтцээс бусад зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглах эрх олгох асуудлыг зөвхөн төсөл сонгон шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ.", 9.5-д "Энэ хуулийн 9.3-

т заасан төсөл болон сонгон шалгаруулалтад оролцох этгээдэд тавигдах шаардлага, төсөл шалгаруулах журмыг Засгийн газар батална.” гэж заажээ.

Газрын тухай хуульд доор дурдсанаас бусад тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэх ба төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтоохоор заасан⁴ байна. Үүнд:

- 29.1.Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар 0,07 га-гаас илүүгүй хэмжээтэй газрыг үнэ төлбөргүй эзэмшүүлэх;

- 29.2.гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар иргэнд 0,1 га-гаас илүүгүй газар үнэ төлбөргүй эзэмшүүлэх;

- 29.3.Багийн иргэдийн Нийтийн Хурлын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн, тариалангийн газрыг газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан Засгийн газраас тогтоосон журмын дагуу давуу эрхээр эзэмшүүлэх;

- төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газрыг эзэмшүүлэх.

Иймд хуулийн төслийн 9.2-т “...хотын эдэлбэр газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах газрын байршил, зориулалт, хэмжээг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгана.”, 9.4-т “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглах эрх олгох төсөл нь хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хотыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний үе шатны төслийн жагсаалтад хамаарч байна.” гэж тус тус заасны дагуу төсөл сонгон шалгаруулах зарчмаар бусдад газар ашиглуулах асуудлыг шийдвэрлэх зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх боломжтой байна.

Мөн хуулийн төслийн 9.7-д дээр дурдсаны дагуу зохион байгуулсан төсөл сонгон шалгаруулалтад орж шалгарсан этгээдтэй байгуулах газар ашиглуулах гэрээнд Газрын тухай хуульд зааснаас гадна заавал тусгах нэмэлт нөхцөлийг 9.7-д дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- 9.7.1.газрыг гэрээнд заасан төсөл хэрэгжүүлэхээс өөр зориулалтаар ашигласан, эсхүл ашиглахаар бүтээн байгуулалтын ажил хийгдэж байгаа бол гэрээг нэг талын санаачилгаар цуцлах;

- 9.7.2.төслийг гэрээ байгуулснаас хойш 6 сарын хугацаанд хэрэгжүүлж эхлээгүй бол газар ашиглах эрх дуусгавар болох.

Энэ нь шинэ хотын бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөсөн хугацаандаа хийж гүйцэтгэх, хотын бүтээн байгуулалтын ажил төлөвлөлтийн дагуу хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж, хариуцлагажуулах ач холбогдол бүхий зохицуулалт болсон байна.

Дүгнэлт: Хуулийн төслийн зохицуулалтуудыг практикт дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд тодорхой, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байна гэж дүгнэлээ.

3.3. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь Нийтлэг үндэслэл, Хот байгуулалт, Хотын зохион байгуулалт, удирдлагын тогтолцоо, Шинэ Зуунмод хотын эдийн засаг, Хотын бизнесийн орчин, хөрөнгө оруулалт, Бусад асуудал гэсэн 6 бүлэг, 29 зүйлээс бүрдэх бөгөөд хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэж, дүн шинжилгээ хийлээ.

А.Хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэх талаар:

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хүснэгт 4

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйлийн 2-т “Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана.” гэж заасантай нийцүүлэн хуулийн төслийн 8.1 дэх хэсгийн “Хотын нутаг дэвсгэр” гэснийг “Хотын эдэлбэр газар” гэж томъёолох санал дэвшүүлсэн. Энэ саналыг тусгасан тохиолдолд шаардлага хангасан байна.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад	Шаардлага хангасан.

удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлага хангасан.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Шаардлага хангасан.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлага хангасан.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

Хуулийн төслийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын эрх зүйн ажилтнууд, БХБЯ, МАЭ болон хот байгуулалт, төлөвлөлт, барилгын зураг төсөл, архитекторын мэргэжлийн хүмүүст танилцуулж, санал авахад хуулийн төсөл ойлгомжгүй байна гэсэн санал гараагүй байна.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн зохицуулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцэж байна гэж дүгнэлээ.

Б.Хууль тогтоомжийн тухай хууль, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэх:

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, түүнийг дагалдан гарах хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг бүхэлд нь авч үзэхэд Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.4.“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, хуулийн этгээдэд ачаалал хүндрэл үүсгэх

зохицуулалтыг шалгах хэрэгслийн хүрээнд “Хүлээн зөвшөөрөгдөх байдал”-ын судалгааг хийнэ, “тухайн хуулийн төсөлд төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгох, чиг үүрэг нэмэх зохицуулалтыг тусгасан бол шалгах хэрэгслийн хүрээнд судалгааг хийнэ” гэж заасны дагуу хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг (Шинэ Зуунмод хотын удирдлагын тогтолцоог тодорхойлсон), 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг (Төрөөс хотын бүтээн байгуулалтад үзүүлэх дэмжлэг), 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг (нийслэл болон Төв аймгаас хотын бүтээн байгуулалтад үзүүлэх дэмжлэг)-ийг сонгон авлаа.

Аргачлалд “тухайн хуулийн төсөлд төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгох, чиг үүрэг нэмэх зохицуулалтыг тусгасан бол шалгах хэрэгслийн хүрээнд судалгааг хийнэ” гэж заасны дагуу хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт судалгааг хийлээ.

- 12 дугаар зүйлийн “12.1.Шинэ Зуунмод хотын удирдлага дараах тогтолцоотой байна.

12.1.1.хотын Зөвлөл;

12.1.2.хотын Захирагч;

12.1.3.хотын Ерөнхий архитектор;

12.1.4.Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпораци.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудад хотын удирдлагын талаар дараах зохицуулалт тусгагдсан байна. Үүнд:

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн “37.1.Дагуул хотын удирдлага нь Захирагч, түүнд зөвлөх үүрэг бүхий дагуул хотын зөвлөлөөс бүрдэнэ.”; “24.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нь нийслэл хотын аж ахуйн чиг үүргийг хэрэгжүүлэх, нэгдмэл байдлыг хангах, холбогдох байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий Улаанбаатар хотын Ерөнхий менежерийг томилж, чөлөөлнө”;

- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн “10.1.Хот, тосгоны удирдлага нь захирагч, зөвлөлөөс бүрдэнэ.”;

- Хот байгуулалтын тухай хуулийн “10.1.Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитектор нь хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан дүрмийн дагуу дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ”.

Эдгээр зохицуулалтаас дүгнэж үзвэл хуулийн төслийн 12.1-д тодорхойлсон Шинэ Зуунмод хотын удирдлагын тогтолцоонд хүчин төгөлдөр байгаа хуульд зааснаас гадна “Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпораци” гэсэн шинэ бүтцийг бий болгож чиг үүргийг нь тодорхойлсон байна. Гэхдээ энэ нь бусад улсуудын жишгээр авч хэрэгжүүлж байгаа тухайн хотод шаардлагатай бүтэц бий болгож, төрийн байгууллагын оролцоо, ачааллыг багасгаж байгаа зохицуулалт байх тул олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөн хэрэгжих боломжтой гэж дүгнэлээ.

- Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн “18.1.Төрөөс хотын бүтээн байгуулалтад татварын болон татварын бус дэмжлэг үзүүлнэ.” гэж заасан зохицуулалт нь төрийн байгууллагад нэмэлт чиг үүрэг хүлээлгэж байгаа агуулгатай байх боловч энэхүү чиг үүрэг нь төрийн байгууллагуудын хуулиар хүлээсэн үүрэг байх бөгөөд энэхүү чиг үүрэг нь шинэ хотын бүтээн байгуулалтыг дэмжих, улмаар иргэн, хуулийн этгээдэд эерэг үр нөлөөтэй зохицуулалт байх тул олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөн хэрэгжих боломжтой зохицуулалт байна. Хуулийн төслийн

18.1 дэх хэсэг нь ерөнхий зохицуулалт байх боловч хуулийн төслийг дагалдуулан холбогдох татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан байх тул практикт хэрэгжих боломжтой байна.

- Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн "19.1.Нийслэл хот нь Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтад зориулж холбогдох хууль, журмын дагуу үнэт цаас гаргаж болно." гэж заасан нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15.1.6⁵-д заасантай нийцэж байгаа буюу нийслэл нь үнэт цаас гаргах эрхтэй байна.

Мөн Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.24-т "аймаг, нийслэлийн үнэт цаас" гэж аймаг, нийслэлээс тодорхой төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зорилгоор хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, журмын дагуу олон нийтэд санал болгон, эсхүл нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд арилжаалах өрийн бичгийг" гэж, Үнэт цаасны тухай хуулийн 5.1.10-т Аймаг, нийслэлийн үнэт цаас санхүүгийн хэрэгсэлд хамаарахаар тус тус заасан байгаа нь нийслэл хотоос дагуул хотын бүтээн байгуулалтад зориулж гаргаж байгаа үнэт цаасыг арилжаалах харилцаа, процессыг эдгээр хуулиар нарийвчлан зохицуулах боломжтой байгаа нь хүлээн зөвшөөрөгдөх байдлыг илэрхийлж байна гэж дүгнэлээ.

3.5."Хуулийн төслийн харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорилоо.

Хүснэгт 5

Д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Нийцэж байна.
2	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төсөлд нэр томьёо тухайлан тайлбарласан зохицуулалт байхгүй бөгөөд хэрэглэгдэж байгаа нэр томьёо нь ойлгомжтой бөгөөд бусад хуулийн нэр томьёотой нийцэж байх тул энэхүү шаардлагыг хангаж байна.
3	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Хуулийн төслийн 8.1 дэх хэсгийг Газрын тухай хуулийн 12.1 дэх хэсэгтэй нийцүүлэн "Хотын нутаг дэвсгэр" гэснийг "Хотын эдэлбэр газар" гэж томьёолох санал дэвшүүлсэн.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Давхардсан зүйлгүй.
5	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй.

⁵ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15.1.6 хуульд заасан үндэслэл, журмын дагуу төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн саналыг хэлэлцэх, үнэт цаас гаргах асуудлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэх.

6	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй.
7	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Хуулийн төсөлд холбогдох хуулийн хүрээнд төр, хувийн түншлэлээр хэрэгжүүлж болох талаар тусгагдсан: - Хуулийн төслийн 18.4.Шинэ Зуунмод хот хувийн хэвшилтэй хамтрах, төр, хувийн түншлэлийг хэрэгжүүлэх тусгай нөхцөлийг хуулиар тогтоож болно. - 23.7.Хотыг хөгжүүлэх төсөл, арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж болох бөгөөд энэ харилцааг холбогдох хуулиар зохицуулна.
8	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Хуулийн төслийн 25.1-д Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтад чиглэсэн тогтвортой үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс барилга угсралтын ажил дуусах хүртэлх хугацаанд тодорхой төрлийн татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхээр тусгасан бөгөөд хуулийн төслийн 25.3-т татварын дэмжлэгийн хувь хэмжээ, хугацааг холбогдох татварын хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулахаар тусгасан байх бөгөөд холбогдох татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар Шийн Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг дагалдуулан хуулийн төсөл боловсруулсан байна.
9	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
10	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй.
11	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
12	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
13	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
14	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хуулийн 28 дугаар зүйлд хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тусгасан: - 28.1.Энэ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

	- 28.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. - 28.3.Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол төсөл хэрэгжүүлэгч нь хотын удирдлагатай байгуулсан гэрээний харилцаанаас үүсэх маргааныг талууд харилцан тохиролцсоны дагуу шүүх, эсхүл арбитраар шийдвэрлүүлнэ. - 28.4.Хотын эдэлбэр газар, бүтээн байгуулалтад хохирол учруулсан гэм буруутай этгээд нь Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээсэн эсэхээс үл хамааран уг хохирлыг өөрийн хүч хөрөнгөөр арилгах арга хэмжээ авах бөгөөд хэрэв мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн бол үүнтэй холбогдон гарсан зардлыг бүрэн хариуцна. Гэм буруутай этгээд нь төсөл хэрэгжүүлэгч бол төсөл хэрэгжүүлэх эрхийг цуцалж, учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.
--	---

Дээрх хүснэгтээс харахад Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн зүйл, заалт хоорондоо болон бусад хуулийн зүйл, заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ

4.1.Баримтжуулалт

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд ашигласан дараах баримт бичиг, мэдээлэл, тоо баримтыг цуглуулан үр нөлөөг тооцох ажиллагааны тайланд баримтжуулж хавсаргалаа.

- Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл;
- Хуулийн төслийн үзэл баримтлал;
- Хуулийн төслийн танилцуулга;
- Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан;
- Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний танилцуулга;
- хуулийн төслийг хэлэлцүүлж, санал авсан баримтууд.

4.2.Үнэлэлт, дүгнэлт

Хуулийн төслийг сонгон авсан шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах дүгнэлтийг хийлээ.

4.2.1.Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн зохицуулалт нь уг төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийж, дараах дүгнэлтэд хүрсэн.

Хуулийн төслийн зохицуулалтуудын хувьд уг төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж зорилгод хүрэх байдлаар томъёологдсон байна.

Дүгнэлт: Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр үнэлж Хуулийн төслийн 1.1-д заасан зорилго нь Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн зорилго, зорилтод бүрэн нийцэж байна гэж үзлээ. Харин хуулийн төслийн 1.1-д заасан зорилгыг бүрэн хэрэгжүүлэхэд шууд хамаарал бүхий хотын чиг үүрэгтэй холбоотой 10 дугаар зүйлд заасан зохицуулалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нарийвчилсан зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгаж, эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар анхаарах шаардлагатай гэж дүгнэлээ.

4.2.2.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд Шинэ Зуунмод хотын эрх зүйн үндэс буюу хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн “4.1.Шинэ Зуунмод хот нь хуулиар тусгайлан тогтоосон чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалт, эдийн засагтай, нийслэл хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэхэд стратегийн ач холбогдол бүхий Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын дагуул хот байна.”, “4.4.Шинэ Зуунмод хот нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 34.4-т заасан дүрэмтэй байх”, Шинэ Зуунмод хотын байрлал, эдэлбэр газар буюу 5 дугаар зүйлийн “5.1.Шинэ Зуунмод хот нь Хөшигийн хөндий дэх олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт

байрлана.", "5.2.Шинэ Зуунмод хотын эдэлбэр газрын хэмжээг Монгол Улсын Их Хурал тогтооно." гэсэн зохицуулалтуудыг судлан үзэж, практикт хэрэгжих боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийж дараах байдлаар дүгнэлээ:

- Багануур, Налайх хот байгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлж байсан нь нийслэлд дагуул хот байгуулах харилцаа практикт хэдийн хэрэгжсэн бөгөөд холбогдох бодлогын баримт бичгүүдэд тусгагдаж, хууль тогтоомжийн уялдаа холбоо хангагдсан байх тул Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан Шинэ Зуунмод хот нь хуулиар тусгайлан тогтоосон чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалт, эдийн засагтай, нийслэл хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэхэд стратегийн ач холбогдол бүхий Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын дагуул хот байна, 4.4-т заасан Шинэ Зуунмод хот нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 34.4-т заасан дүрэмтэй байх" гэсэн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой байна;

- Нийслэлийн дагуул хотыг нийслэлийн болон бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид, эсхүл засаг захиргааны нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжид дамнан байгуулж болно гэж Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 34.2-т заасан, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 5.2-т Хот, тосгоны эдэлбэр газар нь хэд хэдэн сумын нутаг дэвсгэрийг дамнан байрлаж зохицуулалт тусгагдсан байх тул Шинэ Зуунмод хот нь бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид буюу Хөшигийн хөндий дэх Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт дамнан байрлах тухай хуулийн төслийн 5.1 дэх зохицуулалт практикт хэрэгжих боломжтой байна;

- Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д "хот байгуулалтын талаарх төрийн бодлогыг тодорхойлох", 5.1.2-т "хотыг шинээр байгуулах болон татан буулгах, нүүлгэн шилжүүлэх тухай шийдвэр гаргах" бүрэн эрхийг Улсын Их хурал хэрэгжүүлэхээр зохицуулсантай болон Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 35.1-д Дагуул хотыг стратегийн ач холбогдол бүхий дараах нөхцөлийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал байгуулна, 35.2-т Дагуул хотыг байгуулах шийдвэрт хотын нэр, эдэлбэр газрын хэмжээ, байршлыг тусгана гэж заасан тул хуулийн төслийн Шинэ Зуунмод хот эдэлбэр газартай байх, түүний хэмжээг хотыг байгуулах шийдвэрт буюу УИХ тогтоолоор тогтоох зохицуулалт практикт хэрэгжих боломжтой байна;

- Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1-д Шинэ Зуунмод хотын нутаг дэвсгэр энэ хуулиар тодорхойлсон 8 бүстэй байхаар хуульчилсан нь тогтвортой байх, ямар нэг төлөвлөлтөөр тэр бүр өөрчлөхгүй байх давуу талтай байна. Харин "нутаг дэвсгэрийн бүсчлэл" гэж томъёолсон нь хот нутаг дэвсгэртэй байх агуулгыг илэрхийлж байгаа тул Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйлийн 2-т "Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана." гэж заасантай нийцэхгүй байгаа нь практикт хэрэгжих боломжыг хязгаарлаж байна;

- Төсвийн болон МУЗЗНДНТУТХ, МУНУБХЭЗБТХ-д төсвийн болон төсвийн бус хөрөнгөөр хөгжлийн сан байгуулах, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журамтай байх зохицуулалт тусгагдсан, нөгөө талаар Нийслэлд "Улаанбаатар сан"-г байгуулан хотын тохижилтын ажилд тодорхой хувь нэмэр оруулж байсан туршлагатай байх тул Шинэ Зуунмод дэд бүтцийн сантай байх зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх боломжтой байна;

- Газрын тухай хуульд иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг Засгийн газраас баталсан журмын дагуу төсөл шалгаруулах зарчмаар хэрэгжүүлэх зохицуулалт тусгагдсан байх тул хуулийн төслийн

“9.3.Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу нийгмийн болон инженерийн суурь дэд бүтцээс бусад зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглах эрх олгох асуудлыг зөвхөн төсөл сонгон шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ.”, “9.5.Энэ хуулийн 9.3-т заасан төсөл болон сонгон шалгаруулалтад оролцох этгээдэд тавигдах шаардлага, төсөл шалгаруулах журмыг Засгийн газар батална.” гэсэн зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх боломжтой байна;

Дүгнэлт: Хуулийн төслийн зохицуулалтуудыг практикт дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд тодорхой, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байна гэж дүгнэлээ.

4.2.3.“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтээр:

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь Нийтлэг үндэслэл, Хот байгуулалт, Хотын зохион байгуулалт, удирдлагын тогтолцоо, Шинэ Зуунмод хотын эдийн засаг, Хотын бизнесийн орчин, хөрөнгө оруулалт, Бусад асуудал гэсэн 6 бүлэг, 29 зүйлээс бүрдэх бөгөөд хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэж, дүн шинжилгээ хийлээ.

Дүгнэлт: Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан байна.

4.2.4.“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төсөлд төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгох, чиг үүрэг нэмэх, тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэх, хуулийн этгээдэд ачаалал хүндрэл үүсгэх зохицуулалтыг судалж дүн шинжилгээ хийсэн ба дараах байдлаар үнэлгээ хийж дүгнэв:

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 37.1⁶, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1⁷, Хот байгуулалтын тухай хуулийн 10.1⁸ -т зааснаар хотын удирдлага нь Зөвлөл, Захирагч, Ерөнхий архитектор байхаар тусгагдсантай нийцүүлэн хуулийн төслийн 12.1-д Хотын Зөвлөл, Захирагч, Ерөнхий архитектортой байхаар тусгагдсанаас гадна Шинэ Зуунмод хотын удирдлагын тогтолцоонд “Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпораци” гэсэн шинэ бүтцийг бий болгож чиг үүргийг нь тодорхойлсон байна. Гэхдээ энэ нь бусад улсуудын жишгээр авч хэрэгжүүлж байгаа тухайн хотод шаардлагатай бүтэц бий болгож, төрийн байгууллагын оролцоо, ачааллыг багасгаж байгаа зохицуулалт байх тул олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөн хэрэгжих боломжтой байна;

- Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн “18.1.Төрөөс хотын бүтээн байгуулалтад татварын болон татварын бус дэмжлэг үзүүлнэ.” гэж заасан зохицуулалт нь төрийн байгууллагад нэмэлт чиг үүрэг хүлээлгэж байгаа агуулгатай байх боловч энэхүү чиг үүрэг нь төрийн байгууллагуудын хуулиар хүлээсэн үүрэг байх бөгөөд энэхүү чиг үүрэг нь шинэ хотын бүтээн байгуулалтыг дэмжих, улмаар

⁶ 37.1.Дагуул хотын удирдлага нь Захирагч, түүнд зөвлөх үүрэг бүхий дагуул хотын зөвлөлөөс бүрдэнэ.

⁷ 10.1.Хот, тосгоны удирдлага нь захирагч, зөвлөлөөс бүрдэнэ.

⁸ 10.1.Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитектор нь хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан дүрмийн дагуу дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ”.

иргэн, хуулийн этгээдэд эерэг үр нөлөөтэй зохицуулалт байх тул олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөн хэрэгжих боломжтой байна;

- Хуулийн төслийн 19 дүгээр зүйлийн "19.1.Нийслэл хот нь Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтад зориулж холбогдох хууль, журмын дагуу үнэт цаас гаргаж болно." гэж заасан нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15.1.6⁹-д нийслэл нь үнэт цаас гаргах эрхтэй, Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.24-т "аймаг, нийслэлийн үнэт цаас" гэж аймаг, нийслэлээс тодорхой төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зорилгоор хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, журмын дагуу олон нийтэд санал болгон, эсхүл нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд арилжаалах өрийн бичгийг" гэж, Үнэт цаасны тухай хуулийн 5.1.10-т Аймаг, нийслэлийн үнэт цаас санхүүгийн хэрэгсэлд хамаарахаар тус тус заасантай нийцэж байх тул нийслэл хотоос дагуул хотын бүтээн байгуулалтад зориулж үнэт цаас гаргах, арилжаалах асуудал нь олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөх боломжтой байна.

4.2.5."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтээр:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгасан. Харилцан уялдаатай байдлыг хангасан байна.

4.3.Зөвлөмж

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон түүнийг дагалдан гарах хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал"-ын дагуу 5 шалгуур үзүүлэлтээр үнэлж, дүгнэн хуулийн төсөл боловсруулагчид дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1.Хуулийн төслийн 8.1 дэх хэсгийг Газрын тухай хуулийн 12.1¹⁰, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 35.2¹¹ болон Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 5.2-т заасантай нийцүүлэн "Хотын эдэлбэр газар нь дараах бүсчлэлтэй байна:" гэж томъёолох;

2.Хуулийн төслийн 10.2-т Шинэ Зуунмод хот Засгийн газар, нийслэл, бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тухайлбал, Төв аймаг, Сэргэлэн сум, Алтанбулаг сумаас шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан нь төрийн байгууллагын чиг үүрэг давхардахгүй байх эерэг үр нөлөөтэй байх боловч ямар чиг үүргийг шилжүүлэх талаар хуулийн төсөл болон түүнийг дагалдан гарах бусад

⁹ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15.1.6 хуульд заасан үндэслэл, журмын дагуу төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн саналыг хэлэлцэх, үнэт цаас гаргах асуудлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэх.

¹⁰ 12 дугаар зүйл.Хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газар

12.1.Хот, тосгон, бусад суурины газар болон нийслэл хотын эдэлбэр газарт хот, тосгон, бусад суурины барилга байгууламж, үйлдвэр, уурхайн дэвсгэр газар, инженерийн дэд бүтэц, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийн газар, нийтийн эдэлбэрийн газар болон цаашид тэлж хөгжих нөөц газар хамаарах бөгөөд эдэлбэр газрын хэмжээ, заагийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталж, тогтооно.

¹¹ Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйл.Дагуул хотыг байгуулах

35.2.Дагуул хотыг байгуулах шийдвэрт хотын нэр, эдэлбэр газрын хэмжээ, байршлыг тусгана.

хуулиудад тухайлан зааж өгөөгүй байгаа нь энэхүү зохицуулалт хэрэгжихгүй байх, үр нөлөөгүй байх үр дагаврыг бий болгож байна. Иймд Захиргааны ерөнхий хуулийн 8.1-д “хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно” гэж заасантай нийцүүлэн хуулийн төсөл болон холбогдох бусад хуульд нийслэлийн дагуул хотын удирдлагад шилжүүлэх бүрэн эрхийг тухайлан заасан зохицуулалтыг тусгах;

3.Хуулийн төслийн 10.3-т хотын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төрийн болон орон нутгийн өмчийг Засгийн газар, нийслэл, бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж буюу Төв аймаг, Сэргэлэн, Алтанбулаг сумдаас Шинэ Зуунмод хотод шилжүүлж болохоор хуулийн төсөлд тусгасан боловч хэрхэн шилжүүлэх асуудлыг холбогдох хуулиар зохицуулахаар заасан байна. Иймд хуулийн төслийн 10.3 дахь зохицуулалт нь шууд хэрэгжих боломжгүй байх тул Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд хотод өмчийн эрх шилжүүлэх заалтыг тусгах;

4.Хуулийн төслийн 10.4-т хотын удирдлага эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даасан шийдвэр гаргах эрхтэй гэж заасан боловч манай улсын Төсвийн тухай хуульд хотын төсөв гэсэн ангилал байхгүй, нэгдсэн төсөвтэй байх зарчмын хүрээнд хотын төсвийг нийслэлийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байхаар хуулийн төслийн 20.1-д зохицуулалт тусгасан байна. Иймд хотын бие даасан байдлыг хангах, улмаар хуулийн төслийн 1.1-д заасан зорилгыг бүрэн хангахын тулд хуулийн төслийн 20.1-д заасны дагуу нийслэлийн төсөвт жил бүр хотын төсвийг шаардлагатай хэмжээгээр тусгаж, баталж өгөх үүрэг хүлээлгэсэн зохицуулалтыг холбогдох хуульд тусгах;

5.Хуулийн төслийн 22.2-т Шинэ Зуунмод хотын дэд бүтцийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хуулийн төслийн 22.2-т нарийвчлан зөөж өгсөн байх бөгөөд эдгээр эх үүсвэр нь Хотын удирдлагаас үл хамаарах эх үүсвэрүүд байгаа тул холбогдох хууль болон дүрэмд нь тухайлан зааж өгөх шаардлагатай байна. Жишээлбэл, Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпорацийн дүрэм, Нийслэлийн төсвийн хуваарилалт гэх мэт.

Үр нөлөөг үнэлэх судалгааг дүгнэхэд:

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд тавигдах ерөнхий шаардлагыг хангасан гэж дүгнэлээ.

Харин судалгааны “Зөвлөмж” хэсэгт дурдсан хуулийн төслийн зарим зүйл, заалтыг дахин нягтлах, боловсруулалт хийх, зөрчилтэй зүйл заалтын зөрчлийг арилгах шаардлагатай гэж дүгнэлээ.

---oooOOooo---

ТАВ.АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn
2. Нийслэлийн цахим мэдээллийн систем www.ulaanbaatar.mn
3. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn
4. Нэгдсэн үндэсний хөгжлийн хөтөлбөр www.undp.org
5. Монгол хэлний их тайлбар толь, цахим систем <https://mongoltoli.mn>
6. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын цахим систем <http://www.citycouncil.mn/>
7. Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалгааны тайлан., УБ, 2024 он;
8. Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө;

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**ШИНЭ ЗУУНМОД ХОТЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА	
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	3
НЭГ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО	3
1.1.Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох.....	4
1.2.Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох.....	6
1.3.Гарах зардлыг урьдчилан тооцох	11
1.4. Зардлыг нэгтгэн тооцох /төгрөгөөр/	13
1.5. Хувилбарыг нягталж үр дүнг танилцуулах	13
ХОЁР. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ	14
2.1. Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох	14
2.2. Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох	15
2.3. Тоон үзүүлэлтийг тооцох	16
2.4. Нийт дүнг тооцож гаргах	16
2.5.Хялбарчлах боломжийг шалгах	17
ГУРАВ.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО	18
3.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох	18
3.2.Зардлыг тооцох	18
3.3.Тоон үзүүлэлтийг тооцох	20
3.4. Нийт зардлын дүнг тооцож гаргах.....	21
3.5. Хялбарчлах боломжийг ашиглах	21
3.6.Нэмэлт зардлыг тооцох	22
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	23
ТАВ.АШИГЛАСАН МАТЕРИАЛ	25

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 18.1-д “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамрагдах төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэнд шинээр үүсэх болон нэмэгдэх үүргийн улмаас бий болох зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын дагуу хийж гүйцэтгэлээ.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэх болно. Хуулийн төслийн зардлыг тооцохдоо бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаа авах, түүнчлэн хуулийн төслийн тандан судалгааны тайланд тусгасан судалгаа, тоо баримт, статистикийг ашиглан хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төр, хуулийн этгээд, аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс гарч болох зардлыг тоймлон тооцсон бөгөөд дараах зарчмыг баримталсан:

- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Тооцох боломжтой зардлуудыг бүрэн тооцох;
- Тухайн чиг үүрэгтэй төстэй үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлээс судалгаа авах, ярилцлага хийх зэрэг аргаар шаардлагатай мэдээллийг цуглуулж, зарцуулах хугацааг тодорхойлохыг эрмэлзсэн болно.

НЭГ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

“Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл”-ийн төрийн байгууллагад үүрэг оногдуулсан зохицуулалтуудыг харгалзан тухайн байгууллагад үүсэх ачаалал, зардлын хэмжээг урьдчилан тооцох нь тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийн хэмжээ, хэрэгцээ, шаардлагыг тогтооход оршино.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын 4.1-д заасны дагуу Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцож гаргах бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

1. Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
3. Гарах зардлыг урьдчилан тооцох;
4. Зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

¹ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

Энэ шатанд төрийн байгууллагын ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон жилд гүйцэтгэх тоо буюу тохиолдлын тоо, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт ажлын цаг гэсэн 3 үзүүлэлтийг тодорхойлно.

1.1. Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох

Хуулийн төсөлд дараах байгууллагууд тодорхой чиг үүрэг гүйцэтгэхээр тусгагдсан байна:

- Монгол Улсын Их Хурал;
- Монгол Улсын Засгийн газар;
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /НИТХ/;
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч;
- Төв аймгийн болон Сэргэлэн, Алтанбулаг сумын удирдлага;
- Шинэ Зуунмод хотын зөвлөл;
- Шинэ Зуунмод хотын Захирагч;
- Шинэ Зуунмод хотын Ерөнхий архитектор;
- Шинэ Зуунмод хотын Захирагчийн Ажлын алба;
- Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпораци.

Аргачлалын 4.3.2-т “байгууллагыг сонгохдоо тухайн ажил, үйлчилгээнд хамааралтай бүх байгууллагыг биш голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгоно” гэж заасны дагуу нийслэлээс өөр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нутаг дэвсгэрт байгуулагдаж байгаа нийслэлийн дагуул хот болох онцлогтой нь холбогдуулан дээрх байгууллагуудаас дараах байгууллагыг сонгон гүйцэтгэх үүрэг, холбогдох зардлыг тооцсон болно:

1. Засгийн газар;
2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч;
3. Шинэ Зуунмод хотын зөвлөл;
4. Шинэ Зуунмод хотын Захирагч;
5. Шинэ Зуунмод хотын Ерөнхий архитектор;

Аргачлалын 4.3.3-т ажил, үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг тооцохоор тусгасны дагуу дээрх байгууллагуудаас сонгож, хэрэгжүүлэх, хэмжих боломжтой гэж үзсэн ажлуудыг доор түүвэрлэн авч үзлээ.

Сонгон авсан төрийн байгууллагууд дараах ажил, үйлчилгээг гүйцэтгэхээр хуулийн төсөлд тусгагдсан байна:

Хүснэгт 1

№	Гүйцэтгэх ажил
Нэг.Засгийн газар:	
1.	Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах;
2.	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглах эрх олгох төсөл болон сонгон шалгаруулалтад оролцох этгээдэд тавигдах шаардлага, төсөл шалгаруулах журам батлах;
3.	2040 он хүртэл жил бүр улсын төсөвт инженерийн болон нийгмийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт, төрийн байгууллагуудыг үе шаттай нүүлгэн шилжүүлэх зардлын төсвийг тусгах;
4.	Хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тооны хязгаарыг батлах;
5.	Шинэ Зуунмод хотын газар хөгжүүлэлт, менежмент, хэрэгжих бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, хөрөнгө оруулах, төслийн хэрэгжилтэд

	хяналт тавих чиг үүрэг бүхий нийслэл, Төв аймгийн өмчийн оролцоотой Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпораци байгуулах асуудлыг нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн шийдвэрлэх;
6.	Корпорацийн дүрэм, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах журам батлах;
7.	төрийн байгууллагуудыг үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх;
8.	Хотын бүтээн байгуулалтын төсөлд хөнгөлөлттэй зээл олгох бодлогыг дэмжиж хэрэгжүүлэх;
9.	Шинэ Зуунмод хотын дүрмийг батлах /МУНУБХЭЗБТХ-34.4/
Хоёр. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч:	
1.	Хөрөнгө оруулагчдын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;
2.	Корпорацийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулж, томилох;
3.	Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтад зориулж холбогдох хууль, журмын дагуу үнэт цаас гаргах;
4.	эрчим хүч, дулаан, ус хангамж, ариутгах татуурга, харилцаа холбоо, инженерийн бэлтгэл арга хэмжээ, хог хаягдалтай холбоотой зөвшөөрөл, үйлчилгээг саадгүй үзүүлэх;
5.	орон нутгийн татвар, төлбөр, хураамжаас хөнгөлөх, чөлөөлөх;
6.	өөрийн мэдлийн өмчийг дагуул хотод хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах асуудлыг шийдвэрлэх;
7.	төрийн үйлчилгээг шуурхай, нэг цонхоор үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
8.	салбарын хяналт, шалгалтыг давхардуулахгүй байх.
Гурав.Шинэ Зуунмод хотын Зөвлөл:	
1.	Шинэ Зуунмод хотын нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого тодорхойлох, хотын чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх
2.	хотын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэл, Шинэ Зуунмод хотын төсөв, хөтөлбөрийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;
3.	хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлах, хэрэгжилтэд хяналт тавих;
4.	Шинэ Зуунмод хотын бүсчлэлийн дүрмийг батлах;
5.	Шинэ Зуунмод хотын газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөг Ерөнхий архитекторын саналыг үндэслэн батлах;
6.	Шинэ Зуунмод хотын Захирагчийн тайланг сонсох;
7.	хуульд өөрөөр заагаагүй бол Шинэ Зуунмод хотын чиг үүрэг хэрэгжүүлэх талаар журам, дүрэм, заавар батлах;
8.	Шинэ Зуунмод хотын эдэлбэр газрын бүсчлэл, үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах зардал зэргийг харгалзан татвар, төлбөр, хураамж, урамшууллын хэмжээг тогтоох;
9.	Шинэ Зуунмод хотын өмчийн зүйлсийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх;
10.	хотын өмчийн болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах;
11.	хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.
Дөрөв.Шинэ Зуунмод хотын Захирагч:	
1.	Шинэ Зуунмод хотын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлж, зохион байгуулах;
2.	хотын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэл, хөтөлбөрийг боловсруулан Хотын Зөвлөлөөр батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;
3.	хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
4.	хотын төсвийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах;
5.	хотын өмчийг хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулж, тэдгээрийг шинээр бий болгох, түрээслэх асуудлыг шийдвэрлэх;
6.	хотын мэдлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг чиглүүлж, удирдлагыг нь томилж, чөлөөлөх;

7.	хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хотыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах;
8.	хотын Зөвлөлд ажлаа тайлагнах, нийтэд мэдээлэх;
9.	бүс нутаг, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хот хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, дэмжлэг үзүүлэх, бусад улсын хоттой холбоо тогтоох, хамтран ажиллах;
10.	хотод байгуулагдсан чөлөөт бүсийн Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх;
11.	хуульд заасан бусад.
Тав.Шинэ Зуунмод хотын Ерөнхий архитектор:	
1.	хот байгуулалтын салбарын норматив, эрх зүйн бусад актын төсөл болон тэдгээрийг боловсруулах, өөрчлөх тухай санал оруулах;
2.	орон нутаг дахь хот байгуулалтын бодлого боловсруулахад санал гаргах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
3.	зураг төсөл, хайгуул, шинжилгээний ажлыг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах;
4.	хот суурины нутаг дэвсгэрт хот байгуулалтын кадастр хөтлөх, хот байгуулалтын архивын санг бүрдүүлэх;
5.	орон нутгийн хот байгуулалтын үйл ажиллагааг зохицуулж, Хот байгуулалт, барилга захиалагчийн албыг өдөр тутмын мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;
6.	барилга байгууламжийг барьж байгуулахаас өмнө тухайн газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гудамжны нэр, барилгын дугаарыг тогтоож, газрын кадастрын бүртгэлд оруулах ажлыг зохион байгуулах;
7.	хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан жил бүрийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгөх;
8.	инженерийн бэлтгэл ажилд хяналт тавих.
9.	хот байгуулалт, газар зохион байгуулалтын баримт бичгийг боловсруулах, эрх бүхий этгээдээр батлуулах;
10.	хот байгуулалт, газар зохион байгуулалтын баримт бичгийн хэрэгжилтэнд хяналт тавих;
11.	инженерийн дэд бүтцийн төлөвлөлт, хөгжүүлэлт;
12.	Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпорацийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөмж, дүгнэлт хүргүүлэх;
12.	Барилгажилтын төсөл батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;
13.	тухайн жилийн хот байгуулалт, газар зохион байгуулалтын баримт бичгийн хэрэгжилтийг дараа оны хоёрдугаар сарын 15-ны өдрийн дотор хотын Захирагчид тайлагнах.

1.2.Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Хуулийн төслөөр голлох чиг үүрэг хүлээлгэсэн төрийн байгууллагууд тухайн чиг үүрэг тус бүрийг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаа буюу ажил үйлчилгээ тус бүрийг тооцож, эдгээрт ямар цаг хугацаа зарцуулах, улсын болон орон нутгийн төсөвт хүний нөөцтэй холбоотой ямар хэмжээний зардал үүсэхийг урьдчилан тооцлоо.

Хүний нөөцийн хэрэгцээг тооцохдоо тухайн ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хугацаа болон 1 жилд гүйцэтгэх тохиолдлын тоогоор баримжаалж, тухайн байгууллагын жилийн эцсийн тайлан мэдээ, статистик үзүүлэлт, тоон үзүүлэлт, мэдээ баримт, ажлын байрны ажиглалт дээр үндэслэн стандарт үйл ажиллагааны хугацааг тогтоосон болно.

Аргачлалын 4.4.5.1-д "тохиолдлын тоог тогтоох боломжтой үед зарцуулах хугацааг тохиолдлын тоогоор үржүүлж хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлно.":

Хүний нөөцийн хэрэгцээ=Зарцуулах хугацаа * тохиолдлын тоо
 $80 = 80 \text{ минут} * 1/\text{тухайн ажлыг 1 удаа хийнэ гэж тооцсон}/$

1.2.1.Засгийн газрын хэрэгжүүлэх чиг үүргийн 8 ажил нь дээрх тохиолдолтой адил гэж үзээд доор тооцвол: $720 = 80 \text{ минут} * 9$

Аргачлалын 4.4.7-д "Тооцож гаргасан хүний нөөцийн хэрэгцээг жилд шаардагдах ажлын цагт хувааж тухайн ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтны тоо буюу нэмэгдэх ажлын ачааллын хувийг гаргана" гэж заасны дагуу дараах тооцоог хийлээ.

Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу 1 өдрийн 8 цаг, 1 цаг = 60 минут, Жилд 2202 ажлын өдөр буюу $220 \times 8 = 1760$ ажлын цаг буюу $1,760 \times 60 = 105,600$ минут жилд шаардагдах ажлын цаг нь 105,600 минут гэж тооцов.

Хүний нөөцийн хэрэгцээ/жилд шаардагдах ажлын цаг=Нэмэгдэх ажлын ачааллын хувь: $720/105,600=0$ буюу ажлын ачаалал нэмэгдэхгүй.

Хүснэгт 2

Засгийн газар чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа
 /хугацаа их шаардагдах нэг ажлыг жишиг болгон авч үзэв/

№	Хэрэгжүүлэх чиг үүрэг /Ажил, үйлчилгээ/	Хийгдэх ажиллагаа	Зарцуулах хугацаа
1	Шинэ Зуунмод хотын дүрмийг батлах	Нийслэлийн Засаг даргаас өргөн барьсан дүрмийн төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад танилцуулж санал авах	180 мин
		Нийслэлийн Засаг даргаас өргөн барьсан дүрмийн төслийг ЗГ-ын хуралдааны хуваарьт оруулах;	20 минут
		Засгийн газарт өргөн барьсан төслийн танилцуулгыг сонсож, асуулт, хариулт явагдаж хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх;	60 минут
		Төслийг баталгаажуулах;	30 минут
		Баталгаажсан шийдвэрийг хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлэхээр холбогдох байгууллагад хүргүүлэх;	1 цаг /60 минут/
		Хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэхтэй холбоотой тайлбар өгөх;	40 минут
		Бүртгэгдсэн хэм хэмжээний актын хувийг авч, бүртгэх.	30 минут
	Нэг тохиолдлыг шийдвэрлэх нийт хугацаа		
Жилд ойролцоогоор 5 хэм хэмжээний акт батлан гаргана гэж үзээд: 2,100минут = 420 минут*5 удаа			

Хүний нөөцийн хэрэгцээ/жилд шаардагдах ажлын цаг=Нэмэгдэх ажлын ачааллын хувь: $2,100/105,600=0$ буюу ажлын ачаалал нэмэгдэхгүй.

²Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийг баримталж, ээлжийн амралт болон нийтээр амрах хоногийг хасч ажлын өдрийг тооцож гаргасан болно.

1.2.2. Хотын Зөвлөлийн чиг үүргийн хүний нөөцийн хэрэгцээ, цаг зарцуулалт:

Шинэ Зуун мод хотын зөвлөл нь бодлого тодорхойлох, тэдгээрийн хэрэгжилтэд хянал тавих чиг үүрэг хэрэгжүүлж байх тул жишиг болгон нэг чиг үүргийг авч тооцоо хийж, түүгээр баримжаалан нийт чиг үүргийн хүний нөөцийн хэрэгцээ, зарцуулах хугацааг тодорхойлов.

Хүснэгт 3

	Хэрэгжүүлэх чиг үүрэг /Ажил, үйлчилгээ/	Хийгдэх ажиллагаа	Зарцуулах хугацаа
1.	Хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлэхээр баталсан захиргааны хэм хэмжээ агуулсан журам, стандарт, дүрэм, зааврыг холбогдох хуулийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх	Судалгаа хийх /нөлөөллийн шинжилгээ хийх/	Ажлын 10 өдөр /4800 минут/
		Төсөл боловсруулах	5 цаг /300 минут/
		Төслийг цахим хуудаст байршуулах	20 минут
		Хэлэлцүүлэг зохион байгуулах, цахим хуудсаар ирсэн саналыг хэлэлцүүлэг зохион байгуулахад ирүүлсэн саналтай нэгтгэж төсөлд тусгах	8 цаг /480 минут/
		Төсөлд хяналтын дагалдах хуудас авч, холбогдох хэлтсийн дарга, Тамгын газрын дарга, төслүүдийн удирдагч, орлогч, Нийслэлийн Засаг даргад танилцуулах	Ажлын 3 өдөр 24 цаг /1440 минут/
		Төсөлд холбогдох албан тушаалтнуудын саналыг тусган эцэслэн боловсруулах	2 цаг /120 минут/
		Төслийг баталгаажуулах	2 цаг /120 минут/
		Баталгаажсан шийдвэрийг хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлэхээр холбогдох байгууллагад хүргүүлэх	2 цаг /120 минут/
		Хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэхтэй холбоотой тайлбар өгөх	1 цаг /60 минут/
		Бүртгэгдсэн хэм хэмжээний актын хувийг авч, бүртгэлд өгөх	30 минут
	Нэг тохиолдлыг шийдвэрлэх нийт хугацаа /Цахим хуудаст байршуулах 30 хоногийн хугацааг оруулж тооцоогүй бөгөөд байршуулаад 30 хоног байлгах учир тухайн хугацаанд заавал ажил хийх шаардлагатай биш гэж үзсэн/	өдөр – 14 Цаг – 116 /Минут – 7010/	
Жилд ойролцоогоор 3 хэм хэмжээний акт батлан гаргана гэж үзээд: 21030минут = 7010минут* удаа			

Хүний нөөцийн хэрэгцээ/жилд шаардагдах ажлын цаг=Нэмэгдэх ажлын ачааллын хувь: $21030/105600=0$ буюу ажлын ачаалал нэмэгдэхгүй.

Хүснэгт 4

1.2.3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн чиг үүргийн хүний нөөцийн хэрэгцээ:

№	Хэрэгжүүлэх чиг үүрэг /Ажил, үйлчилгээ/	Хийгдэх ажиллагаа	Зарцуулах хугацаа
1.	ШЗМХотын Хөрөнгө оруулагчдын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;	Судалгаа хийх	Ажлын 5 өдөр 40 цаг, 2,400 минут

2.	Корпорацийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулж, томилох;	Сонгон шалгаруулалтыг зарлах, ирсэн саналыг хяна үзэж үнэлэх, шалгаруулах, томилох	Ажлын 3 өдөр 24 цаг, 3600 минут
3.	хотын эрчим хүч, дулаан, ус хангамж, ариутгах татуурга, харилцаа холбоо, инженерийн бэлтгэл арга хэмжээ, хог хаягдалтай холбоотой зөвшөөрөл, үйлчилгээг саадгүй үзүүлэх;	Нэг цонхны үйлчилгээ үзүүлэх	Ажлын 1 өдөр 8 цаг, 480 минут
4.	өөрийн мэдлийн өмчийг дагуул хотод хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах асуудлыг шийдвэрлэх;	Гэрээ байгуулах	Ажлын 1 өдөр 8 цаг, 480 минут
Асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах нийт хугацаа			Өдөр – 10 /Цаг – 80/ /Минут – 4800/

Хүний нөөцийн хэрэгцээ=Зарцуулах хугацаа * тохиолдлын тоо
19,200 = 4800 минут * 4 /дээрх 4 ажлыг хийгдэнэ гэж тооцсон/

Хүний нөөцийн хэрэгцээ/жилд шаардагдах ажлын цаг=Нэмэгдэх ажлын ачааллын хувь ажлын ачаалал нэмэгдэхгүй.

Хүний нөөцийн хэрэгцээ/жилд шаардагдах ажлын цаг=Нэмэгдэх ажлын ачааллын хувь: **19200/105600=0 буюу ажлын ачаалал нэмэгдэхгүй.**

Хүснэгт 5

1.2.4.Шинэ Зуунмод хотын Захирагчийн чиг үүргийн хүний нөөцийн хэрэгцээ

№	Хэрэгжүүлэх чиг үүрэг /Ажил, үйлчилгээ/	Хийгдэх ажиллагаа	Зарцуулах хугацаа
1.	хотын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэл, хөтөлбөрийг боловсруулан Хотын Зөвлөлөөр батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;	Судалгаа хийх	Ажлын 3 өдөр 24 цаг, 1,440 минут
		Төсөл боловсруулах	Ажлын 2 өдөр 16 цаг, 960 минут
		Хотын зөвлөлөөр батлуулах	Ажлын 1 өдөр 8 цаг, 480 минут
		Хэрэгжилтийг зохион байгуулах	Ажлын 5 өдөр 40 цаг, 2,400 минут
2.	хотын мэдлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг чиглүүлж, удирдлагыг нь томилж, чөлөөлөх;	Томилж, чөлөөлөх	Ажлын 1 өдөр 8 цаг, 480 минут
3.	хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хотыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах;	Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Ажлын 5 өдөр 40 цаг, 2,400 минут
4.	хотын Зөвлөлд ажлаа тайлагнах, нийтэд мэдээлэх;	Тайлагнах, нийтэд мэдээлэх	Ажлын 1 өдөр 8 цаг, 480 минут
5.	бүс нутаг, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хот хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, дэмжлэг үзүүлэх, бусад улсын	Харилцаа холбоо тогтоох	Ажлын 1 өдөр 8 цаг, 480 минут
		Хамтран ажиллах	Ажлын 3 өдөр

хоттой холбоо тогтоох, хамтран ажиллах;	24 цаг, 1,440 минут
Үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулах нийт хугацаа	Өдөр – 22 /Цаг – 176/ /Минут – 10,560/

Хүний нөөцийн хэрэгцээ=Зарцуулах хугацаа * тохиолдлын тоо
 $19,200 = 10,560 \text{ минут} * 5 \text{ /дээрх 5 ажлыг хийгдэнэ гэж тооцсон/}$

Хүний нөөцийн хэрэгцээ/жилд шаардагдах ажлын цаг=Нэмэгдэх ажлын ачааллын хувь ажлын ачаалал нэмэгдэхгүй.

Хүний нөөцийн хэрэгцээ/жилд шаардагдах ажлын цаг=Нэмэгдэх ажлын ачааллын хувь: $19,200/105,600=0$ буюу ажлын ачаалал нэмэгдэхгүй.

1.2.5.Шинэ Зуунмод хотын Ерөнхий архитекторын чиг үүргийн хүний нөөцийн хэрэгцээ:

Хүснэгт 6

№	Хэрэгжүүлэх чиг үүрэг /Ажил, үйлчилгээ/	Хийгдэх ажиллагаа	Зарцуулах хугацаа
1.	хот байгуулалтын салбарын норматив, эрх зүйн бусад актын төсөл болон тэдгээрийг боловсруулах, өөрчлөх тухай санал оруулах;	Эрх зүйн актын төсөл боловсруулах	Ажлын 5 өдөр 40 цаг, 2,400 мин
		Холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулах ажлыг зохион байгуулах	Ажлын 3 өдөр 24 цаг, 1,440 мин
2.	хот суурины нутаг дэвсгэрт хот байгуулалтын кадастр хөтлөх, хот байгуулалтын архивын санг бүрдүүлэх;	Кадастр хөтлөх	Ажлын 5 өдөр 40 цаг, 2,400 мин
		Хот байгуулалтын архивын сан үүсгэх	Ажлын 3 өдөр 24 цаг, 1,440 мин
		Санг хөтлөх	Ажлын 3 өдөр 24 цаг, 1,440 мин
3.	барилга байгууламжийг барьж байгуулахаас өмнө тухайн газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гудамжны нэр, барилгын дугаарыг тогтоож, газрын кадастрын бүртгэлд оруулах ажлыг зохион байгуулах;	Гудамжны нэр, барилгын дугаар тогтоох ажлыг зохион байгуулах	Ажлын 3 өдөр 24 цаг, 1,440 мин
		Кадастрын бүртгэлд оруулах	Ажлын 3 өдөр 24 цаг, 1,440 мин
4.	хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан жил бүрийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгөх;	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал авах, нэгтгэх	Ажлын 3 өдөр 24 цаг, 1,440 мин
		газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх	Ажлын 2 өдөр 16 цаг, 960 мин
5.	хот байгуулалт, газар зохион байгуулалтын баримт бичгийг боловсруулах, эрх бүхий этгээдээр батлуулах;	Баримт бичгийн төсөл боловсруулах	Ажлын 5 өдөр 40 цаг, 2,400 мин
		Холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулах ажлыг зохион байгуулах	Ажлын 3 өдөр 24 цаг, 1,440 мин

6.	Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпорацийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөмж, дүгнэлт хүргүүлэх;	Хяналт тавих	Ажлын 3 өдөр 24 цаг, 1,440 мин
		Зөвлөмж, дүгнэлт гаргах	Ажлын 2 өдөр 16 цаг, 960 мин
Асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах нийт хугацаа			Өдөр – 43 /Цаг – 344/ /Минут – 20,640/

Хүний нөөцийн хэрэгцээ=Зарцуулах хугацаа * тохиолдлын тоо
 $19,200 = 20,640 \text{ минут} * 6 \text{ /дээрх 6 ажлыг хийгдэнэ гэж тооцсон/}$

Хүний нөөцийн хэрэгцээ/жилд шаардагдах ажлын цаг=Нэмэгдэх ажлын ачааллын хувь ажлын ачаалал нэмэгдэхгүй.

Хүний нөөцийн хэрэгцээ/жилд шаардагдах ажлын цаг=Нэмэгдэх ажлын ачааллын хувь: $19,200/105,600=0$ буюу ажлын ачаалал нэмэгдэхгүй.

1.3.Гарах зардлыг урьдчилан тооцох

1.3.1. Хүний нөөцийн зардал:

Хууль батлагдсанаар орон тоо нэмэгдэхгүй одоогийн хүний нөөцийн хүчин чадлаар ажиллах боломжтой тул цалингийн зардал нэмэгдэхгүй гэж үзлээ. Шинэ Зуунмод хотын захиргаа байгуулсан тохиолдолд Ажлын албаны зардал, албан хаагчдын цалин бусад зардал гарна. Жишээ болгож Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 1 албан хаагчийн зардлыг тооцов. Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалинг шинэчлэн тогтоосны дагуу доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 7

Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ

(сард, төгрөгөөр)

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ
T3-1	2,218,000
T3-2	1,974,000
T3-3	1,862,000
T3-4	1,757,000
T3-5	1,597,000
T3-6	1,452,000
T3-7	1,320,000
T3-8	1,200,000
T3-9	1,100,000
T3-10	1,000,000

Засгийн газрын 2023 оны 06 дугаарсарын 21-ний
өдрийн 241 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралт

Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл
ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ

(сард, төгрөгөөр)

Албан тушаал	Цалингийн доод хэмжээ
ТҮ-12	1,418,000
ТҮ-11	1,351,000
ТҮ-10	1,286,000
ТҮ-9	1,225,000
ТҮ-8	1,114,000
ТҮ-7	1,053,000
ТҮ-6	1,003,000
ТҮ-5	912,000
ТҮ-4	868,000
ТҮ-3	827,000
ТҮ-2	788,000
ТҮ-1	750,000

Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын ангилал зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг баталсан бөгөөд Шинэ Зуунмод хотын Ажлын албаны ажилтны ангилал, зэрэглэлийг тогтоогоогүй бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны албан хаагчтай адил ангилал, зэрэглэлийг ТЗ-7 байхаар тооцоолсон болно.

Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоосон тул уг тогтоолын дагуу доорх хүснэгтэд тооцоог гаргав.

Хүснэгт 8

	Үндсэн цалин	Зэрэг дэв	Төрийн алба хаасан хугацаа	Хоол унааны нэмэгдэл	Нийт дүн /төгрөгөөр/
1.	ТЗ-7 1,320,000	24% 316,800	5% 66,000	200,000	1,902,800 сард 22,833,600 жилд

1.3.2. Материаллаг зардал:

Материаллаг зардалд тухайн үүргийг гүйцэтгэж буй нэг албан хаагчийг ажиллах нөхцөлөөр хангахад зарцуулж буй зардлыг тооцов.

Нэг албан хаагчид гарах жилийн дундаж материаллаг зардал:

Хүснэгт 9

№	Зардлын нэр	Зардлын төрөл	Хэмжээ /төгрөг/
1	Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	160,000
		Утасны зардал	330,000
		Урсгал засвар	100,000
2	Элэгдэл хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	160,000
		Тавилга эд хогшил	80,000
Нийт			830,000

Хүний нөөц нэмэгдэхгүй учир материаллаг зардал мөн адил нэмэгдэхгүй хэвээр байна.

1.3.3. Бусад зардал

Аргачлалын 4.5.3-т "бусад зардал-тухайн ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардлыг хэлнэ" гэсэн бөгөөд дагалдан гарах бусад зардал гарахгүй гэж үзэж байна.

1.4. Зардлыг нэгтгэн тооцох /төгрөгөөр/

Аргачлалын 4.6-д "Нийт зардал = (хүний нөөцийн зардал+материаллаг зардал+бусад зардал)*хүний нөөцийн хэрэгцээ" гэж томъёолсны дагуу:

$$23,663,600 = (22,833,600 + 830,000 + 0) * 1 \text{ /Одоогийн 1 хүний зардал/}$$

Хууль батлагдсанаар зардал нэмэгдэхгүй учир одоогийн 1 хүний зардал хэвээр байна гэж үзлээ.

1.5. Хувилбарыг нягталж үр дүнг танилцуулах

Хууль батлагдсанаар нийслэл болон бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн захиргааны байгууллага болон түүнд ажиллах орон тоо нэмэгдэхгүй, төрийн байгууллагад нэмэгдэл зардал гарахгүй болно. Харин шинээр байгуулагдах Шинэ Зуун мод хотын захирагч, түүний Ажлын алба, Ерөнхий архитектор, түүний ажлын алба, Хотын Зөвлөл, Хөгжлийн корпораци зэргийн орон тоо, зардлын асуудлыг тооцож, төсөвт тусгах шаардлагатай болно.

Мөн дээр дурдсан зардлуудаас гадна шинэ хотын бүтээн байгуулалттай холбоотойгоор Шинэ Зуунмод хотод архитектур төлөвлөлтийн дагуу тооцсон барилга байгууламжийн хөрөнгө оруулалт нь 10.5 сая м² барилга талбайн хувьд 17 их наяд төгрөг байхаар тоцоолол хийгдсэн байх ба 2025-2040 онд 3 үе шатаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.³

Хүснэгт 10

Хөрөнгө оруулалтын тооцоо

№	Хөрөнгө оруулалтын төрөл	1-р ээлж /2025 он/	2-р ээлж /2030 он/	3-р ээлж /2040 он/	Нийт /тэрбум төг/
1	Орон сууц	178.2	476.8	540.4	1,195.4
2	Нийгмийн дэд бүтэц	38.2	119.5	35.6	193.3
3	Олон нийт	2,000.9	1,046.2	2,431.9	5,479.1
4	Өндөр технологийн үйлдвэр бүс		301.9	356.5	658.4
5	Үйлдвэрийн бүс		334.6	334.6	669.1
6	Худалдааны бүс		262.1	262.1	524.2
7	Логистик бүс	35.8	286.4	35.8	358.1
8	Модны аж ахуй			12.7	12.7
9	Карго төв		126.0	189.1	315.1
10	ХӨСҮТ-2		41.7	50.9	92.6
11	Чөлөөт бүс		2,261.9	3,392.8	5,654.6
12	Авто зам	90.0	449.8	359.8	899.5
13	Явган зам	3.9	19.3	15.5	38.7

³ Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө. Боть-II, Төлөвлөлтийн шийдэл, хэрэгжүүлэх үе шатны төлөвлөгөө, 227-240 дэх талд. УБ., 2022.

14	Дугуйн зам	1.9	9.7	7.7	19.3
15	Төмөр зам сүлжээ, өртөө байгууламж	50.0	50.0		100.0
16	Дулаан хангамж	217.6	225.6	175.2	618.4
17	Ус хангамж, ариутгах татуурга	69.1	92.3	376.2	537.6
18	Холбоо	6.7	7.4	17.4	31.5
19	Цахилгаан	128.8	6.8	40.0	175.6
20	Инженерийн бэлтгэл арга хэмжээ	64.5	31.5	102.7	198.6
Нийт хөрөнгө оруулалт		2,885.6	6,194.4	8,736.9	17,771.8
Эзлэх хувь		16%	35%	49%	100%

Энэхүү зардлыг улс, орон нутаг, нийслэл, Шинэ Зуун модын төсөв, төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр ерөнхий зохицуулалттай байх тул төрийн байгууллага болон төсөвт тодорхой хэмжээгээр ачаалал үүсэхээр байна. Гэхдээ хир хэмжээний ачаалал үүсэх талаар тооцоолох боломжгүй байна.

ХОЁР. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг тооцоолохдоо Аргачлалын 3.1-д зааснаар дараах дарааллыг баримтална. Үүнд:

1. иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
2. цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
3. тоон үзүүлэлтийг тооцох;
4. нийт дүнг тооцож гаргах;
5. хялбарчлах боломжийг шалгах.

2.1. Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох

Бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон зайн оновчтой төлөвлөлт бүхий дагуул хот байгуулах зорилтын хүрээнд Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлыг тогтоож, хотын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тогтвортой хөгжлийг дэмжих бодлогыг тодорхойлох зорилго бүхий Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд иргэнд үүрэг болгосон тусгайлсан хэсэг, зүйл байхгүй байна.

Гэхдээ Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 2.3-т “Гүйцэтгэх үүрэг” гэж тухайн хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах этгээд хуульд заасны дагуу тоо баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг хэлнэ гэж тодорхойлсон бөгөөд үүнд бүх төрлийн өргөдөл, хүсэлт, маягт бөглөх, статистик тоо мэдээ өгөх, бүртгүүлэх, нөхөн олговор, төрөөс тусламж, дэмжлэг, зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл гаргах, зөвшөөрөл хүсэх гэх мэт үүргүүд хамаарахаар байна гэж үзэж хуулийн төслийн дараах зохицуулалтыг иргэнд үүрэг болгосон, заавал биелүүлэх үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтад хамааруулан сонгон авлаа.

- 27.2.Хотод үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд нь өмчийн хэлбэрээс үл хамааран хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хотын стандартыг мөрдөх, хотын удирдлагаас хуульд нийцүүлэн гаргасан шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.
- 28.4.Хотын эдэлбэр газар, бүтээн байгуулалтад хохирол учруулсан гэм буруутай этгээд нь Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан

хариуцлага хүлээсэн эсэхээс үл хамааран уг хохирлыг өөрийн хүч хөрөнгөөр арилгах арга хэмжээ авах бөгөөд хэрэв мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн бол үүнтэй холбогдон гарсан зардлыг бүрэн хариуцна. Гэм буруутай этгээд нь төсөл хэрэгжүүлэгч бол төсөл хэрэгжүүлэх эрхийг цуцалж, учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

Өөрөөр хэлбэл, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд зааснаар иргэн:

- Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг зөрчихгүй байх, уг төлөвлөгөөгөөр тогтоосон бүсэд оршин суух гэх мэт;
- Хотын стандартыг дагаж мөрдөх;
- Хотын удирдлагаас гарсан шийдвэрийг дагаж мөрдөх;
- Хотын эдэлбэр газар болон бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд хохирол учруулахгүй байх, саад хийхгүй байх үүрэгтэй байна.

Монгол Улсын нийт хүн амын тоо 2023 оны эцсийн байдлаар 3,504,741 байгаагаас нийслэлд бүртгэлтэй 1,730,263 иргэн байна. Урьдчилсан төлөвлөлтийн хүрээнд Шинэ Зуунмод хот болон эргэн тойрны суурьшлын бүсэд 150,000⁴ орчим иргэн буюу нийслэлд амьдарч буй иргэдийн 8.7%-ийг шилжүүлэн суурьшуулах талаар тооцоо хийгдсэн байна.

2.2. Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох

Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцохдоо зарцуулах цаг хугацааг шаардлагатай мөнгөн дүнгийн хамт гаргана.

Аргачлалын 3.4.3-т заасны дагуу мөнгөн зардлыг тооцохдоо тухайн үүргийг хэрэгжүүлэхэд иргэнээс зайлшгүй гарах мөнгөн зардал буюу бодит, тогтсон зардлыг тооцов. Үүнд: мэдээллийг холбогдох газарт хүргүүлэхэд гарах бичиг хэрэг, шуудангийн зардал, зөвшөөрөл хүсэхэд төлөх хураамж зэргийг оруулсан. Ингэхдээ гүйцэтгэх үүргийг хэрэгжүүлэхэд тухайн иргэнээс гарч болох замын зардлыг тооцохгүй.

Оршин суугч нь төрийн байгууллагад хандан санал, хүсэлтээ илэрхийлэх, хот, нийтийн аж ахуйн болон төрийн үйлчилгээгээр хангагдах тохиолдолд аргачлалын дундаж хугацаагаар тооцсон 10-58 минут зарцуулах, Монгол шуудан ХК-ийн шуудангийн үйлчилгээ ашиглан 1,300 төгрөгийн зардал гаргахаар тооцлоо.

Хүснэгт 11

№	Ерөнхий стандарт үйл ажиллагаа	Гүйцэтгэх хугацаа (минут)
	Хэрэгжүүлэх чиг үүрэг:	
	- Шинэ Зуунмод хотын Захирагчийн шийдвэрийг биелүүлнэ.	
1	Үүрэгтэй танилцах;	3
2	Мэргэжлийн зөвлөгөө авах (холбогдох газраас);	25
3	Мэдээлэл цуглуулах, цуглуулсан мэдээллийг нэгтгэх;	3
4	Цуглуулсан мэдээллээ боловсруулах (нягтлах, тооцоолох, шалгах г.м)	5
Нийт		36
	Үйл ажиллагааны зардал = үйл ажиллагаа х Ажлын хөлс	4,100 төгрөг

⁴ Эх сурвалж: Шинэ Зуунмод хотын ерөнхий төлөвлөгөө

Статистикийн Үндэсний хорооноос гаргасан судалгаагаар иргэний дундаж цалинг 1.2 сая төгрөг гэж үзсэн байна. ⁵ Ажлын 22 хоног, ажлын 8 цагт хуваахад нэг өдрийн цалин 54.5 мянган төгрөг байна. Зарцуулах 36 минутад ногдох зардал 4.1 мянган төгрөг байна.	
---	--

Үүргийг биелүүлэх хугацааг аргачлалын дундаж хугацаагаар тооцов.

2.3. Тоон үзүүлэлтийг тооцох

Аргачлалын 3.5-д заасны дагуу Тоон үзүүлэлтийг тооцох үе шатанд тухайн үүргийг иргэн хэдэн удаа хэрэгжүүлэхийг хуанлийн 1 жилээр тооцож гаргах бөгөөд тоон үзүүлэлтийг тохиолдлын болон давтамжийн тоо ашиглан дараах томъёогоор тооцохоор тусгасан.

$$\text{Тоон үзүүлэлт} = \text{Тохиолдлын тоо} \times \text{Давтамжийн тоо}$$

Тохиолдлын болон давтамжийн тоог тогтоохдоо хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах этгээдийн гүйцэтгэх үүрэг нэг бүрийг тогтооно. Гүйцэтгэх үүрэг гэж тухайн хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах этгээд хуульд заасны дагуу тоо баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг хэлнэ.

Энэхүү үүргийн дагуу хүргүүлж байгаа мэдээлэл нь нэг буюу хэд хэдэн мэдээллийн агуулгаас бүрдэнэ. Мэдээллийн агуулга гэж тухайн этгээдээс төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх бүх тоон мэдээлэл, бичиг баримтын бүрдлийг ойлгох бөгөөд агуулга бүр нь үүрэгтэйгээ нийцэж байх ёстой.

Хуулийн төслийн иргэнд хүлээлгэж буй үүргийг хэрэгжүүлэх тоон үзүүлэлтийг дараах бүдүүвчийн дагуу тооцов.

Хүснэгт 12

№	Ерөнхий стандарт үйл ажиллагаа	Тоон үзүүлэлт
	Хэрэгжүүлэх чиг үүрэг:	
	Шинэ Зуунмод хотын Захирагчийн шийдвэрийг биелүүлэх.	
	Тоон үзүүлэлт= Тохиолдлын тоо х Давтамжийн тоо Бүсийн захирагчаас жилд дунджаар 5 удаагийн үүрэг өгнө гэж тооцвол $5 \times 1 = 5$	5 удаа

2.4. Нийт дүнг тооцож гаргах

Аргачлалын 3.6-д заасны дагуу нийт дүнг тооцож гаргах үе шатанд тухайн үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан иргэнд үүсэх ачааллыг тооцож гаргах бөгөөд иргэнд үүсэх ачаалал нь цаг хугацааг тоон үзүүлэлтээр үржүүлснээр тодорхойлогдоно.

$$\text{Ачаалал} = \text{Цаг хугацаа} \times \text{Тоон үзүүлэлт}$$

Хүснэгт 13

№	Ерөнхий стандарт үйл ажиллагаа	Ачаалал
	Хэрэгжүүлэх чиг үүрэг:	

⁵ https://www.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Dundaj_tsalin_2020_Q1.pdf&In=Mn

1.	Шинэ Зуунмод хотын Захирагчийн шийдвэрийг биелүүлнэ.	180 минут
	Захирагчаас жилд дунджаар 5 удаагийн үүрэг, даалгавар гарна гэж тооцсон бөгөөд үүрэг, даалгаврыг биелүүлэхэд 36 минут зарцуулна гэж тооцсон.	
2.	Дагуул хотын удирдлагын гаргасан шийдвэрийг биелүүлэх	180 минут
	Дагуул хотын удирдлагаас нэг жилд нийтээр дагаж мөрдүүлэхээр хэм хэмжээ тогтоосон 5 акт гаргана гэж тооцсон бөгөөд үүргийг хэрэгжүүлэхэд 36 минут зарцуулна гэж тооцов.	
	Нийт	360 минут буюу 6 цаг

2.5.Хялбарчлах боломжийг шалгах

Аргачлалын 3.7-д заасны дагуу хялбарчлах боломжийг шалгах үе шатанд энэхүү аргачлалын 2.7-д заасантай нэгэн адил арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

2.7.Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана.

Хүснэгт 14

№	Хэрэгжүүлэх чиг үүрэг /Ажил, үйлчилгээ/	Тайлбар
1	Шинэ Зуунмод хотын Захирагчийн шийдвэрийг биелүүлнэ.	Иргэд дагуул хотын удирдлагын шийдвэрийн талаар мэдээлэл авах, санал өгөхдөө хотын захиргааны цахим хуудсаар, гар утасны аппликэйшн, фэйсбүүк, твитер хуудас, гэрт ойр байрлах хотын үйлчилгээний төвүүд, өөрийн оршин суух хороогоор болон нийтийн сонсголд оролцох, хотын удирдлагатай биечлэн уулзах зэргээр мэдээлэл авах, санал хүсэлтээ илэрхийлэх боломжтой байгаа тул дээрх шуудангийн зардлыг гаргахгүй цахим шуудан, фэйсбүүк, факсаар явуулах зэргээр уг зардлыг хэмнэх боломжтой байна. Мөн санал, хүсэлтийг биечлэн хүргэж өгөхөөр бол аргачлалд заасны дагуу унааны зардлыг тооцохгүй.
2	Дагуул хотын удирдлагын гаргасан хэм хэмжээ тогтоосон дүрэм, журмыг биелүүлэх	
3	Дагуул хотод зорчигч этгээд энэ хууль, бусад хууль тогтоомж, дагуул хотын удирдлагаас гаргасан шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.	

ГУРАВ.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

Энэ хэсэгт Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана. Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох;
2. Зардлыг тооцох;
3. Тоон үзүүлэлтийг тооцох;
4. Нийт зардлын дүнг тооцож гаргах;
5. Хялбарчлах боломжийг ашиглах;
6. Нэмэлт зардлыг тооцох.

3.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох

Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоохдоо хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг нэг бүрийг тогтооно. Гүйцэтгэх үүрэг гэж тухайн хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд хуульд заасны дагуу тоо баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг хэлнэ.

Хуулийн төсөлд хуулийн этгээдэд үүрэг болгосон тусгайлсан бүлэг, зүйл, ххэсэг, заалт байхгүй боловч дараахи зохицуулалтуудыг хуулийн этгээдэд үүрэг болгосон зохицуулалт байна гэж үзэж сонгон авч тооцоо хийлээ.

- Хотын Захирагчийн шийдвэрийг биелүүлэх;
- хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хотын стандартыг мөрдөх;
- хотын зөвлөлөөс батлан гаргасан хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг биелүүлэх.

3.2.Зардлыг тооцох

Зардлыг тооцон гаргахдаа тухайн үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаа нэг бүрийг ямар хугацаанд хийж гүйцэтгэхийг дунджаар гаргасан стандарт хугацааг ашиглав.

Хүснэгт 15

№	Чиг үүрэг	Хийгдэх ажиллагаа	Дундаж хугацаа /минут/
1	Хотын Захирагчийн шийдвэрийг биелүүлнэ	Үүрэгтэй танилцах, судлах	15
		Мэдээлэл цуглуулах	15
		Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх	7
		Тооцоо хийх	20
		Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	5
		Алдааг засах	10
		Тоо баримтыг боловсруулах	15
		Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх	2
		Дотоод хуралдаан (зөвлөгөөн)	30
		Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөгөөн)	60
		Мөнгө шилжүүлэх үүрэг хэрэгжүүлэх	8
		Олшруулах, архивлах, тараах	5

	Төрийн захиргааны байгууллагаас шалгах	30
	Төрийн захиргааны байгууллагын шалгалтын дүнгээс үүдэлтэй засвар, өөрчлөлт	90
	Холбогдох байгууллагатай харилцахад хүндрэл үүссэнээс үүдэн мэдээлэл нэмж цуглуулах	15
	Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	15
	Зарцуулах нийт хугацаа	342

Ажлын хөлс=Үндсэн цалин*Ажиллах хугацаа

Ажлын хөлс= 1,269,100*0.7125 хоног=904,233 төгрөг

Хүснэгт 16

Д/д	Салбараар	Дундаж цалин /мянган төг/
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1,769
2	Уул уурхай, олборлолт	5,125.6
3	Боловсруулах үйлдвэрлэл	2,029.2
4	Цахилгаан, хий, агааржуулалт	2,575.7
5	Ус хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	1,779.2
6	Барилга	2,019.8
7	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	1,699.3
8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2,419
9	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1,366.3
10	Мэдээлэл, холбоо	2,299.5
11	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2,525.9
12	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	2,287.6
13	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2,617.4
14	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1,883.2
15	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2,333.6
16	Боловсрол	1,882.4
17	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	2,121.8
18	Урлаг, үзвэр, тоглоом, наадам	1,862.1
19	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1,904.7
20	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	2,073.5
21	Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	4,995.8
	Улсын дундаж	2,235.4

Статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас 2023 оны 4 дүгээр улирлын мэдээг авч ашиглав.

Хүснэгт 17

№	Чиг үүрэг	Хийгдэх ажиллагаа	Дундаж хугацаа
1	хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хотын стандартыг мөрдөх	Үүрэгтэй танилцах, судлах	15
		Мэдээлэл цуглуулах	15
		Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх	7
		Тооцоо хийх	20
		Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	5
		Алдааг засах	10
		Тоо баримтыг боловсруулах	15
		Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх	2
		Дотоод хуралдаан (зөвлөгөөн)	30

	Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөгөөн)	60
	Мөнгө шилжүүлэх үүрэг хэрэгжүүлэх	8
	Олшруулах, архивлах, тараах	5
	Төрийн захиргааны байгууллагаас шалгах	30
	Төрийн захиргааны байгууллагын шалгалтын дүнгээс үүдэлтэй засвар, өөрчлөлт	90
	Холбогдох байгууллагатай харилцахад хүндрэл үүссэнээс үүдэн мэдээлэл нэмж цуглуулах	15
	Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	15
Зарцуулах нийт хугацаа		342

Ажлын хөлс=Үндсэн цалин*Ажиллах хугацаа

Ажлын хөлс= 1,269,100*0.7125хоног=904,233 төгрөг

Хүснэгт 18

№	Чиг үүрэг	Хийгдэх ажиллагаа	Дундаж хугацаа /минут/
1	хотын зөвлөлөөс батлан гаргасан хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг биелүүлэх	Үүрэгтэй танилцах, судлах	15
		Мэдээлэл цуглуулах	15
		Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх	7
		Тооцоо хийх	20
		Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	5
		Алдааг засах	10
		Тоо баримтыг боловсруулах	15
		Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх	2
		Дотоод хуралдаан (зөвлөгөөн)	30
		Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөгөөн)	60
		Мөнгө шилжүүлэх үүрэг хэрэгжүүлэх	8
		Олшруулах, архивлах, тараах	5
		Төрийн захиргааны байгууллагаас шалгах	30
		Төрийн захиргааны байгууллагын шалгалтын дүнгээс үүдэлтэй засвар, өөрчлөлт	90
		Холбогдох байгууллагатай харилцахад хүндрэл үүссэнээс үүдэн мэдээлэл нэмж цуглуулах	15
		Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	15
Зарцуулах нийт хугацаа		342	

Ажлын хөлс=Үндсэн цалин*Ажиллах хугацаа

Ажлын хөлс= 1,269,100*0.7125 хоног=904,233 төгрөг байхаар тооцов.

Нийт зардлын дүн=904,233*3=2,712,699

3.3.Тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлт=Тохиолдлын тоо*Давтамж тоо

Тохиолдлын тоо нь тухайн үүргийг нийт хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг харуулдаг бол давтамжийн тоо нь тухайн үүргийг хуулийн этгээд 1 жилд хэдэн удаа хэрэгжүүлэхийг харуулна.

Хүснэгт 19⁶

№	Өмчийн хэлбэр	Статистик тоо
1	Төрийн болон орон нутгийн өмчийн	1,390
2	Монгол Улсын иргэний хувийн	64,166
3	Хувийн гадаадтай хамтарсан	567
4	Гадаад улсын	2,252
Нийт тоон үзүүлэлт		68,375

Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.2-т зааснаар хуулийн этгээдэд компани, нөхөрлөл, холбоо, сан, хоршоог хамааруулав.

Хүснэгт 20

№	Чиг үүрэг	Давтамж тоо/жилд
1	Шинэ Зуунмод хотын Захирагчийн өгсөн үүргийг биелүүлэх;	жилд 2 удаа
2	Дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хотын стандартыг мөрдөх;	жилд 2 удаа
3	Дагуул хотын удирдлагаас хуульд нийцүүлэн гаргасан шийдвэрийг биелүүлэх.	жилд 2 удаа

Тоон үзүүлэлт= Тохиолдлын тоо*Давтамж тоо

Тоон үзүүлэлт=88,602*2=177,204

3.4. Нийт зардлын дүнг тооцож гаргах

Нийт зардал=Зардал*Тоон үзүүлэлт

Нийт зардал=2,712,699*177,204=480,701,114

3.5. Хялбарчлах боломжийг ашиглах

Аргачлалын 2.7.1-д заасны дагуу хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэхийг тодорхойлбол:

- Энэ тохиолдолд хуулийн этгээдийн тоог багасгах боломжгүй байна. Учир нь дээрх аж ахуйн нэгжийн явуулж байгаа үйл ажиллагаа нь нийслэл хотын хүн амын төвлөрөл, иргэдийн эрэлт хэрэгцээнээс шалтгаалан цаашид нэмэгдэх хандлагатай байна.

Аргачлалын 2.7.2-д заасны дагуу мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэхийг тодруулбал:

- Хуулийн этгээдэд мэдээллийг хүргэх давтамжийг багасгах боломж байна гэж үзэж байна. Учир нь орчин үед цахимаар мэдээллийг хүлээн авах, тайлан өгөх боломж улам бүр нэмэгдэж байгаа тул цаашид энэ төрлийн зардлыг бууруулах боломжтой байна.

Аргачлалын 2.7.3-д заасны дагуу мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэхийг тодруулбал:

- Мэдээллийн агуулгыг багасгах боломж одоохондоо хараахан бүрдээгүй байна. Учир нь одоогийн мэдээлэл нь зорилгодоо нийцсэн мэдээлэл байна гэж үзэж байна.

Аргачлалын 2.7.4-д заасанчлан шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх:

⁶ Эх сурвалж: Статистикийн нэгдсэн мэдээллийн сангаас 2023.04 дүгээр улирлын байдлаар.

- Шинээр үүсэх үүрэг харьцангуй бага тул энэ тал дээр өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзлээ.

Аргачлалын 2.7.5-д заасны дагуу мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх:

- Технологийн хөгжлийн эрин үед амьдарч байгаа энэ цаг үед мэдээллийг цахимаар хүргэх боломж улам бүр нэмэгдэж байна. Иймд цаашдаа аж ахуйн нэгжийн мэдээлэл дээр үндэслэн дата бааз үүсгэн мэдээллийг нэгэн зэрэг хурдан шуурхай, найдвартай хүргэх боломжтой юм. Ингэснээр хүн хүч, техник, цаас, цаг хугацааны зардал хэмнэх боломжтой байна.

Аргачлалын 2.7.6-д заасанчлан мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх:

- Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой. Ингэснээр мэдээлэл хүргэх зардал, цаг хугацааг хэмнэх боломжтой байна.

Аргачлалын 2.7.7-д заасан нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой эсэх:

- Дээр дурдсан үйлчилгээнүүдийн зарим нь нэг цэгийн үйлчилгээгээр дамжин иргэдийн цаг, мөнгийг хэмнэж байгаа болно. Цаашид илүү олон үйлчилгээг нэг цэгийн үйлчилгээгээр иргэдэд хүргэх боломжтой гэж дүгнэлээ.

3.6.Нэмэлт зардлыг тооцох

Нэмэлт зардал=Бусад зардал*Тоон үзүүлэлт

Хууль батлагдсанаар нэмэлт зардал гарах эсэх нь тодорхойгүй тул тооцох шаардлагагүй гэж үзлээ.

Хуулийн төсөлд хуулийн этгээдэд үүрэг болгосон зохицуулалтаас илүү боломж олгосон, үйл ажиллагааг нь баталгааг нь хангасан шинэлэг зохицуулалтууд оруулсан байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Аргачлалын дагуу төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэний үүсэх зардлыг тэдгээрийн гүйцэтгэх үүрэг, зарцуулах цаг хугацаа болон гарч болох зардал, тоон үзүүлэлт, нийт дүнг тооцох, хялбарчлах боломжийг шалгах гэсэн дарааллаар тус бүр тооцов.

Төрийн байгууллагын зардлыг тооцох аргачлалын 4.3.2-т “байгууллагыг сонгохдоо тухайн ажил, үйлчилгээнд хамааралтай бүх байгууллагыг биш голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгоно” гэж заасны дагуу холбогдох байгууллагуудыг сонгон тэдгээрийн гүйцэтгэх үүрэг, зарцуулах хугацаа, холбогдох зардлыг тус бүрт нь тооцсон.

Хууль батлагдсанаар Шинэ Зуунмод хот дагуул хот байгуулсан тохиолдолд ажлын албанд ажиллах албан тушаалтнуудын цалин, хэрэглэх тавилга, тоног төхөөрөмжийн зардал нэмэгдэхээр байна. Гэвч энэ хуулийн төсөлд үндэслэн шууд дагуул хотын удирдлага, ажлын алба ажиллаж эхлэхгүй бөгөөд байгуулах шийдвэрийг Улсын Их Хурал гаргахаар тусгасан.

Дагуул хот байгуулахад судалгааны 1 дүгээр хэсэгт дурдсан Засгийн газрын тогтоолоор батлагдсан төрийн албан хаагчийн цалингийн сүлжээгээр нэг ажилтны зардалд дунджаар нэг сард 1,902,800 төгрөг, нэг жилд 22,833,600 төгрөгийн цалин, тавилга тоног төхөөрөмжид нэг жилд 830,000 төгрөг зарцуулах тооцоо гаргасан боловч энэ нь уг хуулийн төсөлд шууд холбогдох зардал гэж үзэх боломжгүй юм.

Мөн дээр дурдсан зардлуудаас гадна Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтад 17.7 их наяд төгрөг зарцуулах тоцоолол хийгдсэн байх ба 2025-2040 онд 3 үе шатаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь улс, орон нутаг, нийслэл, Шинэ Зуун модын төсөвт тодорхой хэмжээгээр ачаалал үүсэхээр байна. Гэхдээ хир хэмжээний ачаалал үүсэх талаар тооцоолох боломжгүй байна.

Хуулийн этгээдийн зардлыг тооцохдоо Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.2-т зааснаар хуулийн этгээдэд компани, нөхөрлөл, холбоо, сан, хоршоог хамааруулан авч үзэв.

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар нийслэлд бүртгэлтэй 172,159 аж ахуйн нэгж, үүнээс 68,375 хуулийн этгээд үйл ажиллагаа идэвхтэй явуулж байгаа бол Төв аймгийн Зуунмод суманд бүртгэлтэй 941 ААНБ байгаагаас тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа 393 ААНБ байгаа нь тус аймгийн хэмжээнд бүртгэлтэй нийт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын 41.8%-ийг эзэлж байна. Харин Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт 78 ААНБ бүртгэлтэй байгаагийн 36 нь үйл ажиллагаа явуулж байгаа бол Алтанбулаг суманд 65 ААНБ бүртгэгдсэнээс 30 ААНБ үйл ажиллагаа явуулж байна.⁷

2023 оны IV дүгээр улирлын байдлаар							
БҮС	ААНБ нийт	Хувь		ААНБ үйл ажиллагаа явуулж байгаа	Хувь		Хэдэн хувь нь үйл ажиллагаа явуулж байна вэ?
Улсын дүн	234,519			96,815			41.3
Төв аймаг	3,116	1.3	Улсын	1,267	1.3	Улсын	40.7
Алтанбулаг	65	2.1	Төв аймгийн	30	2.4	Төв аймгийн	46.2
Зуунмод	941	30.2	Төв аймгийн	393	31.0	Төв аймгийн	41.8
Сэргэлэн	78	2.5	Төв аймгийн	36	2.8	Төв аймгийн	46.2

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

⁷ Үндэсний статистикийн хорооны 2023 оны 4 дүгээр улирлын тоон мэдээ.

Шинэ Зуунмод хотод хамаарагдах ААНБ-ын тоог ойролцоогоор Нийслэл болон Төв аймгийн Зуунмод суманд үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн 30%, Сэргэлэн, Алтанбулаг суманд үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын 40%-иар тус тус тооцож, нийт 20,657 хуулийн этгээд байхаар төсөөлж, Шинэ Зуунмод хотын удирдлагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, хуульд заасан хүрээнд дэмжлэг үзүүлэх, шийдвэрийг биелүүлэх зэрэгт аргачлалд дурдсан дундаж хугацаагаар тооцоход 342 минут буюу 5 цаг 42 минут зарцуулах тооцоолол гаргасан болно. Аргачлалын 2.7-д дурдсаны дагуу хялбарчлах боломжийг шалгахад мэдээллийг цахимаар хүргэж, цаг хугацаа, зардлыг хэмнэх боломжтой гэсэн дүгнэлтийг гаргасан. Энэхүү хууль батлагдсанаар хуулийн этгээдийн хувьд нэмэлт зардал гарахгүй болно.

Хуулийн төсөлд хуулийн этгээдэд үүрэг болгосон зохицуулалтаас илүү боломж олгосон, үйл ажиллагааг нь баталгааг нь хангасан шинэлэг зохицуулалтууд оруулсан байна.

Тус хуулийн төсөлд иргэн хотын удирдлагад санал, хүсэлтээ хүргүүлэх, үйлчилгээ авах, үүргээ биелүүлэх хугацааг аргачлалын дунджаар тооцоход 10-58 минут зарцуулах, "Монгол шуудан" ХК-ийн шуудангаар нийслэлийн удирдлагад санал, хүсэлтээ хүргүүлбэл дунджаар 1300 төгрөгийн зардал гаргахаар тус тус тооцсон. Мөн аргачлалд дурдсан хялбарчлах боломжийг шалгахад дээрх шуудангийн зардлыг гаргахгүй байх боломжтой байна. Мөн аргачлалд санал, хүсэлтээ илэрхийлэхээр биечлэн очсон тохиолдолд унааны зардлыг тооцохгүй байхаар тусгасан.

Дээрх бүгдээс Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг баталснаар төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэнд чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой нэмэлт зардал, ачаалал стандартаас илүү хэмжээгээр үүсэхгүй гэж дүгнэлээ. Харин шинэ хотын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхтэй холбоотойгоор улсын болон орон нутаг, нийслэл, хотын төсөвт нэмэлт ачаалал үүсэхээр байгаа боловч түүнийг нарийвчлан тооцох боломжгүй байна.

ТАВ.АШИГЛАСАН МАТЕРИАЛ**Хууль:**

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн мэдээлэл, 2021, №7;
2. Иргэний хууль, Төрийн мэдээлэл, 2002, №7;
3. Хөдөлмөрийн хууль, Төрийн мэдээлэл, 1999, №25;
4. Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл, 2015, №25;
5. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн мэдээлэл, 2021, №35

Засгийн газрын тогтоол:

1. Засгийн газрын 2022 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”;
2. Засгийн газрын 2023 оны Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтох тухай 241 дүгээр тогтоол;
3. Засгийн газрын 2022 оны Төрийн захиргааны албан тушаалын ангилал зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг батлах тухай 487 дугаар тогтоол;
4. Засгийн газрын 2016 оны Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал батлах тухай 59 дүгээр тогтоол.

Цахим хуудас:

1. www.legalinfo.mn;
2. www.ulaanbaatar.mn;
3. www.google.mn;
4. www.1212.mn /Статистикийн үндэсний хороо/;
5. ubservice.mn /Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба/;
6. ubstat.mn /Хүн амын талаарх тоон мэдээлэл/;
7. <http://mongolpost.mn/service/cat/3/8>;
8. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан;

---oOo---

ШИНЭ ЗУУНМОД ХОТЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН МЭДЭЭ

2024.04.30

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг цахимаар болон танхимаар хэлэлцүүлж иргэд, олон нийт, мэргэжлийн байгууллагаас санал авсан. Үүнд:

1.Хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төслийг 2024 оны 03 сарын 21-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын <https://ulaanbaatar.mn>, Нийслэлийн дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газрын <https://www.scez.ub.gov.mn>, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны <https://www.khfez.com> цахим хуудсуудад байршуулан олон нийтээс санал авсан.

2.Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн агуулгыг мэргэжлийн байгууллага, иргэд, олон нийт, судлаачдын дунд танхимаар 4 удаа хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Д/д	Хэлэлцүүлэг			Саналын тоо
	Зохион байгуулсан огноо, газар	Оролцогч этгээд	Оролцогчдын тоо	
1	2024.03.07 Улаанбаатар-Бүсчилсэн хөгжил форумын урьдчилсан хэлэлцүүлэг /Гадаад харилцааны яам/	УИХ-ын болон Засгийн газрын гишүүд, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшил, гадаадын мэргэжилтэн, судлаач	120	36
2	2024.03.28	Хот байгуулалтын салбарын мэргэжилтнүүд, архитектор,	18	12
3	2024.03.14 Улаанбаатар-Бүсчилсэн хөгжил форумын /Төрийн ордон/	УИХ-ын болон Засгийн газрын гишүүд, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, НӨУБ, хувийн хэвшил, гадаадын мэргэжилтэн, судлаач	890	46
4	2024.04.12 Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	Бизнес эрхлэгч, хувийн хэвшлийн ААНБ Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын гишүүн байгууллагууд	42	14
Нийт			1070	108

Хэлэлцүүлгийн үед гарсан саналуудыг нэгтгэж үзвэл дараах асуудлуудыг хуулийн төсөлд тусгах санал нийтлэг гарсан байна. Үүнд:

- хот төсөвтэй байх;
- шинэ хотыг анхнаас нь зөв төлөвлөж, төлөвлөлтийн дагуу бүтээн байгуулах, хөгжүүлэх;

- хотын удирдлага буюу хотын Зөвлөл, Захирагчийг оршин суугчдаас нь сонгодог байх;
- хүнд зориулсан хот байх, хүн очоод амьдрах нийгмийн дэд бүтцийг эхний ээлжинд барьж байгуулсан байх;
- хөрөнгө оруулагчдад ээлтэй байх, хөнгөлөлт, чөлөөлөлт тодорхой байх;
- гадаадын ажиллах хүчинд хатуу шаардлага тавихгүй байх;
- олон улсын санхүүгийн төвүүдийг байгуулагдах нөхцөлийг бүрдүүлсэн байх;
- хот байгуулах зорилго, чиглэлээ тодорхой болгох, Улаанбаатар хотын түгжрэл, төвлөрлийг бууруулахад чиглэх үү? Эсхүл хөрөнгө оруулалт татах гээд байна уу? Үүнийг ялгаж холбогдох зохицуулалтыг хийх;
- иргэд, аж ахуйн нэгжийг татахын тулд төр, төрийн байгууллага манлайлж, эхэлж шилжин байрших;
- оршин суугчдын оролцоог дэмжих, тэдний эрх, үүргийг өргөжүүлэх гэх мэт.

Эдгээр саналыг харгалзан үзэж, хуулийн болон дагалдах хуулийн төслүүдэд тусгасан болно.

АЖЛЫН ХЭСЭГ

**АЖЛЫН ДЭД ХЭСЭГТ ОРОХ
АЛБАН ТУШААЛТНЫ НЭРС**

Д/д	Албан тушаал	Нэр	Утас
1.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч	Х.Нямбаатар	
2.	Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч	П.Сайнзориг	88110079
3.	Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч	О.Номинчимэг	99998326
4.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга	Л.Хосбаяр	88040004
5.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх	Д.Цолмон	88101375
6.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын дарга	Д.Амгалан	99070489
7.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Өрийн удирдлагын тасгийн дарга	Л.Эрдэнэбадрах	99090549
8.	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн дарга (Ерөнхий инженер)	М.Балдандорж	99068748
9.	Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний төвийн дарга	Р.Дагва	99116727
10.	Хан-Уул дүүргийн Засаг дарга	Ж.Алдаржавхлан	99119003
11.	Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын дарга	Г.Батзориг	88884272
12.	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга	Г.Мөнхбаатар	99053872
13.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч	Б.Төрбат	88007383
14.	Барилга, хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот байгуулалтын газрын ахлах шинжээч	Д.Билэгсайхан	99798665
15.	Эдийн засгийн хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга	Д.Эрдэнэбаяр	99097578
16.	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	М.Санжаадорж	
17.	Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга	Б.Тэлмүүн	
18.	Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга	М.Батбаяр	99103966
19.	Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Ерөнхий менежер	Б.Гүнболд	98098098

20.	Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах хорооны Ажлын албаны дарга	Д.Баярдорж	99085013
21.	Ажлын албаны төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч	Ц.Батгэрэл	91114290
22.	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын мэргэжилтэн	С.Энхжаргал	99090580
23.	Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн	М.Уранбилэг	99800505
24.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах мэргэжилтэн	Б.Төгслхам	99087148
25.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн	Д.Баялагцэнгэл	99078106